




МОНГОЛБАНК

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

**УЛААНБААТАР
2012 ОН**



ГАРЧИГ

I.	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	6
II.	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААРХИ 2012 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛ.....	25
III.	ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА.....	37
3.1	ДОТООД МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ	37
3.1.1	Эдийн засгийн өсөлт	37
3.1.2	Инфляци, түүний өөрчлөлт.....	41
3.1.3	Инфляци, эдийн засгийн өсөлтийн 2012-2013 оны төсөөлөл.....	43
3.1.4	Мөнгөний нийлүүлэлт, түүний өөрчлөлтийн шалтгаан	49
3.1.5	Зээл.....	55
3.1.6	Зээлийн хүү.....	57
3.1.7	Төгрөгийн гадаад валюттай харьцах ханийн хэлбэлзэл, гадаад валютын урсгал	58
3.1.8	Монгол улсын гадаад секторын тойм (2012 оны 8 дугаар сарын байдлаар)	60
3.1.9	Санхүүгийн салбарын тогтвортой байдал	69
3.1.10	Монгол улсын төсөв	83
3.2	ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	85



ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрөөс мөнгөний бодлогын
талаар 2013 онд баримтлах
үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт,
Төв банк (Монголбанкны)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг олон нийтэд тогтмол тайлгнах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд тус тус даалгасугай.
3. Иргэдийн өргөн хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авч, үнийг тогтвожуулах цогц механизм боловсруулж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал)-нд даалгасугай.
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон бусад шаардлагатай хууль тогтоомжийг олон улсын холбогдох стандартад нийцүүлж, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас тогтоосон Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал)-нд даалгасугай.
5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд тус тус даалгасугай.
6. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо (Б.Гарамгайбаатар)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын
2012 оны ... дугаар тогтоолын
хавсралт

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхд мөнгөний бодлогыг чиглүүлнэ.

1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

- 1.1 Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Үүний үр дунд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2013 оны эцэст 8 хувиас хэтрүүлэхгүй байж, улмаар 2014-2015 онд инфляцийг 5-7 хувийн түвшинд байлгах нөхцөл бүрдүүлнэ.
- 1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.
- 1.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үндсэн зорилтын хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах замаар Төв банкны хариуцлагыг сайжруулна.

2. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

- 2.1 Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлнэ.
- 2.2 Олон улсад мөрдөгдөж буй хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.
- 2.3 Банкны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчилнэ.

3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

- 3.1 Төрөөс мөнгөн хадгаламжид гаргах баталгааг хязгаарлагдмал хадгаламжийн

даатгалын тогтолцоонд шилжүүлснээр төрд учрах эрсдэлийг бууруулж, банкны салбарын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлнэ.

- 3.2 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2013-2015 онд эрчимжүүлэх ажлын хүрээнд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, боловсронгуй болгоно.
- 3.3 Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлэх олон улсын жишигт суурисан аргачлалыг нэвтрүүлж эхэнэ. Банк санхүүгийн үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй болгох, иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилана.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Гадаад эдийн засгийн таагүй нөлөөгөөр 2012 онд манай улсын экспортын эрэлт болон үнэ буурч, гадаад валютын дотогшлох урсгал багасан, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс эдийн засгийн өсөлт саарч байна. Үүний дунд санхүүгийн зуучлал хумигдаж эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, 2012 оны эхний улиралд 16.5%-иар өссөн дотоод эдийн засгийн идэвхжил нь гадаад эрэлт буурсан, Таван толгой төслийн бүтээн байгуулалтын ажил төлөвлөсөн хугацаанд хийгдээгүй, төсвийн зардал 30 орчим хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа зэргээс шалтгаалж 2 дугаар улиралд 11% болж саарв.

2012 он гарсаар дэлхийн эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж, Евро бүсийн өрийн хямрал гүнзгийрсэн нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж, тэр дундаа Хятадын аж үйлдвэрийн салбарт сөргөөр нөлөөлж суурь металл, аж үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн эрэлтийг бууруулаад байна. Түүхий эдийн эрэлтийг дагаад манай улсын экспортын гол бүтээгдэхүүнүүд болох нүүрс, төмрийн хүдэр, цайр зэрэг түүхий эдийн үнэ буурч, зэсийн үнэ ихээхэн тогтвортгүй байна. Ойрын хугацаанд Евро бүсийн өрийн хямрал, АНУ-ын төсвийн хүндрэл арилахааргүй байгаагаас дэлхийн эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч, Хятадын эдийн засгийн өсөлт удаашрах, улмаар энэ нь түүхий эдийн эрэлт, үнэ буурах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хөрөнгийн цэвэр дотогшлох урсгал тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 оны эхний 7-н сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 883 сая ам.доллараар буюу 31%-иар буурсан байна. 2010 оноос хойш анх удаа гадаадын шууд хөрөнгө оруулалт ийнхүү буурсан нь гадаад эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэнээс гадна сонгуулийн жилийн онцлог, Монгол улсын хөрөнгө оруулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс шалтгаалжээ. Түүнчлэн гадаад худалдааны алдагдал 2012 оны 8 дугаар сарын байдлаар 1.79 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 37.3 нэгж хувиар нэмэгдсэн байна. Ийнхүү валutyын дотогшлох урсгал нь урсгал данс болон хөрөнгө санхүүгийн дансны аль алинаар нь саарч байна.

Гадаад секторын тааламжгүй нөхцөл байдал нь төгрөгийн нэрлэсэн ханш сулрах үндсэн шалтгаан болж байна. 2012 оны эхний 8-н сарын байдлаар Монголбанк ханшийн сулралтын огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор гадаад валютын интервенци хийж, цэвэр дүнгээрээ 856 тэрбум төгрөгийг банк хоорондын захаас татаад байна. Ийнхүү эдийн засгийн суурь хүчин зүйлсээ даган өөрчлөгдөж буй валютын ханшийг харьцангуй тогтвортой байлгах зорилгоор хэрэгжүүлж буй ханшийн бодлого нь банкны системийн төгрөгийн эх үүсвэрийг хомсдуулж, санхүүгийн зуучлалын хүртээмжийг бууруулах давхар нөлөөг үзүүлж байна.

Хэдийгээр 2011 онд мал сүргийн тоо толгой 36.3 саяд хүрч¹ өмнөх оноос 11 хувиар өсөн, нөөцийн махны хэмжээг нэмж 16 мянган тонн болгосон ч 2012 онд махны үнэ өсч түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрсэн. Тухайлбал, 2012 оны эхний 8-н сарын турш жилийн инфляцийн 50 гаруй хувийг махны үнийн өсөлт дангаар бүрдүүлсэн байна. Энэ нь УИХ-ын тогтоолын “Гол нэрийн хүнсний барааны нийлүүлэлтийн тогтвортой, найдвартай тогтолцоо бий болгох” заалтыг хэрэгжүүлэх Засгийн газрын бодлого үр дүн муутай байсныг илтгэж байна. Ирэх хавар махны хомсдол үүсч, үнэ нь огцом өсөхөөс сэргийлж Засгийн газрын зүгээс махны нөөц бүрдүүлэхэд анхаараад зогсохгүй түүнийг зах зээлд нийлүүлэх үр ашигтай механизм, дэд бүтэц бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Цаашид Засгийн газар нийгмийн хalamжийн бодлого, тэр дундаа мөнгөн тэтгэмжийг хавтгайруулан олгох нь махны нийлүүлэлтийн найдвартай байдлыг хангах бодлогод сөргөөр нөлөөлж буйг анхаарч үзэх нь зүйтэй.

2012 оны эхний 8-н сарын байдлаар төсвийн зарлагын гүйцэтгэл 71 хувь, орлогын гүйцэтгэл 83 хувийн биелэлттэй, төсвийн алдагдал 483 тэрбум төгрөгт хүрсэн байна. Төсвийн алдагдлын 63.5%-ийг зээл, бондоор санхүүжүүлэхдээ халамжийн зардал, тэр дундаа мөнгөн тэтгэмжийг санхүүжүүлсэн нь эдийн засагт эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг нэмэгдүүлснээс гадна хэрэглээний импортыг тэтгэн, нэрлэсэн ханш суурх дарамтыг нэмэгдүүлэх нөлөөллийг бий болгож байна.

Эдийн засгийн өндөр идэвхжил, махны үнийн өсөлтөөс шалтгаалж эхний хагас жилд эрчимжиж байсан инфляци 7 дугаар сараас хойш буурах хандлагатай байна. Тухайлбал, жилээр тооцсон инфляци 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 15.6%-д хүрсэн нь энэ оны зорилtot түвшнээс өндөр байгаа хэдий ч хүнс, шатахууныг хасч тооцсон суурь инфляци 11.1% байна. Энэ нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурч буйг илтгэнэ. Түүнээс гадна нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн дарамт энэ оны суулийн хагас жилд буурахаар байгаа тул оны эцэст инфляци зорилtot түвшинд ойрхон гарахаар байна.

Төсвийн төлөв, махны үнийн хэлбэлзэл болон төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь 2013 оны инфляцид нөлөөлөх гол хүчин зүйлс хэвээр байхаар байна. 2013 оны 1 дүгээр сараас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн бодлого мөчлөг сөрсөн хэлбэрээр хэрэгжиж эхлэх тул инфляцид үзүүлэх дарамт бага байх боломж бүрдэнэ. Харин төгрөгийн нэрлэсэн ханшийн хувьд суурх дарамт 2013 оны эхний хагас хүртэл өндөр хэвээр байж болзошгүй. Эдгээр хүчин зүйлс нь инфляцийн төлвийг тодорхойлохоос гадна инфляцийн төсөөллийн тодорхой бус байдлыг бий болгож байна. Үүний зэрэгцээ төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн тодорхой бус байдал нь инфляцийн эрсдэлийн нэг чухал хүчин зүйл юм.

¹ YCX-ны “МУ-ын Статистикийн эмхэтгэл 2011” 207-р хуудас

Банкны салбарын зээлийн өсөлт 2013 онд үргэлжлэн саарч болзошгүй байна. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтийг хязгаарлах, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага байхад эерэгээр нөлөөлөх хэдий ч, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Түүнчлэн нийслэлийн захиргаанаас Улаанбаатар хотын “А” зэрэглэлийн бүсэд дэд бүтцээс бусад зориулалтаар газар олгохгүй байх шийдвэр гаргасан нь тус бус дэх үл хөдлөх хөрөнгийн үнийг цаашид өсгөж, банкны салбарын эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Макро эдийн засгийн дээр дурдсан нөхцөл байдлыг бид дунд хугацааных гэж харж байна. 2012 оны үлдсэн хугацаанд экспортын түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ одоогийн түвшинд байж, Хөгжлийн банкны санхүүжилт зориулалтын дагуу гарч, улсын төсвийн зардал батлагдсан түвшиндээ зарцуулагдах тохиолдолд ОУВС болон Сангийн яамны тооцоо ёсоор 2012 онд 13-15%-ийн өсөлттэй байх боломжтой хэдий ч гадаад зах зээлийн орчин муудаж, мөнгө зээлийн өсөлт үргэлжлэн саарч байгаа зэргээс үзэхэд эдийн засгийн өсөлт үүнээс бага байх эрсдэлтэй байна. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлт эргэн сайжирч, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж, экспорт өсөх зэргээс шалтгаалан Монголын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд энэ оны хүлээгдэж буй түвшин (15%)-ээс өндөр гарах боломжтой юм.

Гэхдээ зээлийн одоогийн хязгаарлалт энэ хэвээр үргэлжилж, уул уурхайн бус салбарын өсөлт саарч, зээлийн чанар муудвал эргээд санхүүгийн салбарын тогтвортой байдалд хүргэж, эдийн засгийн өндөр өсөлт хангагдахгүй болох эрсдэл богино хугацаанд байсаар байна.

Дээрх нөхцөл байдал, эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв байдалтай уялдуулан мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг богино хугацаанд санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэхэд, дунд хугацаанд хэрэглээний үнийн өсөлтийг нам түвшинд тогтвортжуулахад чиглүүлэх нь зүйтэй гэж үзэн дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

1.1 Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Үүний үр дунд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2013 оны эцэст 8 хувиас хэтрүүлэхгүй байж, улмаар 2014-2015 онд инфляцийг 5-7 хувийн түвшинд байлгах нөхцөл бүрдүүлнэ.

Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд төгрөгийн тогтвортой байдлыг хангахын тулд дотоодын үнийн өсөлтийг тодорхой түвшинд тогтвортой барих зорилго тавьж

ажилладаг билээ. Гэвч Монголбанкнаас тухайн зорилтын хүрээнд авч хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын хэрэгслүүдийн үйлчлэх хүрээ хязгаарлагдмал буюу зөвхөн эрэлтийн шинж чанартай инфляцийн өсөлтийг бий болгохгүй байхад чиглэж байдаг. Иймээс нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөг багасгах ажил ерөнхийдөө орхигдож ирсний улмаас сүүлийн жилүүдийн инфляцийн өсөлтийг нийлүүлэлтийн шинж чанартай буюу мах, гурил, шатахуун болон цахилгаан дулааны үнийн өсөлт болон импортлож буй барааны үнэ дэх тээврийн зардлын хувь хэмжээ өсч байгаа зэрэг нь голлон тодорхойлох болсон. Ийм нөхцөлд Монголбанкны зүгээс эрэлтийн шинжтэй инфляцийг бага байлгах, Засгийн газрын зүгээс нийлүүлэлтийн шинж чанартай аливаа инфляцийн дарамтыг бий болгохгүй байх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай байна.

Иймээс 2013 онд Монголбанк нийлүүлэлтийн гаралтай инфляци үүсэх хүчин зүйлсийн үндсэн шалтгааныг арилгах, ялангуяа мах, гурил, шатахуун зэрэг өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийг чадавхижуулах тусгайлсан хөтөлбөрийг Засгийн газартай хамтарч хэрэгжүүлэх зорилт тавьж байна. Энэ ажлын хүрээнд богино хугацаанд хүнсний нийлүүлэлтийн системийг боловсронгуй болгох чиглэлд Засгийн газрын оролцоог илүү оновчтой, үр ашигтай болгох, бараа, үйлчилгээний үнэ өртөгт хүчтэй нөлөөлдөг шатахууны жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах, импортын тээврийн зардлыг бууруулах чиглэлээр тооцоо судалгааг гүйцэтгэж, холбогдох арга хэмжээний саналыг Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

Монголбанк төгрөгийн тогтвортой байдлыг хангахын тулд дотоодын үнийн өсөлтийг 8 хувь орчимд тогтвортой байлгах зорилго тавьж байна. Төгрөгийн тогтвортой байдлыг түүний гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдалтай хольж ойлгох тохиолдол олон нийтийн дунд байна. Угтаа төгрөгийн валюттай харьцах нэрлэсэн ханшаас илүүтэй бодит үйлчилж буй ханш чангараах/сулрах нь манай эдийн засагт оруулах хөрөнгө оруулалт нь бусад оронтой харьцуулахад илүү өгөөжтэй/үр ашиг муутай болж байгааг илэрхийлнэ. Иймд төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшийг удирдах байдлаар тогтвorumжуулах гэж оролдох нь эцэстээ санхүүгийн салбарын аль нэг хэсэгт эрсдэл хуримтлагдах, тогтвorumгүй байдал үүсэх шалтгаан болдог гэдгийг олон улсын хөгжлийн эдийн засгийн түүх нотолсон билээ. Азийн олон улс орон эдийн засгийн төрөлжилт, хүний нөөц, технологийн давуу тал зэрэг онцлогоо ашиглан валютын ханшаа байнга сулруулж экспортын орлогоор эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгож буй туршлага байна. Гэхдээ үүнийгээ дээр дурдсан давуу талуудаас гадна захиргааны болон хөрөнгө шилжилтийн хязгаарлалтыг хэрэглэж байж амжилтад хүрсэн байдаг. Манай эдийн засгийн хувьд эдгээр хувилбарууд тохиорхгүй болохыг 1994-1998 болон 2008-2009 онуудын санхүүгийн хямралууд харуулсан.

Үнийн тогтвортой байдлыг хангах нь Төв банкны зүгээс өндөр, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход оруулж буй үндсэн хувь нэмэр билээ. Манай улсын хувьд 8 орчим хувьд тогтвортой байх инфляци нь бодит эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөгүй, нийгмийн амьжиргааг хамгаалах боломж олгосон, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт эрчимтэй байх нөхцөл бүрдүүлсэн, нөөцийн хуваарилалт үр ашигтай байхад зохистой тувшин гэж Монголбанк үзэж байна. Энэ зорилго хэрэгжихэд макро эдийн засгийн бодлого цогцоороо эдийн засгийн тогтвортой өсөлтийг зорьсон байх нь нэн чухал юм. Түүнчлэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон түлш шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг найдвартай болгох арга хэмжээг Засгийн газар авсан байх шаардлагатай.

Хэлбэлзэл ихтэй, өндөр инфляци нь ядуурлыг нэмэгдүүлж, дундаж давхаргын хуримтлалыг хязгаарлах төдийгүй эдийн засагт тодорхой бус байдал, эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн зуучлал болон иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлнө. Өндөр инфляци нь макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг хэврэгшүүлж, дунд болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хязгаарладаг. Иймд Монголбанк инфляцийг боломжит нам, тогтвортой түвшинд байлгаснаар дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсч, нийгмийн амьжиргаа дээшлэх, санхүүгийн тогтолцоо үр ашигтай ажиллах орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Монголбанк 2013 онд инфляцийг 8 хувиас хэтрүүлэхгүй, 2014-2015 онуудад 5-7 хувиин түвшинд байлгах зорилт тавьж байгаа нь зөвхөн үнийн тухай асуудал бус бөгөөд мөнгөний бодлого бүхэлдээ санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах, нийгмийн амьжиргааг хамгаалах, төгрөгт итгэлийг бэхжүүлэхэд чиглэж байхыг хэлнэ. Энэхүү 8 хувиин тогтвортой инфляци нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөгүй, нийгмийн амьжиргааг хамгаалах зохистой түвшин болохыг олон улсын судалгаа харуулсан. Инфляци болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал шугаман бус буюу инфляци тодорхой түвшин хүртэл өсөх нь нийлүүлэлтийг урамшуулдгаараа эдийн засгийн өсөлтийг дэмждэг бол тодорхой түвшний дараагаас нөөцийн үр ашиггүй хуваарилалтыг бий болгож тэр нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг ихэнх судалгаа нотолдог. Сүүлийн 50 жилийн судалгааны үр дүнгээс үзэхэд инфляцийн энэхүү босго утга хөгжиж буй орны хувьд 7-12 хувь, харин дэлхийн дунджаар 8 хувь болохыг тогтоосон байна.

Монголбанк 2009 оноос хойш инфляцийг нэг оронтой тоонд буюу дээд хязгаар нь 10% байхаар тогтвортой зорилт тавих болсон нь олон нийтэд инфляцийн хүлээлт төлөвших, эдийн засаг дахь тодорхой бус байдал буурах, хүүний хэлбэлзэл багасах зэрэг зерэг нөлөөг үзүүллээ. Хэдийгээр Монголбанк инфляцийг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт албан ёсоор шилжээгүй байгаа ч уг бодлогын онцлог, давуу тал болох макро эдийн засгийн хэтийн төлөвт суурилан, ирээдүйг харсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлж хэвших, инфляцийн зорилтыг хангах замаар инфляцийн хүлээлтийг

төлөвшүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. 8 хувийн тогтвортой инфляци нь санхүүгийн зуучлал гүнгийрч, зээлийн хүү одоогийн түвшний 2/3-т хүрч буурах боломжийг олгож, эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлт хадгалагдах боломжийг олгоно. Эдийн засгийн 10 хувийн бодит өсөлт нь ерөнхий цалингийн түвшинг хамгийн багадаа энэ хувиар өсөх боломжийг бүрдүүлэх тул бодит цалингийн орлого жил бүр 2-оос дээш хувиар нэмэгдэх нөхцөл бүрдэх юм. Үүний үр дүнд зээлийн хүү буурснаар иргэдийн зээлийн эргэн төлөлт дэх хүүгийн төлбөр 2-3 дахин багасч, худалдан авах чадвар нь мөн 2-3 дахин нэмэгдэх боломжтой.

Инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах нь мөнгөний бодлогын гол зорилт юм. Үүнийг хангахад мах, шатахууны үнийн хэлбэлзлийг далайцтай бууруулах ажлыг Засгийн газраас зохион байгуулах, үр дүнд хүрэх нь асар их ач холбогдолтой. Манай орны хувьд мах болон шатахууны үнийн өөрчлөлт нь инфляци, түүний хэлбэлзлийг өдөөгч нийлүүлэлтийн үндсэн хүчин зүйл болж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн дунджаар жилийн инфляцийн 40 гаруй хувийг суурь инфляци, 20 гаруй хувийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляци, үлдсэн 40 орчим хувийг хүнсний бүтээгдэхүүний инфляци, үүнээс 24 хувийг нийлүүлэлт доголдсоны улмаас бий болсон махны үнийн өсөлт тус тус эзэлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлсэн махны нөөц бүрдүүлж, нийлүүлэлт доголдооос сэргийлэх арга хэмжээний үнийн дүн нь 2010-2011 онд нэмэгдсэн хэдий ч, арга механизмын хяналт, зохион байгуулалт нь нэн сул байснаас хэрэгжилт нь үр дүнтэй байж чадаагүй. Цаашид энэхүү арга хэмжээг илүү үр нөлөөтэй арга механизмаар тогтмолжуулах, нөөцийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Монголбанк эдийн засаг дахь эрэлт, нийлүүлэлтийн шокын инфляци, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө хэр удаан үргэлжлэхийг шинжилж үзсэний үндсэн дээр ирээдүйг харсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байна. Хэрэв инфляцийг өдөөгч шок нь түр зуурын шинж чанартай бол инфляци зорилтот түвшнээс бага зэрэг зөрөх үед Төв банк ихэвчлэн хариу арга хэмжээ авдаггүй болно. Харин мөнгөний бодлогын хэрэгслийг ямар хэмжээгээр өөрчлөх нь шокын төрөл, шинж чанар болон хэмжээнээс хамаарах юм. Тухайлбал, эрэлтийн шокын үед инфляци болон эдийн засгийн өсөлт ижил чиглэлд өөрчлөгднө. Төсвийн бодлого бодино хугацаанд хэт тэлэх нь эдийн засгийн хэт халалтыг бий болгож, эрэлтийн шалтгаантай өндөр инфляцийг бий болгоно. Иймд мөнгөний бодлогыг чангaruулан эдийн засгийн идэвхжилийг сулруулах замаар инфляцийн дарамтыг бууруулахад хүргэдэг. Харин нийлүүлэлтийн шокын үед инфляци болон үйлдвэрлэл нь эсрэг чиглэлд өөрчлөгдөх ба энэ нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг байна. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг мөнгөний бодлогоор бууруулах гэж оролдох нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй гэж үзэж байна.

Мөнгөний бодлого нь инфляци болон үйлдвэрлэлд тодорхой хугацааны хоцролтой нөлөөлдөг тул тогтвортой, нам түвшний инфляци нь санхүүгийн зуучлалыг идэвхжүүлж, санхүүгийн тогтвортой байдал хангагдсанаар мөнгөний бодлогын хэрэгслийн санхүүгийн зах зээлээр дамжин бодит секторт үзүүлэх үр нөлөө сайжирч, нөлөөллийн хоцролтыг бууруулдаг. Иймд санхүүгийн зах зээлийн хөгжлөөс хамааран улс орон бүр дэх мөнгөний бодлогын үр нөлөө харилцан адилгүй байна. Түүнчлэн мөнгөний бодлогын хүүний шийдвэр болон инфляцид үзүүлэх хамгийн хүчтэй нөлөө хоорондын хугацааны хоцролт нь эдийн засаг дахь бүтцийн болон институционал өөрчлөлтөөс хамааран цаг хугацааны туршид өөрчлөгдөнө. Иймээс Төв банк мөнгөний бодлогын шилжих механизмын хугацааны хоцролтыг зөвхөн ойролцоолон хэмжиж, ирээдүйг харсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай нүүр тулдаг. Одоогоор манай орны хувьд уг хугацааны хоцролт 2-3 улирал байх тооцоотой байна.

Урт хугацааны үнийн тогтвортой байдлыг хангахын тулд санхүүгийн тогтвортой байдлыг мөнгөний бодлогын шийдвэрт харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь мөнгөний бодлогын шилжих механизм зөвхөн санхүүгийн тогтвортой системээр дамжиж үр дүнтэй ажилладаг. Иймд 2013 онд баримтлах мөнгөний бодлого үнийн өсөлтийг тогтвorumжуулж зорилтот түвшинд байлгахын зэрэгцээ санхүүгийн тогтвorumгүй байдлын эрсдэлээс зайлсхийхэд давхар чиглэх болно.

Монголбанк 2013 онд инфляцид нөлөөлөх хүчин зүйлсийн өөрчлөлт, хандлагыг анхааралтай ажиглан инфляцийн зорилтыг хангаж, энэхүү үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх мөнгөний бодлогын холбогдох арга хэмжээг авч ажиллана. Макро эдийн засгийн тогтвортой байдал, тэр дундаа үнийн тогтвортой байдлыг хангах зорилт нь төсвийн зохистой бодлого, нийлүүлэлтийн хомсдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй хосолсноор л амжилттай хэрэгжих боломжтой гэдгийг онцлон тэмдэглэж байна.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах хани нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

2012 он гарсаар дэлхийн эдийн засгийн өсөлт зогсонги, Европын өрийн хямрал ужгирсан, Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширсан буюу гадаад эдийн засгийн орчны тааламжгүй нөхцөл байдал үргэлжилсээр байна. Үүнтэй уялдан суурь металл, аж үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн үнэ буурсан. Монгол Улсын экспортын нүүрс, төмрийн хүдэр, цайр зэрэг түүхий эдийн үнийн бууралт нь нийт экспортын бүтээгдэхүүний үнийн индексийг энэ оны 8 дугаар сарын эцсийн байдлаар оны эхнээс 5.2 хувиар, жилийн 11.1 хувиар буурахад хүргэв. Улмаар гадаад худалдааны нөхцөл оны эхнээс 16.0 хувиар, жилийн 17.3 хувиар муудаад байна. Нөгөө талаар гадаад эдийн засгийн орчны тодорхой бус, эрсдэлтэй нөхцөл байдал нь

Монгол улсын валютын орох ургалд голлох хувийг эзэлдэг гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц буурахад нөлөөллөө. 2011 онд цэвэр дунгээр 4.6 тэрбум ам.долларт хүрч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ оны эхний 7 сард 1.98 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 883 сая ам.доллараар буюу 31 хувиар буураад байна.

Валютын захын эрэлт, нийлүүлэлт энэ оны 1 болон 3 дугаар улиралд тэнцвэргүй болж, эдийн засгаас цэвэр дунгээр гадаад валют гадагшлах хандлагатай болж байна. Энэ нь гадаад секторын эрсдэл өмнөх оныхоос илүүтэй өссөн, гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотой.

Ургал тэнцэл, гадаад худалдааны алдагдал огцом өсч байгаатай уялдан төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөө дагаж энэ оны 6 дугаар сараас эхлэн алгуур сулрах хандлагатай боллоо. Хэдий тийм боловч Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.08 хувь буюу валютын зах тогтвортой байлаа. Гэвч валютын захын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийн эрсдэл өссөөр байна.

Мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хангахын тулд Монголбанк инфляцийг өдөөдөг хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, эрдэс баялгийн салбараас шалтгаалсан валютын ургалын эдийн засаг, валютын зах дахь сөрөг нөлөөллийг саармагжуулах, инфляцийн хүлээлтийг зохистой удирдах, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралтаас шалтгаалж инфляци өсөх эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээгээ уlam бүр сайжруулах ба үүнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөвлрүүлэх бодлого нь эерэгээр нөлөөлж байна.

Төрийн мөнгөний бодлогын үндсэн зорилт болох үнийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хангах, эдийн засгийн тэнцвэртэй, хүртээмжтэй өсөлтийг урт хугацаанд дэмжих нэг суурь нөхцөл нь өнөөгийн уян хатан ханшийн бодлогыг үргэлжлүүлэн тууштай баримтлах явдал мөн. Иймд Монголбанк уян хатан ханшийн бодлогыг 2013-2015 онд үргэлжлүүлэн баримтална.

1.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үндсэн зорилтын хэрэгжилтийг олон нийтэд тогтолцоулсан замаар Төв банкны хариуцлагыг сайжруулна.

Өнөөдөр дэлхийн ихэнхи Төв банк үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх нөлөөтэй хэмээн үздэг болсон

байна. Үйл ажиллагааны ил тод байдал нь Төв банкны бодлогын хэрэгжилт, богино хугацааны зорилтууд, макро эдийн засгийн гэнэтийн (хүлээгдээгүй) шокуудын нөлөө зэрэг асуудлыг хамардаг билээ.

Эдийн засгийн нөхцөл байдлыг тогтмол үнэлэн, бодлогын арга хэмжээнүүдээ тайлбарлах нь мөнгөний бодлогын үндэслэл, хариу үйлдлийг зөв ойлгох боломж олгох төдийгүй Монголбанкны мөнгөний бодлогыг дунд хугацаанд таамаглагдахуйц болгох ач холбогдолтой билээ. Энэ нь эргээд зах зээлийн хүлээлтийг зөв зохистой, үр ашигтай бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

Монголбанкнаас сүүлийн үед мөнгөний бодлогын зорилт, шилжих механизм, шийдвэр гаргах явц, мөнгөний бодлогын шийдвэрийн нээлттэй, ил тод байдлыг ахиулахад анхаарч ажилласан билээ. 2013 онд Монголбанк үйл ажиллагааны ил тод байдлыг хангах тал дээр, ялангуяа бодлогын хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлан таниулах тал дээр анхаарч ажиллана.

Мөнгөний бодлогын хэрэгжилт, макро эдийн засгийн нөхцөл байдалд тогтмол үнэлгээ өгөх замаар Төв банкинд итгэх итгэл, Төв банкны хариуцлагыг нэмэгдүүлнэ. Нэн ялангуяа, хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн оны эхнээс тооцсон инфляцийн түвшин зорилтот түвшнээс хэтэрсэн тохиолдолд УИХ, Засгийн газарт нээлттэй захия хүргүүлэн байр сууриа илэрхийлэх туршлагыг төлөвшүүлнэ. Энэ хүрээнд Монголбанкнаас Засгийн газар, УИХ-д мөнгөний бодлогын хэрэгжилттэй холбоотойгоор өмнө нь хүргүүлж байсан албан тоот, бусад баримт бичгийг өөрийн цахим хуудас дээр тавьж нийтэд ил тод тайлагнана.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1 Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, толбөрийн чадварыг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшилүүлнэ.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын уул уурхай, барилга, банк санхүүгийн салбаруудад хийгдэж буй шууд, багцын болон бусад хөрөнгө оруулалт хурдацтайгаар өсөх хандлага ажиглагдаж байсан ч тайлант хугацаанд буурсан үзүүлэлттэй гарлаа. Хэдийгээр нийт хөрөнгө оруулалт дахь багцын хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдэж байгаа ч банкны системээс хөрөнгө богино хугацаанд гадагшлах эрсдэл байсаар байна.

Иймд банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах үүднээс системийн ач холбогдол

бүхий банкуудын зохистой харьцааны шаардлагыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд цаашид дээрх шаардлагын хэрэгжилтийг хангулж, шаардлагатай тохиолдолд холбогдох албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Түүнчлэн банкны системийн хямрал болон төлбөрийн чадварын хүндрэл үүсэхэд авах арга хэмжээний бэлтгэлийг хангуулах зорилгоор *Хямралын үед авч хэрэгжүүлэх болон өөрийн хөрөнгийн дутагдлыг арилгах төлөвлөгөөг* банк тус бүрээр гүйцэтгүүлж, эрсдэлийг бодитойгоор үнэлэх ажлыг хэвшүүлнэ.

2.2. Олон улсад мөрдөгдөж буй хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

Дэлхийн санхүүгийн хямралаас шалтгаалан банкуудыг эрсдэл өндөртэй активт хөрөнгөө байршуулахыг хязгаарлан, өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын үзүүлэлтийг сайжруулах зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн банкуудад мөрдүүлэх ажлыг эхлүүлээд байна. Түүнчлэн эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг банкуудын эрсдэлийн ерөнхий түвшин болон системийн хэмжээнд үзүүлж буй нөлөөлөлд үндэслэн оновчтойгоор зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Иймд банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор өөрийн хөрөнгийн зохистой харьцааг олон улсын Базель III стандарттай уялдуулж, өөрийн хөрөнгийн бүтэц, чанарын ангиллыг төрөлжүүлэх, өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагуудыг судалснаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д үе шаттайгаар тусган, банкуудад мөрдүүлнэ.

Банкуудын эх үүсвэрийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах, урт хугацаат эх үүсвэр татахад дэмжлэг үзүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах арга хэмжээг авах хүрээнд Базель III стандарттаар санал болгож буй богино болон урт хугацааны хөрвөх чадварын шаардлагыг мөрдүүлэх боломжтой эсэхийг судална. Базелийн хороо нь шинээр танилцуулж буй эдгээр зохицуулалтуудаа 2015-2019 оны хооронд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Иймд Монголбанкны зүгээс дээрх зарчим нь банкны системд тохирох эсэх, хэрэгжүүлсэн тохиолдолд банкуудын төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлөх нөлөөллийг судалсны үндсэн дээр холбогдох журам, зааварт тусган банкуудад мөрдүүлнэ.

Банкинд учирч болох нийтлэг эрсдэлүүдийг (зээлийн, төлбөрийн чадварын, зах зээлийн, үйл ажиллагааны гэх мэт) түүхчилсэн мэдээлэл болон мэдрэмтгий байдлын шинжилгээнд үндэслэн банкуудын бие даасан үнэлгээг хийлгэж, үр дүнгээс нь хамаарч, үүссэн эрсдэлийн түвшинтэй нь уялдуулан газар дээрх болон зайны хяналт шалгалтын үйл ажиллагааны хуваарийг банкуудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн Монголбанкнаас дунд хугацаанд хэрэгжүүлэх хяналт шалгалтын үйл ажиллагааны стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3 Банкны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчилнэ.

Зээлийн барьцаа хөрөнгийн захиран зарцуулах эрхийг банкны мэдэлд шилжүүлэхэд их хэмжээний зардал, хугацаа зарцуулдаг түгээмэл зөрчлийг арилгах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг оновчтойгоор хангуулах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг санаачлан зохион байгуулна.

Барьцаа хөрөнгийн худалдан борлуулах эрхийг банкинд шуурхай шилжүүлэх боломжийг хангаснаар банкны үндсэн үйл ажиллагаа түргэн шуурхай явагдах, санхүүгийн сахилга бат сайжирч, банкны системийн эрсдэл, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ. Энэ нь хямрал учрах эрсдэлтэй үед банкны системийг эрсдлээс хамгаалах зайлшгүй арга хэмжээний нэг билээ.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1 Төрөөс мөнгөн хадгаламжид гаргах баталгааг хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжүүлснээр төрд учрах эрсдэлийг бууруулж, банкны салбарын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дэшилүүлнэ.

УИХ-аас 2008 онд баталсан “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийн хэрэгжих хугацаа 2012 оны 11 дүгээр сард дуусгавар болж байгаатай холбогдуулан эрсдэлд сууриссан, нөөцийн хуваарилалтыг илүү оновчтойгоор зарцуулах чадамж бүхий хадгаламжийн даатгалын шинэ тогтолцоог бий болгох шаардлага тулгарч байна.

Үүнтэй холбоотойгоор Монголбанк, Сангийн яам, холбогдох бусад байгууллагын төлөөлөлтэйгээр 2010 онд байгуулсан “Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг нь банкны салбарын тогтвортой байдал, банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа, банкны ил тод байдлыг сайжруулах бодлогын арга хэрэгслүүдийн талаар судалгаа хийсний үндсэн дээр хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх нь илүү оновчтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Энэхүү харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчинг бий болгох үүднээс “Хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн төслийг Монголын банкны салбарын онцлог байдал болон Basel II-ийн банкны хяналт шалгалтын хорооноос гаргасан

“Хадгаламжийн даатгалын үр ашигтай тогтолцооны үндсэн зарчмууд”-тай нийцүүлэн боловсруулсан.

Дээрх хууль батлагдсанаар хязгаарлагдмал хадгаламжийн даатгалтын тогтолцоог бий болгож, банк болон санхүүгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн сахилгыг дээшлүүлж, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, төрд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зэрэг эерэг үр дүн бий болно.

Цаашид хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэгтэй хуулийн этгээдийн ажиллах журам, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлон үйл ажиллагааг эхлүүлж, “Мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хууль”-д заасан банкуудаас хадгаламжийн даатгалд төвлөрүүлэх шимтгэлийн хэмжээг тооцож, холбогдох санд төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

3.2 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2013-2015 онд эрчимжүүлэх ажлын хүрээнд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, боловсронгуй болгоно.

Манай орны эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж байгаа гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Төлбөр тооцооны системээр 2012 оны эхний хагас жилийн байдлаар 9.9 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн 3.5 сая ширхэг гүйлгээнээс даруй 2.8 дахин өсчээ.

Өдрийн гүйлгээний дундаж үзүүлэлтийг 2007 ба 2011 оны байдлаар авч үзвэл 2007 онд бага дүнтэй төлбөр тооцооны системээр ойролцоогоор 800 сая төгрөгийн 6 мянян ширхэг гүйлгээ хийгдэж байсан бол 2011 онд дунджаар 2.8 тэрбум төгрөгийн 13 мянян ширхэг гүйлгээ болж өслөө. Банк хоорондын их дүнтэй гүйлгээний хувьд 2007 онд өдөрт дунджаар 46 тэрбум төгрөгийн 1.7 мянян ширхэг гүйлгээ хийгдэж байсан бол 2011 онд 132 тэрбум төгрөгийн 3.6 мянян ширхэг гүйлгээ болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг хурдаасгах зорилгоор бэлэн бус төлбөр тооцоонд ашиглах төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ хэрэгсэл нэвтрүүлэх, төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах шаардлага тавигдаж байна.

Иймд Монголбанк 2013-2015 онд бэлэн бус төлбөр тооцооны хосолмол (чи�, соронзон тууз, зайнаас хандах технологи хосолсон) карт гаргах, иргэний ухаалаг

Үнэмлэхийг төлбөр тооцоонд ашиглах, интернетийн орчинд төлбөр хийх боломжийг боловсронгуй болгох ба хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлж, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.

Монголбанкаас үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн үндэсний брэнд Т картыг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах бөгөөд цаашид энэхүү Т карт дээр тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг өргөтгөх, гар утастай холбох, банкны үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжоор хязгаарлагдмал хөдөө орон нутгийн иргэдэд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн үйлчилгээг шуурхай хүргэж, бэлэн бус төлбөр тооцооны хүртээмжийг нэмэгдүүлэх болно.

Төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаснаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх ба бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэх юм.

3.3 Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлэх олон улсын жишигт суурисан аргачлалыг нэвтрүүлж эхэлнэ. Банк санхүүгийн үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжстэй болгох, иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Энэ ажлын хүрээнд Дэлхийн банктай хамтран 2012 оны эхний хагас жилд Монгол улсын банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэж буй хэрэглэгч, харилцагчдын эрх ашгийг хэрхэн хамгаалж буй байдал, тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын өнөөгийн байдлыг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгааг хийсэн. Дээрх судалгаанд Монголын эрх бүхий байгууллагуудаас харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал, харилцагчдын банк санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг хангалтгүй байгаа талаар дүгнэлт хийсэн.

Монголбанк ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн өртөг болон нөхцөлийг харьцуулах боломжийг өөрийн цахим хуудсаараа олгоно. Зээлийн өргөдлийг боловсруулах явцад тавигддаг шаардлагуудыг судлан шинэчилнэ. Банкууд иргэдийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, санал гомдлын мэдээллийн санг Монголбанктай хуваалцах механизмыг Төв банкаас бий болгоно. Хэрэглэгчдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд Монголбанк Монголын банкуудын холбоотой хамтран Санхүүгийн нэр томъёоны толь бичгийг боловсруулан нийтийн хүртээл болгоно.

Харилцагч банкуудын санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардал, урамшуулал, эрсдэлийн талаар хангалттай мэдээлэл авч чаддаг, эдгээр мэдээлэл нь ил тод,

ойлгомжтойгоор харилцагч нарт хүрдэг тохиолдолд хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдах юм. Харилцагчдын эрх ашиг, санхүүгийн боловсрол нь санхүүгийн системд итгэх олон нийтийн итгэлийг бий болгох ба улмаар санхүүгийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлдэг хуримтлал болон урт хугацаатай санхүүгийн хөрөнгө оруулалтыг урамшуулж байдаг билээ.

Иймд Монголбанк банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээ, зээлийн бодит өртөг, зардал, мэдээллийн ил тод байдлыг хамарсан судалгааг хийх, түүний үр дүнд үндэслэн санхүүгийн зах зээлд нийтээр дагаж мөрдөх олон улсын жишигт суурилсан аргачлалыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхээр зорьж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай УИХ-ын тогтоолын 4 дэх заалт “*Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын холбогдох стандартад нийцүүлж, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас тогтоосон Монгол Улсын үнэлгээг дээшилүүлэх ажлыг зохион байгуулах*” арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага нь:

2004 онд Монгол Улс Ази, номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АПГ)-т элсэн дотооддоо мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, ялангуяа, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын 40+9 зөвлөмжид нийцсэн тогтолцоог бий болгох үүрэг хүлээжээ.

ФАТФ-аас улс, орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх дотоодын хууль тогтоомжийг НҮБ, олон улсын бусад байгууллагын холбогдох гэрээ, конвенц болон өөрийн 40+9 зөвлөмжид нийцүүлсэн байх төдийгүй, гаргасан хууль тогтоомжкоо үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг зөвлөдөг.

Хэдийгээр дээрх зөвлөмжийг улс орнууд “зөвлөмж” мэтээр хүлээж авч болох ч энэ нь үнэндээ “шаардлага”-тай нийцэхүйц чадамж бүхий бичиг баримт юм. Тухайлбал, тус байгууллага нь өөрийн гишүүн орнууд, АПГ мэтийн бус нутгийн ФАТФ-тай төстэй байгууллагууд, хамтран ажилладаг олон улсын байгууллагуудаар дамжуулан дэлхийн бүх улс оронд өөрийн зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг нарийвчлан хянан шалгаж, зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлж эхэлсэн боловч стратегийн томоохон дутагдалтай хэвээр байгаа орнуудыг “ФАТФ-тай хамтарч ажилладагтүй улс орнуудын жагсаалт”-д оруулах замаар тэдгээр орныг олон улсын санхүүгийн системээс тусгаарлах арга хэмжээ авдаг байна.

Дэлхийн банк, санхүүгийн томоохон байгууллагууд энэхүү жагсаалтад орсон улс орны банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээд, иргэдтэй харилцаа тогтоох, тэдгээрийн гүйлгээг хийхдээ давхар хяналт тавих, тэдгээрээс нэмэлт мэдээлэл шаардах, тэдгээрт тавигдах шаардлагыг өндөрсгөх, санхүүгийн харилцаа, гүйлгээг нь удаашруулах, цаашлаад тэдгээрт данс нээхгүй, тэдгээрийн гүйлгээг хийхгүй байх хүртэл арга хэмжээ авах үүрэгтэй байдаг. Энэ нь жагсаалтад орсон улс орны эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх аюултай үр дүнг дагуулдаг юм.

Монгол Улс 2006 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, Монголбанкны бүтцэд энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн албыг байгуулан ажиллаж байна. Гэсэн хэдий ч олон улсын байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, ялангуяа энэ талаарх эрх зүйн орчин дутмаг, ФАТФ-ын 40+9 зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ихээхэн дутагдалтай байна гэсний үндсэн дээр Монгол Улсыг олон улсын санхүүгийн системд эрсдэл үүсгэх боломжтой орон гэж тооцож ФАТФ, АПГ-гийн давхар хяналтад оруулан үнэлгээг бууруулсан байна.

Тухайлбал, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд сэжигтэй гүйлгээний тодорхойлолтыг өргөжүүлэх, уг гүйлгээг мэдээлээгүй банк, санхүүгийн байгууллагад тооцох захиргааны хариуцлагыг өндөрсгөх, данс, эд хөрөнгийн жинхэнэ эзэмшигч хувь хүний тодорхойлолт, түүний мэдээллийг цуглуулах тухай заалтыг бий болгох, Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн тоог нэмэгдүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох заалт оруулах, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэмт хэргээс олсон орлогын тодорхойлолтыг сайжруулах, гэмт хэргээс олсон орлогыг хураах, битүүмжлэх ажиллагааг НҮБ-ын холбогдох конвенцид нийцүүлэх зэрэг эрх зүйн цогц өөрчлөлт хийхийг тус байгууллага Монгол Улсын Засгийн газарт зөвлөжээ.

Монгол Улс дээр дурдсан хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулан эрх зүйн орчноо ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн сайжруулах үүргийг олон улсын байгууллагуудын өмнө хүлээж, Монголбанк, Хууль зүйн яам хууль тогтоомжийн эдгээр дутагдалтай байдлыг 2013 оны 6 дугаар сараас өмнө арилгах талаар улс төрийн амлалтыг ФАТФ, АПГ-д өгсөн байгаа болно.

Иймд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын эрх зүйн орчинг ФАТФ-ын холбогдох зөвлөмжид нийцүүлэх, тус байгууллагаас тогтоосон Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

МОНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД: 2009 оноос 2013 он

(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр)

Мөнгөний тойм	2009		2010		2011				2012				2013			
	Q4	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	M8	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	
	Гүйц	Гүйц	Гүйцэтгэл					Гүйцэтгэл					Төсөөлөл			
M2 мөнгө	2880	4680	4955	5773	6064	6412	6105	7051	6997	6982	7267	7036	8568	8449	9149	
М1 мөнгө	651	1158	1182	1553	1676	1741	1488	1797	1681	1718	1780	1707	2088	2063	2229	
Бараг мөнгө	2229	3522	3774	4220	4388	4671	4617	5254	5316	5264	5487	5329	6480	6386	6920	
Гадаад цэвэр актив	1533	2739	2619	2950	3040	3067	3355	3448	3103	2872	2404	2000	2068	2246	2446	
Гадаад цэвэр нөөц	1694	3023	2886	3260	3343	3400	3655	3785	3452	3642	3173	2770	2838	3016	3215	
Төв банкны	1652	2628	2566	2951	3084	3153	3495	3645	3404	3173	2844	2581	2790	2967	3167	
Арилжааны банкны	41	395	320	309	259	247	160	139	47	469	329	188	48	48	48	
Бусад цэвэр зүйл	-160	-283	-267	-310	-303	-333	-300	-336	-349	-770	-770	-770	-770	-770	-770	
Дотоод цэвэр актив	1347	1941	2336	2823	3024	3345	2750	3603	3894	4110	4863	5035	6500	6203	6703	
Дотоодын цэвэр зээл	1938	2430	2735	3380	3711	4271	3571	4469	4788	5004	5757	5929	7394	7097	7597	
ЗГ-ын цэвэр зээл	-717	-835	-996	-1173	-1350	-1370	-1378	-1030	-1048	-1048	-850	-821	-442	-672	-748	
Хөгжлийн банкны цэвэр зээл*							-833	-819	-839	-841	-510	-440	-254	-218	-120	
ББ-aас авах авлагат	2655	3265	3731	4553	5060	5641	5782	6318	6675	6893	7117	7191	8090	7988	8466	
Бусад цэвэр зүйл	-591	-489	-399	-557	-687	-926	-821	-866	-894	-894	-894	-894	-894	-894	-894	
Төв банк																
Нөөц мөнгө	733	945	1019	1260	1399	1660	1815	2281	1943	1857	1991	1938	2393	2195	2328	
Гадаад цэвэр актив	1539	2529	2470	2850	2983	3044	3391	3542	3296	3065	2737	2473	2682	2860	3059	
Дотоод цэвэр актив	-806	-1584	-1451	-1590	-1584	-1384	-1576	-1261	-1353	-1208	-746	-535	-288	-665	-731	
ЗГ-ын цэвэр зээл	-265	-492	-627	-827	-958	-714	-608	-440	-419	-415	-281	-358	-209	-543	-724	
Хөгжлийн банкны цэвэр зээл*							-833	-782	-752	-754	-440	-70	-84	-98	0	
Банкинд олгосон зээл	198	131	128	215	118	342	544	404	254	324	354	321	379	346	383	
Хасах нь: ТБҮЦ	393	1101	1173	1147	881	879	740	557	464	391	406	456	402	397	417	
Бусад цэвэр зүйл	-346	-122	221	169	137	-133	60	114	27	27	27	27	27	27	27	
Меморандум үзүүлэлтүүд:																
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	26.9	62.5	66.6	63.8	57.4	37.0	23.2	22.2	18.3	15.1	13.3	15.2	21.5	21.0	25.9	
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	15.7	29.0	50.3	50.2	79.7	75.5	78.0	81.1	50.7	32.8	20.0	6.8	4.9	18.2	16.9	
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	0.7	23.0	34.8	57.9	64.0	72.8	55.0	39.6	38.8	36.2	26.2	24.4	28.0	15.9	18.9	
M2 мөнгөний үргжүүлэгч (нэгжээр)	3.93	4.95	4.86	4.58	4.33	3.86	3.36	3.09	3.60	3.76	3.65	3.63	3.58	3.85	3.93	
Гадаад цэвэр албан нөөц (сая ам доллар)	1145	2091	2142	2339	2408	2258	2637	2718	2464	2262	2028	1840	1989	2116	2258	
Нээрлэсэн ДНБ/тэрбум төгрөг/	6591	8415				10830						14399			17895	
Мөнгөний эргэлтийн хурд	2.63	2.39				1.92						2.09			2.16	
Мөнгөний хурдны өөрчлөлт (нэгжээр)	2.63	-0.25				-0.47						0.17			0.06	

*Хөгжлийн банкны цэвэр зээлийг бусад цэвэр зүйлэс салгаж харуулав.

Төсөөлөлт төгрөгийн ам. доллартаа харьцах ханшигийн одоогийн түвшингтэй адил буюу 1403 байхаар авч үзэв.

*Монголбанкны 2012 оны 05 дугаар сарын 22-ны
өдрийндугаар албан тоотын хавсралт*

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2012 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ
УИХ-ЫН 58 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**

(2012 оны III улирлын урьдчилсан байдлаар)

2. Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро зохистой бодлогын арга хэрэгслийг тодорхойлж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

ОУВС-гаас олон улсын хэмжээнд явуулсан судалгааны үр дүн, нийтэд түгээсэн судалгааны үр дүн зэргийг үндэслэн Монголбанк макро зохистой хэрэгслүүдийн жагсаалтыг гарган Захирлуудын зөвлөлд хэлэлцүүлсний үндсэн дээр зохистой хэрэгслүүдийг сонгон холбогдох арга хэмжээг шаардлагатай үед нь авч ажилласан. Тухайлбал, заавал байлгах нөөцийг хувийг 1 хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэсэн, 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцааны доод хэмжээг 25 хувь, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг 7 хувиар мөрдүүлж эхлэсэн. Энэхүү арга хэмжээ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогыг нэвтрүүлэх хүрээнд банкны системийн хувьд динамик эрсдэлийн санг байгуулах тооцоо хийж, динамик эрсдэлийн санг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг судлах, Монголд хэрэгжүүлэх талаар санал боловсруулах зэрэг ажлуудыг хийж байна.

Макро эдийн засгийн бодлого зохистой байх гол үндэс нь төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг бусад макро бодлогын хамт цогцоор нь хэрэгжүүлж, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийн гол суурь болгох явдал билээ. Төсвийн бодлого төдийлөн мөчлөг сөрсөн байж чадахгүй, төсвийн алдагдал өндөр байгаагаас Монголбанк төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах талаар санал боловсруулан Засгийн газарт удаа дараа хүргүүлсэн болно.


II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААРХИ 2012 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ (2012 оны 8 дугаар сарын эцсийн байдаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2012 онд нэг оронтой тоонд, 2013-2014 онуудад найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах.

Хэрэглээний үнэ 2012 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 0.7 хувиар өсч, жилийн 14.9 хувьд, Улаанбаатар хотын хэмжээнд 1.38 хувиар өсч, жилийн 15.6 хувьд хүрлээ (Зураг 1.1). Улаанбаатар хотод 8 дугаар сард мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 63.5 хувиар өссөн нь инфляцийн 44.3 хувийг, хувцас, бөс барааны үнэ 17.7 хувиар өссөн нь 14.2 хувийг, орон сууц, ус цахилгаан түлшний үнэ 14.4 хувиар өссөн нь 12.7 хувийг, боловсролын үнэ 16.1 хувиар өссөн нь инфляцийн 6.3 хувийг тус тус бүрдүүлжээ.


Зураг 1.1 Улаанбаатар хотын жилийн инфляци, хувиар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хэрэглээний үнийн өсөлтөд нийлүүлэлтийн гаралтай махны үнийн өсөлт өндөр хэвээр байна. Оны эхнээс тооцсон инфляцийн түвшин 12.1 хувьд хүрсний 52.9 хувийг махны үнийн өсөлт тайлбарлаж байна (Зураг 1.2).

Зураг 1.2 Инфляцийн задаргаа (оны эхнээс, %)



Зураг 1.3 Махнаас бусад бүтээгдэхүүний инфляци



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хэрэглээний үнийн индексээс махны үнийг хасч тооцвол инфляци 2012 оны 8 дугаар сарын байдлаар 9.7 хувь байгаа бөгөөд сүүлийн гурван жилд нэг оронтой тоонд байжээ. Монголбанкнаас махны үнийг тогтвортой байлгах арга хэмжээ авах, Засгийн газраас махны нийлүүлэлтийг зохицуулах талаарх саналыг удаа дараа хүргүүлж байсан.

Монголбанк үнийн өсөлтийг сааруулах, цаашид мөнгөний нийлүүлэлтээр түүнийг тэтгэхгүй байх, Хүний хөгжлийн сангаас олгож буй бэлэн мөнгө зэрэг эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор 2012 оны 2, 3 дугаар сард мөнгөний бодлогыг чангариуулж, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар 2 удаа өсгөн 13.25 хувьд хүргэж, арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэсэн. Эдгээр бодлогын Үр дүнд 20 хувь хүртэл өсч болзошгүй байсан инфляцийн түвшин буурч, 1 дүгээр улирлаас 1.7 нэгж хувиар буурсан бөгөөд цаашид мөн буурахаар байна.²

Хүснэгт 1.1. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн үндсэн үзүүлэлтүүд (хугацааны эцэст, өөрөөр заагаагүй бол өөрчлөлтийн хувь)

Үзүүлэлт	VIII.2010	VIII.2011	VIII.2012	VIII.2012 VIII.2011
Инфляци (жилийн өөрчлөлт)				
УБ хотын	11.1	7.0	15.6	
Мөнгөний нийлүүлэлт (тэрбум төгрөг)	3657.5	5903.2	6997.1	18.5
M1 мөнгө	932.0	1653.8	1681.1	1.7
Бараг мөнгө	2725.4	4249.5	5316.1	25.1
Нөөц мөнгө	738.6	1289.8	1943.1	50.7
Зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж)				
Төгрөгийн зээлийн нэрлэсэн хүү	20.4	17.2	18.3	
Валютын зээлийн нэрлэсэн хүү	14.0	12.7	14.1	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк сарын мэдээ

² Монголбанк, МБСГ-ын инфляцийн төсөөлөл

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг баримтална.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь Монгол Улсын макро эдийн засгийн суурь нөхцөл, гадаад эдийн засгийн орчны өөрчлөлт, валютын захын нөхцөл байдалтай нийцэн уян хатан тогтох байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш оны эхэнтэй харьцуулахад 2012 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1.16 хувиар чангач 1381.99 төгрөгт хүрчээ. Тайлант хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.01 хувиар чангач, 0.83 хувиар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.17 хувь байв.

Зураг 1.2.1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.2.2: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Валютын ургалын нийт эргэлтийн хэмжээ тайлант хугацаанд 2011 оны мөн үеэс 13 хувиар өсчээ. Гэхдээ валютын цэвэр ургалын хэмжээ 205.3 сая ам.доллартай тэнцэх хэмжээний сөрөг үлдэгдэлтэй байгаа нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 517.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээгээр буурсан байна.

Ийнхүү оны эхний 8 сард эдийн засгаас цэвэр дүнгээр гадаад валют гадагшилсан нь нэгд, экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн уналтаас шалтгаалж Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл оны эхнээс 10.5 хувиар муудсан, хоёрт, гадаад секторын тодорхой бус байдал, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд гарсан өөрчлөлт, улс төрийн нөхцөл байдалтай уялдан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ оны эхний 7 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 883 сая ам.доллараар буюу 31 хувиар татарсан, гуравт, ургал тэнцлийн алдагдал оны эхний 7 сард 1829 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 24 хувиар өссөн зэрэгтэй шууд холбоотой байна.

Монголбанк төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр валютын захын үйл ажиллагаанд шаардлагатай үед оролцон зохицуулалт хийсээр байна. Тухайлбал, валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны, түр зуурын шинжтэй зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтвортжуулах зорилгоор тайлант хугацаанд 71 удаагийн валютын дуудлага худалдаагаар нийт 732 сая ам.доллар, 1.3 тэрбум юанийг валютын захад нийлүүлэв.

Монголбанк шаардлагатай үед юанийн спот захад оролцох нөхцлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ банкуудтай валютын своп, форвард хэлцлүүдийг хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг бууруулах, ханшийн зөв хүлээлтийг төлөвшүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах зэрэг ач холбогдолтой болж байна.

1.3 Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор Засгийн газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлнэ.

Макро зохистой бодлогын тогтолцоог сайжруулах чиглэлээр Монголбанкны захирал, мэргэжилтнүүд 2012 оны 03 дугаар сарын 22-23-ны хооронд ОУВС-гийн Ази номхон далайн орнуудын бүс нутгийн уулзалтанд оролцож, бүс нутгийн орнуудад макро зохистой бодлогыг хэрэгжүүлж буй туршлагыг солилцож, макро зохистой бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг судалсан.

ОУВС-аас олон улсын хэмжээнд явуулсан судалгааны үр дүн, нийтэд түгээсэн судалгааны үр дүн зэргийг үндэслэн Монголбанк өөрийн оронд хэрэгжүүлж болох макро зохистой хэрэгслүүдийн жагсаалтыг гарган Захирлуудын зөвлөлд хэлэлцүүлсэний үндсэн дээр тохиромжтой хэрэгслүүдийг сонгож, холбогдох арга хэмжээг шаардлагатай үед нь авч ажилласан. Тухайлбал, Заавал байлгах нөөцийн хувийг 1 хувиар нэмэгдүүлэх, 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцааны доод хэмжээг 25 хувь, өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцааг 7 хувиар тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг дурьдаж болно. Эдгээр арга хэмжээ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогыг нэвтрүүлэх хүрээнд банкны системийн хувьд динамик эрсдэлийн санг байгуулах тооцоо хийж, динамик

эрсдлийн санг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг судлах, Монголд хэрэгжүүлэх талаар санал боловсруулах зэрэг ажлуудыг хийж байна.

Макро эдийн засгийн бодлого зохистой байх гол үндэс нь төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг бусад макро бодлогын хамт цогцоор нь хэрэгжүүлж, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийн гол суурь болгох явдал билээ. Мөнгө, төсвийн бодлогын харилцан уялдааг хангах зорилгоор төсвийн бодлогын төлөвийг тооцох судалгааны ажлыг хийж, мөнгөний бодлогын тооцоо судалгаанд ашиглаж байна. Төсвийн бодлого мөчлөг дагаж, төсвийн алдагдал өндөр байгаа нь макро эдийн засгийн бодлого үр ашигтай байх нөхцлийг бүрдүүлэхгүй байгаа болон төсөв мөнгөний бодлого харилцан уялдаатай байх талаар санал боловсруулан Засгийн газарт удаа дараа хүргүүлсэн.

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

2.1 Эдийн засаг, санхүүгийн салбарын түргэн өсөлт, бизнесийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн банкуудын чадавхийг дээшлүүлнэ. Банкны салбарын тогтвортой байдлыг дэмжих хяналт шалгалтын олон улсын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлэх арга хэмжээг ургэлжлүүлнэ.

Банкны эрсдэл даах чадварыг дээшлүүлж, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 404 дүгээр тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 16.0 тэрбум төгрөг болгосон. Уг шаардлагыг банкууд 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ханган ажиллах шаардлагатай бөгөөд 2012 оны 8 дугаар сарын байдлаар нийт 8 банк уг шаардлагыг хангаад байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний дээрх шаардлагад хүрээгүй байгаа бусад банкуудаас төлөвлөгөө гаргуулан авч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2012 оны 8 дугаар сарын байдлаар нийт 9 банкинд газар дээрх иж бүрэн шалгалт хийж активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөрийн чадварын байдлыг шалган, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг газар дээр нь баталгаажуулсан. Түүнчлэн 3 банкинд хийсэн хэсэгчилсэн шалгалтаар өөрийн хөрөнгийн хүрэлцээг шалгаж, зарим банкуудад өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавьсан.

Түүнээс гадна өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор хяналт шалгалтын дунд хугацааны хөтөлбөрийг 2 банкинд хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөр энэ оны 12 дугаар сард дуусгавар болох юм.

Олон улсын төлбөр тооцооны банкны дэргэдэх Базелийн санхүүгийн тогтвортой байдлын хорооноос гаргасан Basel III-ын шаардлагуудыг судалж, Макро зохистой бодлогын арга хэрэгслүүдтэй уялдуулан банкуудад нийцтэй байдлаар мөрдүүлэх үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн A/45 дугаар тушаалаар системийн нөлөө бүхий банкуудын жагсаалтыг баталсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 726 дугаар тушаалаар системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн нэмэгдүүлэн тогтоосон бөгөөд тайлант сарын байдлаар нэг банк уг шаардлагыг хангаж ажиллаагүй байсанд холбогдох арга хэмжээг авч, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

Санхүүгийн зах зээл өргөжиж тэлэхийн хэрээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ санхүүгийн хэрэгсэл олноор бий болж байгаатай уялдан банкны бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг сайжруулж, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх шаардлагатай болж байна. Иймд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг өөрийн орны банк санхүүгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх үүднээс Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд дотоод, гадаадын зөвлөхүүдтэй хамтран 2012 оны 3 дугаар сараас эхлэн ажиллаж байгаа бөгөөд арилжааны банк, Сангийн яам болон Монголбанкны газар, хэлтсийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Монголбанк зээлийн барьцаа хөрөнгөтөй холбоотой тулгамдаж байгаа эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Банкуудын хуульчдын холбоотой хамтран нэр бүхий 7 хуульд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг оруулах шаардлагатай болохыг судалж эхний шатны төслийг боловсруулаад байгаа бөгөөд цаашид уг төслийг Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн хүрээнд боловсруулж намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлагдсантай холбогдуулан зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн секторт шилжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор хуулийн дагуу эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зээлдэгчийн зөвшөөрлийг авах, олон нийтэд зээлийн мэдээллийн сангийн хувийн тогтолцооны талаар таниулах зэрэг ажлуудыг хийж байна.

Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөжүүлж, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулж байна. 2012 оны 8 дугаар сарын байдлаар нийт 14 банк болон 85 бичил санхүүгийн байгууллага буюу 74 банк бус санхүүгийн байгууллага, 8 хадгаламж зээлийн хоршоо, 3 санхүүгийн түрээсийн компанийтай мэдээлэл солилцож байна.

2.2 Банкны удирдлагыг сайжруулан үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжин, санхүүгийн хариуцлагыг ондөржүүлнэ.

Банкуудын үйл ажиллагааг нийтэд ил тод болгох, Банкны тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд банкуудын цахим хуудсан дахь мэдээллийг сар бүр хянан баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд энэхүү хяналттай холбоотой үйл ажиллагааны нэгтгэлийн тайланг улирал бүр удирдлагуудад танилцуулж хэвшээд байна.

Банкны зохистой засаглалын шилдэг туршиллагыг нэвтрүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангах үүднээс “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын биелэлтийг жайлд 2 удаа тогтмол үнэлэхээс гадна газар дээрх иж бүрэн шалгалтаар удирдлага зохион байгуулалт, мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын шалгалтыг хийж, үнэлгээ өгч байна. Энэ хүрээнд банкуудын 2011 оны жилийн эцсийн болон 2012 оны эхний хагас жилийн байдлаарх зохистой удирдлагын үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

2.3 Хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангана.

“Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дуусч байгаатай холбогдуулан хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулагдаж, Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг 2011 онд эцэслэн боловсруулсан. Хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн бариад байсан бөгөөд шинэ УИХ байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулж, өргөн барихаар төлөвлөж байна.

Мөн түүнчлэн 2012 оны 6 дугаар сард Мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд заасан шимтгэлийг татан төвлөрүүлэхтэй холбоотой асуудлуудын талаар арилжааны банкуудын удирдлагуудтай уулзалт хийсэн бөгөөд банкууд Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөлд Монголын банкны холбоогоор дамжуулан санал өгөхөөр болсон.

Уг хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, харилцагчдын хөрөнгийг хамгаалж, банкны салбарын эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой бөгөөд энэ ажлын хүрээнд банкууд дахь хадгаламжийн холбогдох судалгааг улирал бүр хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлж байна.

2.4 Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх бололцоог өргөтгөж, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

Монголбанк Санхүүгийн зохицуулах хороон дээр байгуулагдсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд хуулийн төслийг урьдчилсан байдлаар боловсруулан, Банкны холбоо, банкуудын төлөөлөл, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн зөвлөх болон Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагуудтай хуулийн үзэл баримтлал болон зөвлөхийн боловсруулсан санал зэргийг хэлэлцэж, цаашид хуулийн төслийг улам боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа тэлэхийн хэрээр банкны байгууллага оролцсон санхүүгийн нэгдлүүд нэмэгдэх хандлагатай байгаагаас тухайн санхүүгийн нэгдлүүдэд нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэ үүднээс Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын журмын төслийг боловсруулаад байгаа бөгөөд цаашид Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2.5 Гадаадын банкны салбар, нэгжийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас дотоодын зах зээлд ихээхэн зээл олгож, хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа идэвхжиж цаашид улам эрчимжих хандлагатай байна. Иймд гадаадын банк, салбар нэгжийг Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавих зорилгоор “Банкны зөвшөөрлийн журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 06 дугаар сарын 08-ны А-80 дугаар тушаалаар баталсан бөгөөд энэхүү

журамд гадаадын банк нь Монголын нутаг дэвсгэр дээр зөвхөн охин компани хэлбэрээр банкны үйл ажиллагаа эрхэлж болохоор заасан. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-81 дүгээр тушаалаар гадаадын банкны охин компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 65 тэрбум төгрөг байхаар тогтоосон.

Харин гадаадын банкнаас төлөөлөгчийн газар байгуулах үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 07 дугаар сарын 03 өдрийн А-99 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны нэгжийн журам”-аар зохицуулахаар болсон. Түүнээс гадна гадаадын банк, банкны нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан гадаадын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний хязгаарлалт болон банкны нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн ирээдүйн чиг хандлагын талаарх хэд хэдэн судалгааг хийж удирдлагуудад танилцуулсан.

3. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

3.1 Төлбөрийн карт, интернет, мобайл зэрэг бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилана.

Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн Үндэсний брэнд “₮ карт”-ыг нэвтрүүлэх ажлыг Монголбанкнаас зохион байгуулж, Худалдаа хөгжлийн банк, ХАС, ХААН, Хадгаламж, Улаанбаатар, Голомт, Капитал, Капитрон зэрэг банкуудад холбогдох зөвшөөрлийг олгосон. Худалдаа хөгжлийн банк тус картыг 2012 оны 4 сард зах зээлд анх гаргаж, харилцагчийн хүртээл болголоо. Үндэсний төлбөрийн картыг нэвтрүүлсэн нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх, үндэсний үзлийг дээдлэх, Монгол улсыг олон улсад сурталчлан таниулах ач холбогдолтой юм. Цаашид Монголбанк “₮ карт” дээр тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэх, гар уастай холбох зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна. Түүнчлэн, “₮ карт”-ын хэрэглээг дэмжих, сурталчлан таниулах зорилгоор зар сурталчилгаа бэлтгэн телевизийн С1, NTV, Eagle, Боловсрол сувгуудаар түгээсэн. 2012 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 7.0 тэрбум төгрөгийн дүнтэй 133 мянган ширхэг “₮ карт”-ын гүйлгээ хийгдсэн байна.

Монголбанк төлбөрийн картын үйлчилгээг нэгдсэн нэг гарцтай болгох талаар Чайна юнион пэй (CUP) байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. Энэ нь төлбөрийн картын үйлчилгээний шимтгэлийг бууруулах, банкуудын тус тусдаа төлдөг хураамжийн хэмжээг багасгах, төлбөрийн картаар өөрийн орондоо төдийгүй

CUP-ийн гишүүн орнуудад төлбөр тооцоог саадгүй, хямд зардлаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх юм. Голомт, ХААН банкууд CUP карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхэлж байсан бол шинээр Худалдаа хөгжлийн банк тус картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ оны 9 дүгээр сард нэмж аваад байна.

Монголбанк “Банксүлжээ” систем, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны систем болон төлбөрийн картын сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. 2012 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийг дуусталх хугацаанд Үндэсний цахим гүйлгээний төвөөр нийт 449.3 тэрбум төгрөгийн дүнтэй 10.4 сая ширхэг картын гүйлгээ, 323.7 тэрбум төгрөгийн дүнтэй 2.3 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ хийгдэж, Банксүлжээ системээр 48.8 их наяд төгрөгийн дүнтэй 572.2 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ амжилттай боловсруулагдсан байна.

Төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор төлбөрийн системийн оролцогчийн нөөц төв, түүнд тавигдах техникийн зохистой шаардлагыг тодорхойлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-40 дүгээр тушаалаар батлуулж, системийн оролцогчид хүргүүлэв. Түүнчлэн, Төлбөр тооцооны системийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-94 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд системийн оролцогчид өөрсдийн онцгой байдлын төлөвлөгөөг нийцүүлэн шинэчлэхийг үүрэг болгосон.

Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн IX хуралдааны хүрээнд банк, санхүүгийн байгууллагын ажилтнуудад зориулсан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд сэдэвт семинарыг ХБНГУ-ын Төв банктай хамтран зохион байгуулсан. Эдгээр зарчмуудыг Олон улсын төлбөр тооцооны банк, Үнэт цаасны хорооны олон улсын байгууллагаас хамтран 2012 онд шинэчилсэн нь зах зээлийн хэвийн болон хямралын үед ч төлбөр тооцоог найдвартай, тасралтгүй байдлаар гүйцэтгэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдлийн удирдлагыг сайжруулах, Төв банк, эрх бүхий бусад байгууллагын хамтын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой юм.

3.2 Мөнгөний бодлогын зорилго, түүнд хүрэх арга замыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, Төв банкны бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэн инфляцийн хүлээлтэд нөлөөлөх чадамжаа дээшлүүлнэ.

Олон нийттэй харилцах тулгуур зарчмууд (ил тод байдал, Төв банкинд итгэх итгэл, хараат бус байдал, Төв банкны хариуцлага)-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс Монголбанк олон нийттэй харилцах стратегийг томъёолох, холбогдсон нэгжийг хүний нөөцөөр бэхжүүлэхэд анхаарч ажиллав.

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн мөнгөний бодлогын шийдвэр гаргалтаар 2012 онд нийт 6 удаа хуралдах хурлын товыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд урьдчилан зарлав. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүдэд гарсан өөрчлөлтийг тухай бүр олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хурлын протоколыг бүрэн эхээр цахим хуудсанд байршуулах ажлыг эхлүүлээд байна. Мөнгө, ханшийн бодлогоор сэтгүүлчдэд ярилцлага, тайлбар өгөх ажлыг үргэлжүүлэв. Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах ажлын хүрээнд Монголбанкнаас Засгийн газарт мөнгөний бодлоготой холбоотой хүргүүлсэн албан бичгүүдийг ил тод болгох ажлыг эхлүүлэв.

Монголбанк “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн дагуу мөнгөний статистик мэдээлэл болон жилийн тайлангаа Засгийн газарт хүргүүлэх; мөнгө, зээл, санхүүгийн зах зээлийн байдлыг улирал тутам томоохон сонин хэвлэлээр дамжуулан нийтэд мэдээлсээр ирлээ.

Монголбанк цахим хуудасны мэдээ мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангаж ажиллав. Ялангуяа валютын дуудлага худалдаа, Төв банкны үнэт цаасны арилжаа зэрэг мөнгөний бодлогын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг санхүүгийн зах, ард иргэдэд түргэн шуурхай хүргүүлж ажиллав. Цахим хуудасны агуулга, дизайныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлэхийн сацуу “Зээлийн төлөвийн судалгаа”, “Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд” цэсүүдийг шинээр нэмж оруулав. Монголбанкны цахим хаягаар ирсэн иргэдийн асуулт, хүсэлтэд тухай бүр хариу өгөх, зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллав.

Нийгмийн мэдээллийн хэрэгсэл болох Twitter, Facebook хэрэгслүүдэд Монголбанкны хуудсыг нээж олон нийтэд мэдээллийг хүргүүлж эхэллээ. Монголбанкны сарын статистикийн бюллетенийг “IPad” системээр ашиглах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр IPad-н хэрэглэгчид тоо мэдээллийг тохиромжтой хэлбэрээр үзэх, дүн шинжилгээ хийх өргөн боломж нээгдэж байна.

Монголбанкнаас олон нийтийг зорилтот бүлгүүдэд хуваан бүлэг тус бүрт тохирох хамгийн оновчтой сувгуудыг тодорхойлоход анхаарч ажиллав. Тухайлбал, дунд сургуулийн хүүхдүүдэд үнийн тогтвортой байдлын ач холбогдлыг тайлбарлах, их дээд сургуулийн оюутан, санхүүгийн захын оролцогчдод мөнгөний бодлогоор лекц унших, сэтгүүлчдэд улирал бүр сургалт зохион байгуулах зэрэг олон ажлыг зохион байгуулав.

3.3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг Засгийн газартай хамтран авч хэрэгжүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 15 тоот тушаалын дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг 2011 оны 10 дугаар сард хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж Дэлхийн банкны мэргэжилтнүүдээс санал авч 2012 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хуулийн төсөл ФАТФ-ын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор ФАТФ-т хуулийн төслөө хүргүүлсэн. 2012 оны 5 дугаар сард ФАТФ-аас хуулийн төсөл ФАТФ-ын шаардлагад нийцэж байгаа гэдгийг мэдэгдсэн хариу ирүүлсэн. Түүнчлэн, ФАТФ-аас хуулийн төсөлд зарим санал ирүүлснийг хуулийн төсөлд нэмж оруулсан. 2012 оны 6 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын гишүүд, Монголбанкинд хуулийн төсөлд санал авахаар ирүүлсний дагуу 2012 оны 6 дугаар сарын 28-нд Монголбанк хуулийн төсөлд саналыг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. ХЗДХЯ-наас мэдэгдсэний дагуу хуулийн төсөлд өгсөн Засгийн газрын гишүүдийн саналыг нэгтгэж 2012 оны УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүхээр төлөвлөж байна. Монголбанк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийг ФАТФ-т улирал бүр бичгээр болон амаар танилцуулж, тайлagnаж байна.

III. ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА

3.1 ДОТООД МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

3.1.1 Эдийн засгийн өсөлт

ДНБ-ий бодит өсөлт 2009 онд 1.3 хувиар буурч байсан бол 2010 онд 6.4 хувьд, 2011 онд 17.3 хувьд хүрлээ. 2011 оны өсөлтийг 100 хувь гэж үзвэл 41.4 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 42 хувийг үйлчилгээ, 16.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар бий болгосон байна. Бүтээгдэхүүний цэвэр татвар 2011 онд 23.2 хувиар өсөхөд импорт 45.1 хувиар нэмэгдсэнээр НӨАТ, гадаад худалдааны татварын орлого өссөн нь нөлөөлсөн байна. Үйлчилгээний салбараас худалдааны салбар 42.5 хувь, тээвэр агуулахын үйлчилгээ 13.8 хувь, аж үйлдвэрийн салбараас уул уурхай 8.7 хувь, боловсруулах үйлдвэрлэл 16 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт 1: Бодит ДНБ, салбараар, тэрбум төгрөг


	2005	2006	2007	2008	2009	2010	2011*	2012-I хагас жил*
Бодит ДНБ	3041.4	3301.6	3640.0	3964.0	3913.7	4162.8	4881.4	2429.2
Өсөлт, %	7.3	8.6	10.2	8.9	-1.3	6.4	17.3	13.2
Уул уурхайн ДНБ	642.1	676.2	683.8	672.6	711.5	736.9	801.0	394.8
Өсөлт, %	12.1	5.3	1.1	-1.6	5.8	3.6	8.7	9.4
Уул уурхайн бус ДНБ	2399.3	2625.5	2956.1	3291.3	3202.2	3425.8	4080.3	2034.4
Өсөлт, %	6.0	9.4	12.6	11.3	-2.7	7.0	19.1	14.0
Хөдөө аж ахуй	602.1	641.5	734.1	768.4	796.3	664.2	666.4	344.4
Өсөлт, %	11.3	6.5	14.4	4.7	3.6	-16.6	0.3	18.1
Боловсруулах үйлдвэрлэл	175.2	196.7	250.8	257.5	234.3	248.6	288.3	126.7
Өсөлт, %	-19.1	12.3	27.5	2.7	-9.0	6.1	16.0	7.3
Цахилгаан, хий, уур, ус	89.7	92.9	98.8	106.8	113.4	112.8	117.2	66.3
Өсөлт, %	1.1	3.6	6.3	8.2	6.1	-0.5	3.9	5.2
Барилга	81.4	84.8	90.9	78.4	51.7	60.2	68.8	22.1
Өсөлт, %	16.1	4.1	7.2	-13.8	-34.0	16.5	14.3	28.3
Бөөний болон жижиглэн худалдаа	227.5	259.9	274.3	315.5	278.2	387.5	552.1	284.4
Өсөлт, %	3.0	14.3	5.5	15.0	-11.8	39.3	42.5	15.5
Тээвэр ба агуулах	256.7	285.1	356.8	425.5	459.4	491.5	559.1	258.0
Өсөлт, %	23.2	11.0	25.2	19.3	8.0	7.0	13.8	4.4
Мэдээлэл, холбоо	96.3	106.6	132.4	157.6	169.5	180.3	190.8	112.3
Өсөлт, %	21.9	10.7	24.2	19.0	7.5	6.4	5.8	20.8
Үйлчилгээний бусад салбар	558.7	574.7	608.5	701.3	705.5	710.9	770.3	421.0
Өсөлт, %	5.4	2.9	5.9	15.2	0.6	0.8	8.4	9.5
Бүтээгдэхүүний цэвэр татвар	311.7	383.4	409.5	480.2	394.0	569.9	867.4	399.2
Өсөлт, %	1.2	23.0	6.8	17.2	-18.0	44.7	52.2	23.2

*урьдчилсан гүйцэтгэл


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ-ийг эрэлт талаас нь авч үзвэл үндсэн хөрөнгийн хуримтлал 2011 онд 69.9 хувь, хувийн хэрэглээ 13.3 хувиар тус тус нэмэгдсэн нь өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна. Эцсийн хэрэглээ өмнөх онуудын эдийн засгийн өсөлтөд гол хувь эзэлж байсан бол 2010 оноос хуримтлалын хувь өндөр жин эзлэх болсон. Энэ нь өсөн нэмэгдэж байсан гадаадын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал өссөнтэй холбоотой.

Зураг 1: Эдийн засгийн өсөлт, өсөлтийн задаргаа (эрэлт талаасаа)



Зураг 2: Бодит ДНБ-ий бүтэц, 2011 оны эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

2012 оны эхний хагас жилийн байдлаар ДНБ өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өсөв. Бүтээгдэхүүний татвар 23.2 хувь, мэдээлэл холбоо 20.8 хувь, хөдөө аж ахуй 18.1 хувь, худалдаа 15.5 хувь, үйлчилгээний бусад салбар 9.5 хувиар тус тус өссөн нь нийт эдийн засгийн өсөлтийн 78.3 хувийг бүрдүүлсэн байна. 2012 оны эхний хагас жилийн байдлаар бодит ДНБ-ий 44 хувийг үйлчилгээ, 25 хувийг аж үйлдвэр, барилга, 14 хувийг хөдөө аж ахуй, 16 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар тус тус эзэлж байна.

Шигтгээ 1: Эдийн засгийн өсөлтийн боломжийг иргэдэд хүртээмжтэй болгох нь

Манай эдийн засаг 2011 онд оны үнээр 31 хувь, зэрэгцүүлэх үнээр 17.5 хувиар өссөн нь сүүлийн 20 жилд гараагүй өндөр өсөлт билээ. Тэгвэл эдийн засгийн энэхүү өндөр өсөлт иргэдийн амжиргааны түвшин, бодит орлогыг нэмэгдүүлж, нийт иргэдэд тэгш хуваарилагдаж чадаж байна уу? гэдэг нь чухал асуудал юм. Сүүлийн үед “хүртээмжтэй өсөлт” гэдэг ухагдахуун олон улсын түвшинд ихээхэн яригдах болж, эдийн засагчдын анхаарал татсан асуудал болоод байна.

“Хүртээмжтэй өсөлт” гэдэг нь урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох замаар тэгш бус байдал, ядуурлын түвшинг бууруулж, нийгмийн үйлчилгээний хүртээмж, эмзэг бүлгийн нийгмийн хамгааллыг дээшлүүлэхийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, иргэн бүр бүтээмжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж, үр дүнд нь бий болсон эдийн засгийн өсөлтөөс тэгш үр өгөөж хүртэх юм /everyone must be able to share in the process of economic growth and enjoy the fruits of their own contribution to the increase in productivity/. Эдийн засгийн өсөлт нь:

- Ядуурлыг тогтвортой бууруулдаг байх;
- Ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр нэмэгдүүлдэг байх;
- Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлдэг байх (тэгш бус байдал буурах);
- Нийгмийн хамгааллыг нэмэгдүүлж, нийгмийн эмзэг бүлгийнхнийг дэмждэг байх;
- Хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлдэг байх нөхцөлүүдийг хангаж байгаа бол хүртээмжтэй өсөлт болно.

Эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байхын тулд өсөлтийн хурд болон хэмжээ чухал байдаг. Тогтвортой, өндөр өсөлт нь эдийн засгийг томруулж, улмаар хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлдэг. Ингэхдээ эдийн засгийг төрөлжүүлж, олон салбарыг хамарсан үр ашигтай нөөцийн хуваарилалтыг хийх замаар хүртээмжтэй өсөлтийн үр өгөөжийг харьцангуй урт хугацаанд хүртэх боломжтой болох юм. Учир нь өсөлтөөс үр ашиг хүртэж чадахгүй байгаа нийгмийн бүлгийн орлогыг урт хугацаанд нэмэгдүүлэх арга нь орлогын шууд хуваарилалт бус бүтээмжтэй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал байдаг. Өсөлтийг богино хугацаанд нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын эмзэг бүлгийнхэнд үзүүлэх сөрөг үр дагаврыг саармагжуулахын тулд Засгийн газар богино хугацаанд орлогын хуваарилалтын аргыг хэрэглэж болох хэдий ч эдгээр шилжүүлгүүд нь урт хугацааны шийдэл болж чадахгүй.

Хүртээмжтэй өсөлтийг бий болгохын тулд:

- Хүний хөгжлийг дээшлүүлэх;
- Ил тод, хариуцлагатай засаглалыг бий болгох;
- Их хэмжээний хөрөнгө оруулалтыг дэд бүтцэд зарцуулах;
- Харилцан уялдаа бүхий макро бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хүснэгт 2: Хүртээмжтэй өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлс

Макро нөхцөлүүд	Микро хүчин зүйлс	Хүртээмжтэй өсөлтийн элементүүд
<p>Макро эдийн засгийн тогтвортой байдал;</p> <ul style="list-style-type: none"> • Инфляцийн нам түвшин • Төсөв болон урсгал тэнцлийн бага алдагдал • Өр/ДНБ-ий бага харьцаа <p>Улс төрийн тогтвортой байдал;</p> <p>Гадаад худалдааны нээлттэй байдал;</p> <p>Хүн амын бага өсөлт;</p> <p>Эмзэг бүлгийнхний нийгмийн хамгааллыг сайжруулах;</p> <p>Гол секторууд дэх шууд хөрөнгө оруулалтын өсөлт;</p> <p>Аж үйлдвэржилтийн бодлогууд</p>	<p>Хүмүүн капитал дахь хөрөнгө оруулалт;</p> <ul style="list-style-type: none"> • Боловсрол • Эрүүл мэнд • Нийгмийн хангамж <p>Дэд бүтэц дэх хөрөнгө оруулалт;</p> <p>Нийгмийн үйлчилгээний тэгш бус байдлыг бууруулах;</p> <p>Арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлан гадуурхалтыг багасгах;</p> <p>Үр чадвар, бүтээмжийг сайжруулах;</p> <p>Санхүүгийн үйлчилгээний хүртээмж;</p> <ul style="list-style-type: none"> • Бичил санхүү • ЖДҮ-ийн санхүүжилт • Хөрөнгийн зах 	<p>Урт хугацааны тогтвортой, өндөр өсөлт;</p> <p>Харьцангуй давуу талыг тодорхойлох бүтцийн шилижилт;</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн төрөлжилт • Экспортын диверсификаци • Бизнесийн таатай орчин <p>Эрүүл мэнд, боловсролын тэгш боломж;</p> <p>Абсолют ядуурлын бууралт;</p>

Эх сурвалж: Tony Addison, 2012, "What is Inclusive growth?" Nordic-Baltic MDB


Манай орны хүртээмжстэй өсөлт: Манай орны эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдтай өсч байгаа боловч өсөлтийн хэлбэлзэл өндөр байгаагаас тогтвортой байж чадахгүй байна.

Зураг 3: Эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 4: Дотоодын нийт бүтээгдэхүүн ба Үндэсний нийт орлого



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Нэг хүнд ногдох ДНБ 2011 онд 3.89 сая төгрөг байгаа бол нэг хүнд ногдох YHO 3.56 сая төгрөг байна. Нэг хүнд ногдох ДНБ болон YHO өсч байгаа боловч тэдгээрийн хоорондын зөрүү жил ирэх тусам ихэссээр байна. Энэ нь манай нутаг дэвсгэр дээр бий болж байгаа боловч гадагшилж буй орлого өсч байна гэсэн үг.

Зураг 5: Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 6: Жини индекс



Эх сурвалж: Дэлхийн банк, “Санхүүгийн хямралын Монголын ядуурал, орлогын хуваарилалтад үзүүлэх нөлөө” судалгааны ажил

Ажилгүйдлийн түвшин 2009 оноос хойш буурч байгаа бөгөөд ажилгүйдэл, эдийн засгийн өсөлтийн хооронд сөрөг хамаарал ажиллагдаж байна. Харин тэгш бус байдал эдийн засгийн өсөлтөөс үл хамааран жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Зураг 7: Ядуурал ба Эдийн засгийн өсөлт**Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо****Зураг 8: Ядуурлын мэдрэмж****Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо**

2011 оны байдлаар нийт хүн амын 29.8 хувь нь ядуурлын шугамаас доош орлоготой иргэд байна. Ядуурлын мэдрэмж 2008 оноос хойш тасралтгүй өсч байсан бол 2011 онд 2.8 болж буурсан (энэ нь 2011 онд ядуурлын түүвэр судалгааны аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой) байна. Энэхүү бууралтад хөдөө орон нутаг дахь ядуурлын түвшний бууралт гол нөлөө үзүүлжээ.


Дээрх нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл сүүлийн жилүүдэд манай орны ажилгүйдлийн түвшин буурч, ажил эрхлэлт нэмэгдэж, үйлдвэрлэл өсч, эдийн засгийн өндөр өсөлттэй байгаа хэдий ч тэгш бус байдал, ядуурлын түвшин төдийлөн буураагүй байгаагаас эдийн засгийн өсөлт төдийлөн хүртээмжтэй байж чадахгүй байгаа нь харагдаж байна. Иймд эдийн засгийн өсөлтийн хэлбэлзлийг бууруулж, тогтвортой бөгөөд хүртээмжтэй болгох арга замуудыг судалж нэвтрүүлэх нь чухал юм.

3.1.2 Инфляци, түүний өөрчлөлт

Үндэсний Статистикийн Хорооноос хэрэглээний үнийн индекс (ХҮИ) тооцох бараа бүтээгдэхүүний сагсыг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн олон нийтэд зарласан.

Тус шинэчилсэн тооцоогоор 2012 оны 8 дугаар сарын эцэст хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оны мөн үеэс 14.9 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 15.6 хувиар тус тус өссөн. Суурь инфляци 8 дугаар сарын байдлаар жилийн 10.1 хувь байв.

Зураг 9: ХҮИ-ийн жилийн өөрчлөлт



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн жилийн өөрчлөлтийг 2012 оны эхний 8 сарын байдлаар авч үзвэл хүнсний бараа бүтээгдэхүүн, тэр дундаа мах, махан бүтээгдэхүүн (63.5%) болон хүнсний ногооны бүлэг (26.3%), мөн бэлэн хувцас (17.4%), зочид буудал, нийтийн хоолны (23.5%) бүлгийн үнүүд хамгийн өндөр хувиар өсөв. 2012 онд инфляцийн хувьд онцлох явдал нь хэдийгээр нийт нутгийг хамарсан зудын нөхцөл байдал үүсээгүй боловч мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдоос үүдсэн үнийн огцом өсөлт байв. 2012 оны эхний улиралд сард дунджаар 14.9 хувь өссөн мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ 2 дугаар улирлаас эхлэн саарч, сард дунджаар 1.7 хувиар өсчээ. Гэвч өмнөх онуудад зуны сард буюу 6, 7 дугаар саруудаас эхлэн ажиглагддаг байсан махны үнийн бууралт энэ жил 8 сараас эхэлсэн нь инфляци өндөр түвшинд хадгалагдахад голлон нөлөөлж байлаа.


Зураг 10: ХҮИ-ийн жилийн өөрчлөлт, бүлгээр



Харин хүнснээс бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт нь харьцангуй эрэлтийн шинж чанартай буюу үүнд төсвийн тэлэлт, цалингийн өсөлт болон эх орны хишиг хувийн нөлөө давамгайлах шинжтэй байв.

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийг бүлгээр нь задалж үзвэл жилийн инфляци 15.6 хувь гарахад 8.1 нэгж хувь нь хүнсний бараа бүтээгдэхүүний бүлгийн үнэ (үүнээс 6.4 нэгж хувь нь мах махан бүтээгдэхүүн), 2.2 нэгж хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ, 2.0 нэгж хувь нь орон сууц, ус, түлш цахилгааны бүлгийн үнийн өсөлт тус тус бүрдүүлж байв.

Зураг 11: Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа, бүлгээр



3.1.3 Инфляци, эдийн засгийн өсөлтийн 2012-2013 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт, инфляцийн төсөөлөлд ашигласан гадаад хувьсагчдын төлөв

Түүхий нефтийн үнэ

Барууны орнууд ба Хятадын өсөлт саарснаар газрын тосны эрэлт буурч 2012 оны эхний хагаст нийт хэрэглээ дорвитой өсөөгүй. Харин сүүлийн саруудад шатахууны жижиглэнгийн үнэ буурсан, олон жилийн дунджийн дагуу хүйтэвтэр өвөл болох төлөвтэй, мөн Япон улс цөмийн эрчим хүчийг шатахуунаар орлуулах хандлагатай болж байгаа тул оны сүүлийн хагаст хэрэглээ өсч 2012 онд 1 хувь, 2013 онд 1.3 хувийн өсөлттэй байхаар байна. Энэ онд Газрын тос экспортлогч орнууд (ОPEC)-ын нийлүүлэлт 6.4 хувиар, улс төрийн тогтвортой байдлын улмаас Иран, Йемен, Өмнөд Суданы нийлүүлэлт саарч 1.6 хувиар өсөх төлөвтэй байна. Түүхий нефтийн нийт нийлүүлэлт 2012 онд 3.5 хувь өсч нийлүүлэлт нь эрэлтээ давна хэмээн судлаачид таамаглаж байгаа юм. Хэдийгээр илүүдэл нийлүүлэлтэй байх ч энэ онд газрын тосны үнэ улс төрийн хурцад мал байдлын улмаас ихээхэн хэлбэлзэлтэй байлаа. Тухайлбал Ираны цөмийн хөтөлбөрийн эсрэг АНУ, Европын холбооноос Ираны эсрэг хориг тавьсан нь улс төрийн

эрсдэлийг нэмэгдүүлсэн тул өнгөрөгч 4 дүгээр сард үнэ огцом өсч WTI брэндийн газрын тосны үнэ 105\$/баррель болсон. Харин дэлхийн эдийн засгийн өсөлт буурснаар газрын тосны үнэ 8 дугаар сард 85\$/баррельд хүрч буурсан бол сүүлийн саруудад Сирийн дотоодын мөргөлдөөн хурцдаж Йемен, Ирак руу дамжин халдвартлах эрсдэл нэмэгдээд байгаагаас нийлүүлэлт саарч газрын тосны үнэ өсөн 9 дүгээр сарын 1-ний байдлаар 96.5\$/баррель болоод байна. Дэлхийн газрын тосны бодит эрэлт сул байх тул цаашид 2012 оны сүүлээр WTI газрын тосны үнэ 94\$/баррель, 2013 онд 99.2\$/баррель болно хэмээн судалгааны байгууллагууд таамаглаж байна. 2014-2016 онд эрэлт сэргэж жилийн 2 хувийн өсөлттэй байх төлөвтэй байна.

Зэсийн үнэ

2012 оны эхний улиралд 8445\$/тн байсан зэсийн үнэ 2 дугаар улирлаас эхлэн Хятад, АНУ-н өсөлт саарч Евро бүсийн хямрал гүнзгийрч байгаагаас бууран 5 сард 7434\$/тн болсон. Цаашид нөхцөл байдал дээрдэхгүй гэж үзсэн зарим судалгааны байгууллагууд 2012 оны үнийн төсөөллөө удаа дараа бууруулаад байна. 2012 оны сүүлийн хагаст зэсийн үнэд ам.долларын ханшийн чангарталт, Хятадын барилгын салбарын уналт сөргөөр нөлөөлөх боловч Төв банкууд мөнгөний төлөвийг сулруулж байгаа, Хятадын Төв банк хүүний түвшинг бууруулж байгаа зэрэг нь зэсийн үнийг ялимгүй дэмжихээр байна. 9 дүгээр сарын 1-ний байдлаар тонн зэс 7606 ам.доллар/тн байгаа бол оны эцэс рүү бага зэрэг өсөх хүлээлттэй байна. 2012 онд Хятадын эдийн засаг хамгийн багадаа 6 хувь өснө гэж тооцвол зэсийн эрэлт 2.9 хувь, нийлүүлэлт 2.8 хувиар өсөх ба зах зээлд 146 мянган тонн зэсийн илүүдэл бий болох магадлалтай учир зэсийн үнэ оны эхний түвшинд хүрэхээргүй байна. Харин Евро бүсийн өсөлт 2013 оноос сэргэж эхэнэ гэвэл зэсийн эрэлт 4.7 хувь нэмэгдэж, зах зээлд 56 мянган тоннын дутагдал үүсч зэсийн үнийг дэмжин 8456\$/тн-д хүргэх боломжтой хэмээн таамаглаж байна. Гэвч аж үйлдвэрийн зогсонги байдалтай уялдан дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ буурах хандлага илүү давамгайлах магадлалтай юм.

Алтны үнэ

Нэг унц алтны үнэ 2012 оны эхэнд 1692\$ байсан ч түүнээс хойш буурч 9 дүгээр сарын 1-ний байдлаар 1626\$-т хүрээд байна. Учир нь Евро бүсийн хямрал гүнзгийрч байгаагаас хөрөнгө оруулагчид бага эрсдэлтэй үнэт цаас буюу АНУ-н засгийн газрын бондод хөрөнгөө ихээр байршуулж байгаа нь ам.долларын ханш бусад голлох валютын эсрэг чанграх үндэс болжээ. Ам.доллар чангарснаар алтны үнэ 7, 8 дугаар саруудад буурсан байна. Харин эдийн засгийн өсөлттөө дэмжих зорилгоор АНУ-ын Холбооны нөөцийн банк Хятад болон Европын холбооны нэгэн адил мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тохиолдолд ам.долларын ханш суларч алтны үнэ өсөх боломжтой. Түүнчлэн оны сүүлийн хагас жил, 2013 онд эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, хүүгийн түвшин доогуур байхаар байгаа нь бизнес эрхлэгчид хөрөнгөө алтанд ихээр байршуулж

алтны эрэлтийг нэмэгдүүлэхээр байна. Иймд 2012 онд алтны нийт хэрэглээ 3.1 хувь, 2013 онд 3 хувиар тус тус өснө хэмээн EIU-н судлаачид үзж байна. 2011 онд олборлолтой холбоотой асуудлуудын улмаас алтны нийлүүлэлт буурч байсан бол 2012 онд нийлүүлэлт сэргэж 3 хувиар өсөх бөгөөд цаашид алтны олборлолт нэмэгдэх төлөвтэй байна. Иймд эрсдэлийн эсрэг баталгаа, үнэ цэнийг хадгалах хэрэгсэл болох алтны эрэлт 2012, 2013 онд өндөр байх нь алтны үнийг дэмжих боловч нийлүүлэлт сэргэж зах зээлд илүүдэл бий болохоос гадна 2013 оны сүүлийн хагаст эдийн засаг сэргэмэгц хөрөнгийн урсгал илүү ашигтай салбар руу чиглэх тул алтны үнэ буурах магадлалтай юм. Bloomberg болон EIU-н тооцоолж байгаагаар 2012 оны сүүлээр 1 унц алтны үнэ 1670\$ болж өсөх бол 2013 оны сүүлээр 1557\$-д хүрч буурахаар байна.

Нүүрсний үнэ

Хятадын эдийн засаг, аж үйлдвэрийн өсөлт саарч, АНУ тэргүүтэй орнууд байгалийн хий, усан цахилгаан станц зэрэг байгальд илүү хор багатай эрчим хүчийг ихээр хэрэглэж байгаагийн дээр Энэтхэг болон бусад орнуудын эрэлт буурснаар нүүрсний нийт эрэлтийн өсөлт саарч 2012 оны эцсийн байдлаар 2 хувьд хүрнэ хэмээн судлаачид үзж байна. Харин энэ онд нүүрсний хэрэглээгээ нэмэгдүүлэх гол бүс нь Евро бүс болоод байна. Учир нь нүүрс байгалийн хийнээс үнийн хувьд хамаагүй хямд тул Европчуудад илүү ашигтай юм. 2013 оноос дэлхийн эдийн засаг сэргэж, АНУ-н байгалийн хийн үнэ нэмэгдмэгц нүүрсний эрэлт эргээд сэргэж 2013-2014 онд 3.8 хувиар өсөхөөр байна. Гэсэн хэдий ч Хятад эрчим хүчиний салбартаа шинэчлэлт хийж, сэргээгдэх эрчим хүчинд анхаарлаа хандуулж эхлээд байгаа нь нүүрсний эрэлтийг 2008 оны өмнөх хэмжээнд хүргэж өсгөхөөргүй байна. Нүүрсний эрэлтийг дагаад 2012 оны эхнээс үнэ буурч байгаа тул энэ онд нүүрс олборлогчид үйлдвэрлэлээ ихээр нэмэгдүүлэхгүй байх төлөвтэй. 2011 онд нүүрсний нийлүүлэлт 5.8 хувиар өсч байсан бол 2012 онд 3.3 хувь болж буурахаар байна. 2013 оноос эрэлт нэмэгдэхээр дагаад нийлүүлэлт нэмэгдэж, өсөлт нь 3.6 хувь болохоор байна. Ерөнхийдөө 2012 онд зах зээлд илүүдэл бий болох тул 8 дугаар сарын 1-ний байдлаар 83.25\$/тн байгаа эрчим хүчиний нүүрсний үнэ хамгийн ихдээ 93\$/тн болох, 2013-2014 онд эрэлт сэргэхээр 97\$/тн болно хэмээн Bloomberg-н судлаачид таамаглаж байна.

Зураг 12: Түүхий эдийн үниийн индекс (2010=100хувь) Зураг 13: Түүхий эдийн үниийн өсөлт (%)




Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Инфляцийн төсөөлөл

Нийлүүлэлтийн талын хүчин зүйлс, түүн дотор махны үнийн нөлөөгөөр Улаанбаатар хотын жилийн инфляци 2012 оны эхний 4 сард тасралтгүй өсч 17.8 хувьд хүрсэн ч, 6, 7 дугаар саруудад дараалан буурсаар 14.9 хувьд хүрээд байна. Харин 8 дугаар сард хүнсний үнэ, түүн дотор маx, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ буурсан хэдий ч, боловсролын үйлчилгээ болон орон сууц, цахилгаан, түлшний үнийн өсөлтөөс шалтгаалан жилийн инфляци яламгүй өсч 15.6 хувьд хүрчээ.

2012 оны 3 дугаар улирлаас 2013 он дуустал жилийн инфляцийн төсөөлөл, түүний итгэх мужийг доор харуулав.

Зураг 14: Жилийн инфляцийн төсөөлөл



Эх үүсвэр: Монголбанкны тооцоо

Энэ онд Улаанбаатар хотын жилийн инфляци 12.3 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 11.6-16.5 хувийн хооронд, 2013 оны эцэст 7.0 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 2.1-11.4 хувийн хооронд байхыг илтгэж байна. Төсөөллийг мөнгөний бодлогын одоогийн төлөв өөрчлөгдөхгүй гэсэн таамаглал дээр үндэслэн тооцлов.

Ирэх саруудад төрийн зохицуулалттай зарим бараа болох дулаан, цахилгааны үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа хэдий ч, махны үнэ буухаар байгаа тул нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг нийлбэр дүнгээрээ бууруулахаар байна. 2012 оны сүүлийн хагас жилд цалин болон төсвийн зардлын өсөлт үнийн өсөлтийг дагуулах

хэдий ч эрэлтийн шалтгаантай инфляцийг эрчимжүүлэхээргүй байна. Энэ нь сүүлийн хагас жилд сар бүр иргэдэд олгож байсан мөнгөн тэтгэмж зогссон, хөрөнгийн дотогшлох урсгалын өсөлт буурч мөнгө, зээлийн үзүүлэлт хумигдаж байгаа нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурах нөхцөл болохоор байгаа юм.

Харин ирэх оны хувьд инфляцийн дарамт харьцангуй багасах төлөвтэй байна. Инфляци ийнхүү буурахаар хүлээгдэж буй нь голчлон эрэлтийн шалтгаантай инфляцийн хүлээлт бага байгаатай холбоотой. Тухайлбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ирэх оноос хэрэгжиж эхэлснээр төсвийн хурдтай тэлэлт саарах, Евро бүсийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаагаас хөрөнгийн дотогшлох урсгал болон гадаад эрэлт эрчимжихээргүй байгаа зэрэг нь мөнгөний болон эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулахаар байна. Гэхдээ энэхүү нөхцөл байдал нь шинэ Засгийн газраас төсвийн хэт тэлэх бодлого явуулахгүй байх тохиолдолд л биелэх боломжтой юм.

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

2012 оны сүүлийн хагас жилд уул уурхай, аж үйлдвэр, тээврийн салбарын өсөлт оны эхний хагас жилтэй ойролцоо байх бол нийт эрэлтийн бууралттай холбоотойгоор бөөний ба жижиглэн худалдаа, үйлчилгээний салбаруудын өсөлт буурахаар байна. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт оны сүүлийн хагас жилд мөн өндөр байхаар хүлээгдэж байгаа бөгөөд 2012 оны эдийн засгийн өсөлтөд тус салбар өндөр хувь нэмэр оруулахаар байна. Нийт дүндээ эдийн засгийн өсөлт 2012 оны эцэст өмнөх оноос буурч 12-14 орчим хувьтай байхаар байна.

Эрэлтийн талын хүчин зүйлсээс хувийн хэрэглээ, засгийн газрын зардал нэмэгдэж байна. Хувийн хэрэглээний өсөлтөд төрийн албан хаагчдын нэрлэсэн цалинг 80000 төгрөг, 23 хувиар өсгөснөөр өрхийн орлого нэмэгдсэн, хэрэглээний зээлийн өсөлт оны эхний хагаст өндөр байсан зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Төсвийн зарцуулалт батлагдсан төсвийн 70 хувьтай тэнцэх гүйцэтгэлтэй байгаа боловч өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсөөд байна. Харин гадаад худалдааны алдагдал экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалан оны сүүлийн хагаст улам нэмэгдэхээр байна.

2013 онд Оюу толгойн орд үйл ажиллагаагаа эхлэхтэй холбоотойгоор алт, зэсийн үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарт огцом өсөлт гарахаар хүлээгдэж байна. Тус салбарыг даган тээврийн агуулах, цахилгаан, дулаан зэрэг салбаруудын өсөлт мөн нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт 2013 оны эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулах хэдий ч гадаад эдийн засгийн таагүй нөхцөл бүрэн арилахааргүй байгаагаас экспортын орлого, төсвийн орлого, цаашлаад нийт эрэлт буурч, үйлчилгээний салбарын өсөлт буурах хандлагатай байна.

Төсөөллийн тодорхой бус байдал

Суурь төсөөллийг өөрчилж болзошгүй дараах гадаад болон дотоод эрсдэлүүд байгааг дор товч тайлбарлав.

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн тодорхой бус байдал: Суурь төсөөллийн үндсэн эрсдэл нь дэлхийн эдийн засгийн төлөвийн тодорхой бус байдал болж байна. 2011 оны сүүлч, 2012 оны эхнээс хөгжингүй орнуудын санхүүгийн хямрал гүнзгийрч, түүхий эдийн томоохон хэрэглэгч Хятадын өсөлт саарч байгаа нь манай улсын экспортын гол түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлөх, цаашлаад экспортын орлогыг бууруулах эрсдэлтэй. Түүнчлэн дэлхийн санхүүгийн хямрал гүнзгийрвэл гадаадын хөрөнгө оруулалт буурч, эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засгийн бодит сектор, үйлдвэрлэлийг бууруулах замаар манай эдийн засгийн өсөлт, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулах болно.

Экспортын гол нэрийн барааны үнийн тодорхой бус байдал: Хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтийн сааралт нэмэгдэж, улмаар уналтад орвол Хятадын экспортын эрэлт хумигдаж дэлхийн зах зээл дээр зэс, нүүрс, төмрийн хүдрийн эрэлт, үнэ буурах болно. Үүний нөлөөгөөр манай орны хувьд зэсийн экспортын үнэ, орлого буурч 2008-2009 оны хямралын нөхцөл байдал дахин давтагдаж ч болзошгүй эрсдэлтэй байна.

2013 оноос хэрэгжиж эхлэх “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн төсвийн зарлагын хязгааруудыг хангахгүйгээр төсвийг батлах эрсдэл: “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн хүрээнд хийгдсэн Төсвийн дунд хүрээний мэдэгдлийн зарлагын дүнгээс хэтрүүлэх, батлагдсан төсвөөс гадуурх зардал нэмэгдэх эрсдэл өндөр байна. Үүнд концессийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүд болон Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх хөгжлийн баримжаатай төсөл, хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой төсвийн хөрөнгийн зардал эрс нэмэгдэх эрсдэлтэй байна. Ийм төсвийн зардлын өсөлт нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг улам эрчимжүүлэх болно.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдсоноос үнэ өсөх эрсдэл: Хэрэглээний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн, тэр дундаа махны нийлүүлэлтийн өөрчлөлт инфляцид богино хугацаанд хүчтэй нөлөө үзүүлдэг. Энэ жил олон жилийн дунджаас илүү хүйтэн өвөл болохоор байгаа болон хувийн секторын мах экспортлох хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотойгоор Улаанбаатар болон бусад томоохон хотын махны нийлүүлэлт бидний тооцоолсноос илүү хэмжээгээр буурч, улмаар үнэ өсөх эрсдэлтэй байна. Үүний нөлөөгөөр нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн дарамт нэмэгдэх болно.

Төрийн зохицуулалттай бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх эрсдэл: Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж байгаагаас төрийн зохицуулалттай 10 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдээд байна. Тухайлбал цалин хөлсний үнийн өсөлтөөс шалтгаалан боловсролын үйлчилгээ, сургалтын төлбөр, шатахуун, нүүрсний үнийн өсөлтөөс шалтгаалан цахилгаан, дулааны үнийг 2012-2013 онд жилд дунджаар 15-20 хувиар өсгөх шаардлагатай байгаа талаар төрийн холбогдох байгууллагаас тооцсон байна. Иймд төрийн зохицуулалттай зарим бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлтэй.

Шатахууны үнэ өсөх эрсдэл: Шатахууны үнэ өсөх дараах хоёр төрлийн эрсдэл байна. Нэгд, улс төрийн тогтвортгүй байдлаас шалтгаалан нефть экспортлогч зарим орны нийлүүлэлт буурснаар дэлхийн зах зээлд түүхий нефтийн үнэ нэмэгдэх тохиолдолд ОХУ нефтийн бүтээгдэхүүнийхээ экспортын татварыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Үүний нөлөөгөөр дотоодын захад шатахууны үнэ өсч, инфляцийн дарамтыг нэмэгдүүлэх болно. Хоёрт, гадаад эдийн засгийн таагүй нөхцөл байдлын улмаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах эрсдэл өндөр байгаа нь шатахууны төгрөгөөр илэрхийлэгдэх үнийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

3.1.4 Мөнгөний нийлүүлэлт, түүний өөрчлөлтийн шалтгаан


Мөнгөний үзүүлэлтүүд ба инфляци

Улирлын зохицуулалт хийгдсэн M1 болон M2 мөнгөний жилийн өсөлт 2011 оны 8 дугаар сараас хойш саарсаар 2012 оны 8 дугаар сарын байдлаар харгалзан 3.3 хувь, 17.9 хувьд хүрээд байна. Мөнгөний үзүүлэлтүүд ийнхүү буурах болсон нь дотоод эдийн засгийн идэвхжил супарч, гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал буурснаас голлон шалтгаалав. Тухайлбал, бодит эдийн засгийн өсөлт 2012 оны эхний 2 улирлын байдлаар хүлээгдэж байсан түвшнээс бага буюу 13.2 хувь гарсан, 2012 оны эхний 8 сарын байдлаар төсвийн орлогын төлөвлөгөө 17 орчим хувиар тасарсан, төлбөрийн тэнцлийн хөрөнгө санхүүгийн тэнцлийн ашиг 2012 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 47 хувиар буурчээ.

Хүнсний бус жилийн инфляцийн өсөлт 2012 оны 4 дүгээр сараас эхлэн саарч, 8 дугаар сарын байдлаар 10.7 хувьд хүрээд байгаа нь өмнөх онуудад ажиглагддаг байсан мөнгөний мөчлөгийн оргил үеэс 8-9 сарын дараа хүнсний бус жилийн инфляци хамгийн өндөр түвшинд хүрч цааш нь буурдаг зүй тогтол хадгалагдаж байгааг илтгэж байна. Хэрвээ энэ хамаарал цаашид үргэлжилнэ гэж үзвэл хүнсний бус жилийн инфляци цаашид ч буурах хандлагатай юм.

Мөнгөний шинжилгээнд өргөн хэрэглэгддэг инфляцийн хөтөч үзүүлэлтүүд (бодит M2 мөнгөний илүүдэл (дутагдал) болон бодит M2 мөнгөний зөрүү³-ийг тооцон үзүүлэв. Манай улсын эдийн засагт 2012 оны эхний 8 сард бодит M2 мөнгөний эрэлт нь нийлүүлэлтээсээ дунджаар 4.4 хүртэл хувиар давсан нь эдийн засаг дахь хүүний хэмжээ өсөх суурь нөхцөл болов. Ингэснээр эдийн засаг дахь мөнгөний ерөнхий төлөвийг хатууруулж байгаа тул эдийн засгийн хэт халалт буурах, эрэлтийн гаралтай инфляцийн дарамт багасах нөхцөлийг бүрдүүлж байна.

**Зураг 15: Улирлын зохицуулалт хийгдсэн M1, M2 мөнгөний жилийн өсөлт ба хүнсний бус инфляци
а. M1 мөнгө ба инфляци
б. M2 мөнгө ба инфляци**




Бодит M2 мөнгөний зөрүү нь мөнгөний нийлүүлэлт эдийн засгийн урт хугацааны тэнцвэрт үеийн мөнгөний эрэлтээс хэр зөрүүтэй байгааг илэрхийлдэг. Зургаас харахад тус үзүүлэлт 2011 оны 4 дүгээр сараас хойш тасралтгүй буурсан бөгөөд 2012 оны 8 дугаар сарын байдлаар-2.8 хувь орчимд байна. Энэ нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт нь урт хугацааны тэнцвэрт утгаас буусан байгааг илэрхийлж байгаа тул цаашид хэрвээ энэ байдал хадгалагдана гэж үзвэл эдийн засгийн болон мөнгөний мөчлөгөөс инфляцид үзүүлэх дарамт бага байх болно.

Эмпирик тооцооны үр дүнгээр бодит M2 мөнгөний илүүдэл (дутагдал), бодит M2 мөнгөний зөрүү нь жилийн инфляцид 5-6 сарын хоцролтой нөлөөлдөг байна. Иймд эдгээр үзүүлэлтүүд буурсаар байгаа өнөө үед 2012 он дуустал эрэлтийн шинж чанартай инфляцийн дарамт бага байх боломжтойг харуулж байна.

Дээрх бүх үр дагаврууд бодит байдал дээр илрэх эсэх нь цаашид мөнгөний агрегатууд хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарна. Харин төсвийн тодотгол болоод зээлийн өсөлтийн хандлагаас хамаараад дотоод эх үүсвэрээр мөнгөний нийлүүлэлт хэр нэмэгдэх нь тодорхойлогдохоор байна. Сүүлийн үеийн мэдээгээр Хөгжлийн банк татан төвлөрүүлсэн эх үүсвэрээсээ эргэлтэнд оруулж эхлээд байгаа (УБ хотын замыг сайжруулах төслүүдэд зориулж 100 тэрбум төгрөгийг олгохоор болсон) нь мөнгөний захын идэвхижилт, эдийн засгийн тэлэлтийг тэтгэх бодит алхам болж байна.

³ Мөнгөний агрегатуудад сууриссан хөтөч үзүүлэлтүүд нь дунд, урт хугацааны инфляцийн төлөвийн талаарх чухал мэдээллийг өөртөө агуулдаг. Мөнгөний шинжилгээнд сууриссан хөтөч үзүүлэлтүүд нь эдийн засгийн мөчлөг, санхүүгийн зах зээл дээрх өөрчлөлт болон мөнгөнд агуулагдах нэмэлт мэдээллийг өөртөө нэгэн зэрэг агуулдгаараа онцлогтой.

Зураг 16: Бодит M2 мөнгөний илүүдэл (дутагдал) болон бодит M2 мөнгөний зөрүү
а) Бодит M2 мөнгөний илүүдэл (дутагдал) **б) Бодит M2 мөнгөний зөрүү**



Шигтгээ 2: Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ

Глобал эдийн засгийн болон санхүүгийн шокууд илүү өндөр давтамжтай болж, хөгжиж буй орнуудын эдийн засаг, санхүүгийн зах зээлд олон суваг (худалдаа, санхүүгийн хөрөнгийн урсгал болон хөрөнгө оруулалт)-аар дамжин богино хугацаанд тархах болсон. Түүнчлэн институци, засаглал нь сул, макро эдийн засгийн харилцан уялдаагүй бодлого нь эдийн засгийг гадаад шоконд илүү өртөмтгий болгож, хямралд хөтөлдөг болохыг өмнөх хямралууд харуулсан. Газар зүйн байршил, эдийн засгийн бүтцээс хамаарсан “төрөлх”-ийн эмзэг байдал өндөртэй орны хувьд дархлааг сайжруулан глобал сөрөг шокийг хохирол багатай даван туулах чадамжийг сайжруулах нь туйлаас чухал юм. Европын холбооны зарим улсуудын өрийн хямрал, Ойрхи дорнод дахь улс төрийн тогтвортгуй байдлаас үүдэлтэй глобал эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа энэ үед дотоод эдийн засгийн эмзэг байдлыг тогтмол судалж, түүнд үндэслэн эдийн засгийн дархлаа, чадамжийг сайжруулах чиглэлд холбогдох арга хэмжээг авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ерөнхийдөө эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ нь микро болон макро эдийн засгийн үндэслэлээс гарч ирдэг. Микро эдийн засгийн хандлага нь шокын өрхүүдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөнд анхаардаг бол макро эдийн засгийн хандлага нь шокын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг илүүтэй авч үздэг. Гэхдээ хөгжиж буй орны хувьд санхүүгийн болон эдийн засгийн хямралд өртөх макро эдийн засгийн эмзэг байдлыг үнэлэх цорын ганц хандлага гэж байхгүй. Хэдий олон арга зүй, хандлага хөгжиж байгаа ч сүүлийн үед үндсэн 2 хандлага илүүтэй ашиглагдаж байна (Seth & Ragab 2012).

Эхний хандлага нь санхүүгийн хямрал руу хөтлөх макро эдийн засгийн эмзэг байдлыг авч үздэг. Хоёрдахь хандлага нь макро эдийн засгийн эмзэг байдал (улс орныг эдийн засгийн болон санхүүгийн шоконд өртүүлэх)-д эдийн засгийн онцлог болон бүтэцтэй холбоотой ямар хүчин зүйлс (хэмжээ, газар зүйн байршил, худалдаа болон хөрөнгийн урсалаас хараат байдал) нөлөөлж байгаад болон шокын шилжих механизмд илүүтэй анхаардаг.

Энэ судалгааны хүрээнд Монгол улсын эдийн засгийн эмзэг байдлын шинж тэмдэг, шалтгааны шинжилгээг Дэлхийн банкны аргачлалыг ашиглан гүйцэтгэж, эдийн засгийн дархлааг бэхжүүлэх бодлогын саналыг боловсруулав. Тус аргачлал нь микро, макро эдийн засгийн хандлагыг давхар агуулахаас гадна, дээр дурьдсан макро эдийн засгийн 2 урсгалыг хамтад нь багтааснаараа онцлог давуу талтай.

Түүнчлэн микро эдийн засгийн буюу нийгмийн эмзэг байдлыг давхар хамарсан нь эдийн засаг хямралын нөхцөл байдалд шилжвэл нийгмийн хувьд ямар хүндрэл бэрхшээлийг дагуулахаар байгааг давхар тодорхойлох бололцоог тус үнэлгээний аргачлал олгох юм.

Монголын макро эдийн засаг, нийгмийн эмзэг байдалд үнэлгээ хийж, 2012 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаарх үр дүнг Хүснэгт 3-т харуулав. 2012 оны 2 дугаар улирлын үзүүлэлтүүд гадаад шоконд өртөх эмзэг байдал өндөр, төсвийн эмзэг байдал дунд, мөнгө болон валютын ханшийн эмзэг байдал өндөр, санхүүгийн салбарын эмзэг байдал дунд, нийгмийн эмзэг байдал дунд гэсэн үр дүн гарч байна. Нийт 25 үзүүлэлтээс зөвхөн 2 үзүүлэлт (Гадаад валютын нөөц, ДНБ-ий харьцаа болон Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа)-ийн хувьд л эмзэг байдал бага байна. Тухайлбал, өмнөх хямралаас сургамж авч, хөрөнгийн дотогшлох урсгал өндөртэй үед төгрөгийн ханшийн хэт чангарталтыг бий болгохгүй байх зорилгоор стерилизаци, интервенцийн бодлого баримталсны дунд гадаад валютын албан нөөц нэмэгдсэн.

Хүснэгт 3: Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: 2012 оны 2 дугаар улирал

Хэмжилт	Үзүүлэлт	Эмзэг байдал бага	Эмзэг байдал дунд	Эмзэг байдал өндөр	Эх сурвалж
Гадаад	Түүхий эдийн экспорт/ Нийт экспорт			88.6%	Төлбөрийн тэнцлийн тойм
	Экспорт/ДНБ			56.7%	Статистикийн бюллетең
	ГВЦАН/Нийт гадаад санхүүжилтийн хэрэгцээ			4.91 сар	Статистикийн бюллетинь, Төлбөрийн тэнцлийн тойм
	Урсгал тэнцэл/ДНБ			-22.5%	Төлбөрийн тэнцлийн тойм
Төсөв	Төсвийн үндсэн тэнцэл*/ДНБ			-4.3%	Төсвийн сарын мэдээ
	Улсын өр/ДНБ		27.5%		Гадаад өрийн тойм
	Санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгцээ/ ДНБ		10.4%		Төсвийн сарын мэдээ
	Зайлишгүй шаардлагатай зардал / Нийт зардал			78.7%	
	Түүхий эдийн орлого/ нийт орлого			49.7%	
Мөнгө ба Валютын ханиг	Инфляци			15.1%	ҮСХ
	Бодит хүү (Бодлогын хүү)			-1.9%	Статистикийн бюллетең
	Валютын ханшийн уян хатан байдал		Зохицуулалттай хөвөгч		
	Гадаад валютын нөөц/ ДНБ	31.7%			Статистикийн бюллетинь

Санхүү	Гадаад валютын өр төлбөрийн нийт өр төлбөрт эзлэх хувь		24.4%		Банкуудын нэгдсэн тайлан
	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	8.2%			
	Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа		4.9%		
	Зээл, депозитын харьцаа		98.7%		
Нийгэм	Ядуурлын мэдрэмж**			2.7	ҮСХ-ны Статистикийн эмхтгэл
	Ажилгүйдлийн түвшин		7.7%		
	Өдрийн \$1.25-аас бага орлого ядуучуудын тоо/нийт хүн ам		29.8%		
	Жини индекс		0.44		Дэлхийн банк
	Ядуурлаас хамгаалах хөтөлбөр			Хариу үйлдэлтэй сүл уялддаг	

Тэмдэглэгээ: * Хүүний төлбөрийг хасч тооцсон төсвийн цэвэр тэнцэл. ** Бага (1 нэгж хувийн өсөлтийн бууралт нь (<0.5) нэгж хувиар ядуурлыг өсгөдөг); Дунд (1 нэгж хувийн өсөлтийн бууралт нь (0.5-1) нэгж хувиар ядуурлыг өсгөдөг; Өндөр (1 нэгж хувийн өсөлтийн бууралт нь (>1) нэгж хувиар ядуурлыг өсгөдөг).

Эх сурвалж: Монголбанкны МБСГ-ын тооцоо

Одоогоор гадаад валютын нөөц ДНБ-ий 1/3-тэй тэнцүү байгаа нь түр зуурын шинжтэй гадаад шокын ханшид ирэх дарамтыг бууруулах, олон нийтийн ханшийн талаарх хүлээлтэд эрэг нөлөөлөх ач холбогдолтой байна. Гэхдээ тус нөөц нь импортын 5 сарын хэрэгцээнээс бага тул гадаад шоконд хариу үйлдэл үзүүлэхэд хангалтгүй. Харин өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 8.2 хувь байгаа нь банкны салбарын үзүүлэлт харьцангуй сайжирч байгааг илэрхийлэх боловч цаашид энэ хэвээр хадгалагдаж чадах нь эргэлзээтэй юм.

Уул уурхайн салбарт түшиглэсэн манай эдийн засгийн бүтэц нь эдийн засгийн эмзэг байдал өндөр байх суурь хүчин зүйл болж байна. Европын өрийн хямрал хүндэрч, дэлхийн эдийн засаг уналтанд орвол манай эдийн засаг гадаад худалдаа, хөрөнгийн урсгалаар дамжин өртөх явдал маш өндөр байна. Тухайлбал, манай экспортын барааны дэлхийн зах зээл дээрх үнэ огцом буурч, экспортын орлого зогсонги байдалд орох тохиолдолд гадаад валютын цэвэр албан нөөц нь 4.3 сарын импортын хэрэгцээг л хангана. Мөн худалдааны алдагдал нэмэгдэх тул төгрөгийн ханшийг сулруулж, инфляцийн дарамтыг өсгөхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг шууд хязгаарлах боломжтой. Төсөв дэх түүхий эдийн орлого буурах тул төсвийн нийт зардлын 50 орчим хувийн санхүүжилтийн асуудал хүндэрх бөгөөд зайлшгүй шаардлагатай төсвийн зардлыг ч санхүүжүүлж чадахгүйд хүрэхээр байна. Түүнчлэн төсвийн алдагдал нэмэгдэж, түүнийг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын өр өсөх нь эдийн засгийн эмзэг байдал улам нэмэгдэх эрсдлийг дагуулна. Хэрэвээ төсвийн алдагдлыг Монголбанкны зээлээр санхүүжүүлбэл төгрөгийн ханшийн сурдрах дарамт нэмэгдэж, инфляцийг улам эрчимжүүлнэ.

Санхүүгийн салбарын эмзэг байдал “дунд”-аас “өндөр” төлөв рүү шилжих эрсдэлтэй. Санхүүгийн салбарын баланс дах долларжилт буурч, өөрийн хөрөнгө нэмэгдэн эрсдэл даах чадвар өсч буй хэдий ч мөчлөг дагасан мөнгө, зээлийн өсөлт нь тус салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Хөрөнгийн цэвэр дотогшлох урсгалыг даган банкны салбар

дахь депозитын өсөлт саарч байгаа нь цаашид зээлийн хязгаарлалт үргэлжлэх эрсдлийг дагуулж байна. Тухайлбал, зээл, хадгаламжийн харьцаа 1-ээс өндөр байгаа нь зээлийн эргэн төлөлт шинэ зээл болж гарахгүй байх нөхцөл болж байна. Ийм байдал удаан үргэлжлэх нь мөнгө үржих процессыг удаашруулж, зээлийн эрсдлийг хуримтлуулан банкны салбар эрсдэлд орох аюултайг анхаарах нь зүйтэй. Эдийн засгийн өсөлт 1 хувиар буурахад ядуурлын түвшин 2.7 нэгж хувиар өсөх буюу 73 мянган иргэн ядуурлын ангилалд шилжихээр байна. Гадаад эдийн засгийн таагүй нөлөө нэмэгдэх тусам нийгмийн амьжиргаа дордож төсвийн зарлагыг бууруулахад төвөгтэй байх болно.

Түүнчлэн макро эдийн засгийн эмзэг байдлын үзүүлэлтүүд, тэдгээрээс үүсгэсэн индексүүд нь эдийн засгийн өсөлт болон инфляцийн хөтөч үзүүлэлт болж байгааг харуулсан нь энэхүү судалгааны бас нэг онцлог юм. Тухайлбал, макро эдийн засгийн эмзэг байдлын дэд бүлгүүдийн индексүүд дотроос гадаад сектор болон санхүүгийн эмзэг байдлын индекс нь эдийн засгийн өсөлт болон инфляцийн хөтөч үзүүлэлт болж байна. Үүн дотроо гадаад валютын нөөц/ДНБ харьцаа, зээл/депозитын харьцаа болон зээл/ДНБ харьцааны өсөлт нь эдийн засгийн өсөлтийн, харин гадаад валютын нөөц/ДНБ харьцаа, экспорт/ДНБ харьцаа болон зээл/ДНБ харьцаа нь инфляцийн хамгийн сайн хөтөч үзүүлэлт байхаар байна. Иймд эдгээр индекс болон үзүүлэлтүүдийн динамикийг анхааралтай ажиглах нь эдийн засгийн өсөлт болон инфляцийн цаашидын төлөвийг урьдчилан тодорхойлж, ирээдүйг харсан макро бодлогыг хэрэгжүүлэх боломжийг олгох юм.

Эдийн засгийн шокыг шингээх эсхүл түүний сөрөг үр дагаварыг хохирол багатай даван туулах чадвар, дархлааг бэхжүүлэхийн тулд дараах бодлогын хувилбарт анхаарал хандуулах нь зохимжтой байна. Үүнд:

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх. Эдийн засгийн дотоод тэнцвэр бий болгохын тулд өр улам нэмэгдэхээргүй байх төсвийн бодлогыг нам, тогтвортой инфляцийн орчин бүрдүүлэх болдлоготой хослуулах нь чухал боллоо. Харин гадаад тэнцвэрийг худалдааны тэнцэл болон гадаад өрийн зохистой түвшинг хослуулах байдлаар бүрдүүлэх юм. Иймд эдийн засгийн шокыг саармагжуулах болон шингээх чадварыг сайжруулах, хөрөнгийн урсгалын хэлбэлзлийн сөрөг нөлөөг бууруулахын тулд төсвийн болон мөнгөний бодлогыг хоёуланг нь мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ интервенци-стерилизацийн хослолыг хэрэглэхээс гадна макро зохистой бодлогын хэрэгслүүд, богино хугацаанд хөрөнгийн урсгалд хяналт тогтоох зэрэг арга хэрэгслийг хослуулан ашиглах шаардлагатай байна. Түүнчлэн уул уурхайн салбараас орох орлогоор “Сан” байгуулж, түүнийг хилийн чанадад гадаад валютаар диверсификаци хийн хөрөнгө оруулалтад байршуулах нь зүйтэй. Энэ нь мөчлөг сөрсөн төсвийн бодлого төдийгүй Голланд өвчинөөс урьдчилан сэргийлэх шалгарсан арга билээ.

Зах зээлийн үр аигийг нэмэгдүүлэх бодлогыг богино хугацаанд хэрэгжүүлэх. Засгийн газрын оролцоог боломжит хэмжээнд бууруулах, үүний тулд төсвийн зардлын хэт тэлэлтийг хязгаарлах шаардлагатай байна. Түүнчлэн, хөвөгч валютын ханшийн системийг бүрдүүлсэнээр валютын ханш шок шингээгчийн үүрэг гүйцэтгэж, гадаад худалдаанд чөлөөт зохицуулалт хийгдсэнээр эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэр хангагдах, санхүүгийн хямралаас сэргийлэх юм. Үүний зэрэгцээ стратегийн импорт (шатахуун,


зарим нэр төрлийн хүнс) болон дотоодын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн (мах, хүнсний ногоо, гурил, будаа)-ий нийлүүлэлтийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх нь туйлаас чухал байна. Энэ нь инфляцийг тогтвортой нам түвшинд барих зорилготой нийцтэй төдийгүй бодит ханшийн чангараалтыг саармагжуулах тул Голланд өвчний сөрөг үр дагаварыг бууруулах ач холбогдолтой.

Эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэх. Эдийн засгийн өсөлт бүхэлдээ гадаад эрэлтээс хамаарч байх хэдий ч дотоод эрэлтийг эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болго замаар бэхжүүлэх нь дээрх эмзэг байдлыг бууруулах үр дүнтэй арга гэдэг нь олон улсын туршлагаар харагдсан. Засгийн газраас ноос, ноолуурын салбарыг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход 2011 онд анхаарч ажилласан. Үүний дунд олборлох салбараас бусад салбарын экспорт нэмэгдэх учиртай. Уг бодлогын үр дүнг тооцох хараахан болоогүй байна. Үүнтэй зэрэгцүүлээд хөдөлмөрийн агууламж өндөртэй бусад салбарт хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлж, эдийн засгийн төрөлжилт, олон тулгуурт байдлыг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

3.1.5 Зээл


2012 оны 8 дугаар сарын байдлаар зээлийн өрийн үлдэгдэл хэмжээ 6675.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар өссөн байна. Энэ өсөлтийн 15.4 нэгж хувийг хувийн хэвшилд олгосон зээл, 15.6 нэгж хувийг иргэдийн зээл, 6.1 нэгж хувийг бусад салбар эзэлж байна.

Зураг 17: Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа



2012 онд олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн ч 2011 онд 61.2 хувиар өссөн өсөлттэй харьцуулахад бага байгаа нь 2012 онд хөрөнгийн дотогшлох урсгалын өсөлт буурсан, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт саарсан, инфляцийн өсөлт зэрэгтэй шууд холбоотой.


Зураг 18: Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбараар




Иргэдийн зээлийн өсөлт 2011 оны 2 дугаар улирал хүртэл жигд өссөн бол 3 дугаар улирлаас эхлэн буурч байна.

Зээлийн өрийн үлдэгдлийн өсөлтийг ДНБ-ий салбаруудаар авч үзвэл 2011 оны 1 дүгээр улирлаас иргэдийн хэрэглээний зээл, үл хөдлөх хөрөнгө, бусад гэсэн ангилал дээрх салбаруудын өсөлт нийт зээлийн өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэжээ. Дээрхи салбаруудын өсөлттэй холбоотойгоор хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилгын салбарын нийт зээлд эзлэх хувь буурсан байна.

Зураг 19: Зээлийн өсөлтийн задаргаа, ДНБ-ий салбараар



Зураг 20: Зээлийн бүтэц, ДНБ-ий салбараар

3.1.6 Зээлийн хүү

Төгрөгийн зээлийн хүү 2011 онд 17.2 хувь хүртэл буурсан боловч 2012 оны эхнээс 2.8 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 1.1 нэгжээр, валютын зээлийн хүү оны эхнээс 2 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгжээр тус тус өслөө. 2012 оноос инфляци өсч, валютын ханш чангартсан, хөрөнгийн дотогшлох урсгал буурсан, зээлийн эрэлт нэмэгдсэн зэрэг нь зээлийн хүүг өсгөх нөхцөлийг бүрдүүлж 2012 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын төгрөгийн зээлийн дундаж хүү 18.3 хувь, валютын зээлийн жилийн дундаж хүү 14.1 хувь болж өссөн байна.

Зураг 21: Зээлийн хүү

Гэвч дээр дурдсан хүүгийн түвшин нь зөвхөн нэрлэсэн үзүүлэлт бөгөөд нэрлэсэн үзүүлэлтийг аливаа хөрөнгө оруулалтын шийдвэрт ашиглах нь учир дутагдалтай юм. Иймээс эдийн засагчид бодит хүү гэдэг ухагдахууныг ашигладаг бөгөөд зээлийн бодит хүү нь зээлийн нэрлэсэн хүүнээс хүлээгдэж буй инфляцийг хасч тооцсон үзүүлэлт юм. Инфляци өмнөх оны мөн үеэс 8.5 нэгж хувиар өсч төгрөгийн бодит хүүний түвшинг бууруулсан бөгөөд төгрөгийн бодит хүүний түвшин 2011 оны 8 дугаар сард 7.5 хувь байсан бол 2012 оны 8 дугаар сарын байдлаар 6.1 хувьтай байна.


3.1.7 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханийн хэлбэлзэл, гадаад валютын урсгал

Төгрөгийн гадаад валюттай харьцах хани. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сүүлийн 42 гаруй сарын турш харьцангуй тогтвортой байна. Энэ оны эхнээс 8 дугаар сарын эцэст төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 1.2 хувиар чангасан бөгөөд дунджаар 1242.55 төгрөг орчимд, өдөрт дунджаар 0.01 хуний хэлбэлзэлтэй байв.

**Зураг 22: Төгрөгийн ам.доллартай харьцах
Монголбанкнаас зарласан ханийн
хөдөлгөөн**



**Зураг 23: Төгрөгийн ам.доллартай харьцах
ханийн нэг өдрийн өөрчлөлт**



Ханш ийнхүү тогтвортой байгаа нь: (i) Монгол Улсын эдийн засагт орсон нийт гадаад валютын урсгалын хэмжээ 2012 оны эхний 8 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 1.08 дахин нэмэгдсэн боловч, эдийн засгийн хурдацтай тэлэлттэй уялдан гадаад валютын гарах урсгалын өсөлтийн хурдац эрс нэмэгдэж, хэмжээ нь 1.18 дахин өссөнөөр гадаад валютын цэвэр орох урсгал 166 хувиар буурсан⁴, (ii) Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2.7 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэний зэрэгцээ Монголбанк, Хятадын Ардын банк хооронд өнгөрсөн онд 5 тэрбум юаньтай тэнцэх хэмжээний үндэсний мөнгөн тэмдэгтийн своп хэлцэл хийх гэрээ байгуулсныг энэ онд 10 тэрбум хүртэл нэмэгдүүлсэн нь иргэдийн төгрөгт итгэх итгэл бэхжихэд эерэгээр нөлөөлсөн, (iii) банкуудын гадаад валютын урсгалыг удирдах, зохицуулах, шингээх чадавхи харьцангуй сайжирсан, (iv) гадаад валютын дотоодын заход ханийн эрсдэлийг удирдах своп, форвард зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нэвтэрч, тэдгээрийн хэрэглээ нэмэгдсэн зэрэг хүчин зүйлстэй холбоотой юм.

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 5.8 хувиар суларч, бодит үйлчилж буй ханш 7.0 хувиар

⁴ 2012 оны эхний 8 сарын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлээр импорт 1.15 дахин өссөнөөр барааны гадаад худалдааны алдагдал 1.34 дахин, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 1.34 дахин өсч, урсгал тэнцлийн алдагдал 1.24 дахин нэмэгдсэн нь эдийн засагт орж ирсэн гадаад валют төлбөрийн урсгал дансаар дамжин гадагшилж байгааг илэрхийлж байна.

чангарчээ. Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн чангараалтын 6.4 хувийг дотоод болон гадаад худалдааны түвш орнууд дахь инфляцийн зөрүү тайлбарлаж байна.

Зураг 24: Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш⁵




Зураг 25: Бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлтийн бүтэц




Хэдийгээр төгрөгийн нэрлэсэн ханш тогтвортой байгаа ч, уул уурхайн салбарын бүтээн байгуулалт, түүнтэй уялдсан хөрөнгийн дотогшлох урсгалаас шалтгаалан цаашид бодит ханш⁶ чангараах хандлагатай байна. Энэ нь эдийн засаг эрдэс баялгийн салбараас хэт хамааралтай болох, дотоодын үйлдвэрлэл, өрсөлдөх чадварыг урт хугацаанд бууруулах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Гадаад валютын урсгал. Энэ оны 8 дугаар сарын эцсийн байдлаар гадаад валютын нийт орох урсгал өнгөрсөн оны мөн үеэс 8.4 хувиар, гарах урсгал 18.0 хувиар өссөнөөр, цэвэр орох урсгал 165.8 хувиар буурчээ. Гадаад валютын цэвэр гадагшлах урсгалын хэмжээ оны эхнээс 205.3 сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Зураг 26: Гадаад валютын цэвэр урсгал⁷



Зураг 27: Гадаад валютын орох урсгалын бүтэц (2012 оны эхний 8 сар/)



⁵ Гадаад төлбөр, тооцоонд хэрэглэгдэж буй валютын төрлөөр нь жигнэж тооцсон нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш.

⁶ Бодит ханш нь худалдааны түвш орнуудтай харьцуулсан бараа бүтээгдэхүүний харьцангуй үнэ бөгөөд нэрлэсэн ханш болон инфляцийн зөрүү гэсэн хоёр сувгаар дамжин өөрчлөгдөж байдаг.

⁷ Орох урсгалаас гарах урсгалыг хассан цэвэр дун.

Гадаад валютын орох урсгалын бүтцэд экспортын орлого 2012 оны 8 дугаар сарын байдлаар 37 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалт 31 хувь, гадаадаас авсан зээл 8 хувь, бэлэн мөнгө ба харилцах 11 хувь, урсгал шилжүүлэг 5 хувь, үйлчилгээ 5 хувийг тус тус эзэлж байна. Харин гарах урсгалын 68 хувийг импортын төлбөр, 4 хувийг бэлэн мөнгө ба харилцах дансны гарах урсгал, 10 хувийг үйлчилгээний төлбөр, 7 хувийг гадаад зээлийн төлбөр, 2 хувийг урсгал шилжүүлэг тус тус бүрдүүлжээ.

Эдийн засгийн өсөлтийн эерэг хүлээлт, гадаад худалдааны тэлэлт, бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны идэвхжил, хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй уялдан цаашид эдийн засаг дахь гадаад валютын урсгалын хэмжээ⁸ огцом нэмэгдэх хандлагатай байна.

3.1.8 Монгол улсын гадаад секторын тойм (2012 оны 8 дугаар сарын байдлаар)

Монгол Улсын гадаад худалдааны тойм

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, худалдааны нөхцөл. Нийт бараа эргэлтийн мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 7531.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7 хувиар буюу 492.3 сая ам.доллараар өсчээ. Үүнд экспорт 23.9 сая ам.доллараар, импорт 468.4 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь нөлөөлөв.

Нийт бараа эргэлтийн жилийн өсөлтийн хурд нь өнгөрсөн оны мөн үеэс 80 нэгж хувиар буурчээ. Энэ оны эхний 8 сарын импортын жилийн өсөлт 2011 оны мөн үеэс 10.1 дахин, экспортын жилийн өсөлт 70.1 дахин буурсан нь худалдааны эргэлтийн жилийн өсөлт саарахад нөлөөлжээ.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 52.4 хувь буюу 3942.7 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 17.4 хувь буюу 1312.7 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 1, 20 нэгж хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.

⁸ Зөвхөн эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал ч бус, мөн гадагшлах урсгал өсөх хандлагатай байна.

Зураг 28: Экспорт, импортын өсөлтийн хурд (3 сарын дунджаар)




Эх сурвалж: ГЕГ

Хүснэгт 4: Гадаад худалдааны эргэлт (сая ам.доллар)

Төрөл	Эхний 8 сар			Өөрчлөлт	
	2012	2011	2010	Дүн	Хувь
Эргэлт	7,531.1	7,038.8	3,758.8	492.3	7%
Экспорт	2,871.6	2,847.7	1,793.6	23.9	1%
Импорт	4,659.5	4,191.1	1,965.2	468.4	11%
Тэнцэл	(1,788.0)	(1,343.4)	(171.6)	(444.5)	33% (1,171.8) 682%


Эх сурвалж: ГЕГ

Зураг 29: Валютын төлбөртэй худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Зураг 30: Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 оны суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.448-т хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.3 хувиар буурлаа. Үүнд нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт болон экспортын бүтээгдэхүүний бууралт голлон нөлөөлжээ.

Экспорт. Нийт экспортод эзлэх ашигт малтмалын бүтээгдэхүүний эзлэх хувь өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй буюу 90 хувьтай байв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт нь ашигт малтмалын экспортын 91 хувь, нийт экспортын 82 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн тус бүр 4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 31: Экспортын өөрчлөлт дэх үнийн болон тоо хэмжээний нөлөөлөл

	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	93	274%	(59)	-174%	34	142%
Чулуун нүүрс	39	42%	54	58%	93	389%
Зэсийн баяжмал	7	-7%	(111)	107%	(104)	-435%
Төмрийн хүдэр ба баяжмал	41	51%	40	49%	81	340%
Боловсруулаагүй нефть	66	115%	(9)	-15%	57	238%
Цайрын хүдэр ба баяжмал	(6)	23%	(21)	77%	(27)	-114%
Мөнгөжөөгүй алт	(60)	93%	(5)	7%	(65)	-271%
Жонц лейцит, нефелин	4	111%	(0)	-11%	4	15%
Молибдений хүдэр ба баяжмал	2	-44%	(7)	144%	(5)	-20%
2. Ноос, ноолуур	44	280%	(28)	-180%	16	65%
Ямааны угаасан ноолуур	46.5	207%	(24.0)	-107%	22.5	94%
Ямааны самнасан ноолуур	(2.9)	42%	(4.0)	58%	(7.0)	-29%
3. Бусад	(71)	276%	45	-176%	(26)	-107%
Нийт	65.9	276%	(42.1)	-176%	23.9	

Эх сурвалж: ГЕГ

Хүснэгт 5: Экспортын барааны гүйцэтгэл

	2012			2011			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн.кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн.кг)	Дүн	%	Дүн	%	%2
1. Ашигт малтмал	2,594	90%		2,560	90%		34	1%	1.2%
Чулуун нүүрс	12,084	1,247	43%	11,687	1,154	41%	93	8%	4%
Зэсийн баяжмал	382	558	19%	377	662	23%	(104)	-16%	-4%
Төмрийн хүдэр/баяж.	4,309	356	12%	3,749	275	10%	81	30%	3%
Боловсруулаагүй нефть	2,146	207	7%	1,493	150	5%	57	38%	2%
Цайрын хүдэр ба баяж.	77	73	3%	83	100	4%	(27)	-27%	-1%
Мөнгөжөөгүй алт	1,413	61	2%	2,708	126	4%	(65)	-52%	-3%
Жонц лейцит, нефелин	282	66	2%	265	62	2%	4	6%	0%
Молибдений хүдэр/баяж	3	26	1%	3	31	1%	(5)	-15%	0%
2. Ноос, ноолуур	164.3	6%		148.7	5%		16	10%	0.5%
Ямааны угаасан ноолуур	3,418	137	5%	2,433	115	4%	22.5	20%	15%
Ямааны самноолуур	297	27	1%	325	34	1%	(7.0)	-21%	-5%
3. Бусад	114	4%		139	5%		(26)	-18%	-0.9%
Нийт дүн	2,872			2,848			24	1%	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Эх сурвалж: ГЕГ

Экспортын 23.9 сая ам.долларын жилийн өсөлт нь тоо хэмжээний жилийн өсөлтөөс шалтгаалж 276 хувиар өссөн бол үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж 176 хувиар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 274 хувиар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 174 хувиар буурсан байна. Үнээс чулуун нүүрс, төмрийн хүдэр гэсэн 2 бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ зэрэг өссөн нь нийт экспортыг 174 сая ам.доллараар нэмэгдүүлсэн бол зэсийн үнийн

дүн, мөнгөжөөгүй алт, цайрын баяжмал гэсэн 2 бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүн зэрэг буурснаас нийт экспорт 92 сая ам.доллараар багассан байна.


Ноос, ноолуурган бүтээгдэхүүний хувьд үнийн дүн буурсан боловч тоо хэмжээ нь өссөнөөр нийт экспортын өсөлтийн 65 хувийг бүрдүүлжээ.

Экспортын 1 хувийн жилийн өсөлт нь бүхэлдээ ашигт малтмалын экспортын 1.2 хувийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Үүнд, чулуун нүүрсний экспортын 8 хувийн өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 4 хувийг, төмрийн хүдэр ба баяжмалын 30 хувийн өсөлт нь 3 хувийг, боловсруулаагүй нефтийн 38 хувийн өсөлт нь 2 хувийг бүрдүүлсэн бол бусад бүтээгдэхүүн 8 хувиар өсөлтийг бууруулжээ.

Ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспорт 10 хувиар өссөн нь өсөлтийн 0.5 хувийг бүрдүүлсэн бол бусад төрлийн бүтээгдэхүүний экспорт 18 хувиар буурсан нь өсөлтийг 0.9 хувиар бууруулж, цэвэр дүнгээр нийт экспортын өсөлтийг 0.4 хувиар бууруулсан байна.

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2012 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1691.9 ам. доллар хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 8 хувиар буурсан бол өмнөх сараас 4 хувиар өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2012 оны 7 дугаар сарын 31-ний байдлаар 7576.5, 1806.0 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 18 хувь, 20 хувиар буурсан бол өмнөх сараас зэсийн ханш 0.1 хувиар, цайрынх 2.4 хувиар чангартсан байна.

Зураг 32: Лондонгийн металлын бирж дээрх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ



Эх сурвалж: Bloomberg

Зураг 33: Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ, сараар



Эх сурвалж: ГЕГ, ЭБЭХЯ

Импорт. 2012 оны эхний 8 сарын байдлаар нийт импортын 51 хувийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 15 хувийг өргөн хэрэглээ, хүнсний бараа, үлдсэн 34 хувийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын хувь өнгөрсөн оны мөн үеэс бараг өөрчлөгдөөгүй хэдий ч дотроо нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өсч, үйлдвэрлийн орцын хувийн жин буурсан байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувийн жин өөрчлөлт багатай, тогтвортой хэвээр байна.

Хүснэгт 6: Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2012			2011			Өөрчлөлт		
	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2
Үйлдвэрлэлийн орц	1,435	31%		1,405	34%		29	2%	1%
Хүнд механизм, тоног төх.	8,893	794	55%	5,286	844	60%	(49)	-6%	-3%
Суудлаас бусад автомашин	674	533	37%	561	468	33%	64	14%	5%
Төмөр хийц, металл бүт.	24,069	38	3%	30,984	40	3%	(1)	-3%	0%
Бусад бүтээгдэхүүн	87,884	69	5%	319,044	54	4%	16	29%	1%
Нефть	943	20%		727	17%		216	30%	5%
Дизель түлш	501,488	571	61%	429,498	461	63%	110	24%	15%
АИ-92, АИ-95	160,456	202	21%	132,343	136	19%	66	48%	9%
А-80 болон бусад	156,352	170	18%	116,823	130	18%	40	31%	6%
Өргөн хэрэглээ	558	12%		461	11%		97	21%	2%
Суудлын автомашин	32	317	57%	34	270	59%	47	18%	10%
Цахилгаан бараа	688	107	19%	659	90	20%	17	19%	4%
Бүх төрлийн эм	1,199	48	9%	2,524	32	7%	16	49%	3%
Бусад өргөн хэрэглээний	11,154	85	15%	10,610	68	15%	17	25%	4%
Хүс	136	3%		120	3%		16	13%	0%
Гурил, будаа, талх	82,455	48	36%	61,433	38	32%	10	26%	8%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	3,466	13	10%	2,474	9	8%	4	47%	4%
Төрөл бүрийн өөх тос	15,851	21	15%	14,712	22	18%	(1)	-3%	-1%
Согтууруулах ундаа	20,242	19	14%	15,021	14	11%	5	39%	4%
Хүнсний ногоо	53,723	9	7%	60,038	11	10%	(2)	-18%	-2%
Бусад	42,463	25	18%	39,506	26	22%	(1)	-5%	-1%
Бусад импорт	1,588	34%		1,478	35%		110	7%	3%
Бусад	1,588			1,478			110	7%	7%
Нийт дүн	4,660			4,191			468	11%	11%

962 - Өөрчлөлт оруулсан хувь номр (contribution to the growth)

Эх сурвалж: ГЕГ

Импортын 11 хувийн өсөлтийн 5 хувийг нефтийн бүтээгдэхүүний өсөлт, 2 хувийг өргөн хэрэглээний, үлдсэн 7 хувийг үйлдвэрлэлийн орц, хүнс болон бусад бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 30 хувиар буюу 216 сая ам.доллараар, өргөн хэрэглээний бараа 21 хувиар буюу 97 сая ам.доллараар, бусад импорт 7 хувиар буюу 110 сая ам.доллараар тус тус өссөн нь энэхүү өсөлтөд голлон нөлөөлжээ.

Импорт үнийн дунгийн өсөлтөөс шалтгаалж 227.3 сая ам.доллараар, тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 241.1 сая ам.доллараар, нийтдээ 468.4 сая ам.доллараар өссөн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын 215.8 сая ам.долларын өсөлтийн 70 хувь буюу 150.2 сая ам.доллар нь тоо хэмжээний өсөлтөөс, 30 хувь буюу 65.7 сая ам.доллар нь хилийн үнийн өсөлттэй холбоотой байна. Хилийн үнэ 2011 оны 5 дугаар сараас

эхлэн хурдацтай өсч эхэлсэн бөгөөд 2012 оны эхнээс буурах хандлага ажиглагдаж байсан боловч 8 дугаар сард буцаад өссөн байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 7 хувиар, үнийн дүнгээс шалтгаалж 93 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэлийн орцын импорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 36 хувиар буюу 10.7 сая ам.доллараар, үнийн дүнгээс шалтгаалж 64 хувиар буюу 18.8 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 34: Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнз



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Зураг 35: Хэрэглээний импортын хандлага (3 сарын гулсаа дундаж)⁹



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл эхний хагас жилийн байдлаар 471.1 сая ам.долларын ашигтай байна. Уул уурхайн салбарын хөгжил, эдийн засгийн тэлэлттэй холбоотойгоор төлбөрийн тэнцлийн урсгал данс тайлант хугацаанд 1410.7 сая ам.долларын алдагдалтай гарсан хэдий ч, хөрөнгө санхүүгийн данс 1679.1 сая ам.долларын ашигтай¹⁰ байснаар нийт тэнцэл ашигтай хэвээр гарав.

Зураг 36: Төлбөрийн тэнцэл



Зураг 37: Урсгал тэнцэл



⁹ Нийт импортын 70%-ийг бурдуулдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцоолов.


¹⁰ Алдаа ба орхигдуулгын дүн 288.2 сая ам.доллар

Ургал данс. Ургал дансны алдагдал ДНБ-ий 31 хувьтай тэнцүү байна. Тайлант хугацаанд эдийн засгийн бодит өсөлт 13.2 хувьд хүрч, дотоодын эрэлт огцом нэмэгдсэнээр төлбөрийн тэнцлийн ургал дансны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 34.6 хувиар өсч 1410.7 сая ам.долларт хүрчээ. Энэ нь барааны гадаад худалдааны алдагдал 53.2 хувиар өсч 631.3 сая ам.долларт, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 36.8 хувиар өсч 662.7 сая ам.долларт тус тус хүрснээр тайлбарлагдаж байна.


Монгол Улсын барааны гадаад худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувиар өсч 5155.8 сая ам.долларт хүрчээ. Түүнчлэн голлох түүхий эдийн экспортын тоо хэмжээ өссөн хэдий ч тулш, шатахуун, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт нэмэгдсэнээр импортын дүн экспортос 6.8 нэгж хувиар илүү хурдацтай өссөн байна. Энэ нь барааны гадаад худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 53.2 хувиар буюу 219.3 сая ам.доллараар өсөхөд голлон нөлөөлжээ.

Үйлчилгээний гадаад худалдааны зардал импортын өсөлттэй уялдан нэмэгдэж байна. Тайлант хугацаанд үйлчилгээний гадаад худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.7 хувиар өсч 300.6 сая ам.долларт хүрсэн боловч зардал нь илүү хурдацтай буюу 32.4 хувиар өсч 963.3 сая ам.доллар болсноор үйлчилгээний худалдааны алдагдал 36.8 хувиар өсөв. Үүнд импортын барааны тээвэрлэлтийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 31.0 хувиар өсч 584.7 сая ам.долларт, аялал жуулчлал болон бусад үйлчилгээний зардал 34.8 хувиар өсч 378.6 сая ам.долларт хүрсэн нь нөлөөлжээ.

Зураг 38: Барааны гадаад худалдаа



Зураг 39: Үйлчилгээний гадаад худалдаа




Орлогын дансны алдагдал өнгөрсөн оны түвшинд байна. Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж /ААН/, иргэд нь эдийн засгийн харьят бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүний төлбөр, ногдол ашигт 200.0 сая ам.долларыг төлж, Монгол Улсын ААН-үүдэд ажиллаж буй харьят бус иргэдэд 117.5 сая ам.долларын цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого шилжүүлснээр цэвэр орлогын данс 283.7 сая ам.долларын алдагдалтай гарав.

Ургал шилжүүлгийн дансны ашиг нэмэгджээ. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гүйвуулга, гадаадын Засгийн газар, олон улсын байгууллагын шилжүүлсэн хандив тусlamжийн дүн өмнөх оны мөн үеэс 62.4 сая ам.доллараар өсч, харин гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гүйвуулга, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн зардлын дүн 24.7 сая ам.доллараар өссөн нь ургал шилжүүлгийн дансны дүн 29.2 хувиар өсч 167.0 сая ам.долларт хүрэхэд нөлөөлжээ.

Хөрөнгө, санхүүгийн данс. Хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 10.5 хувиар өсөв. Дотоодын болон олон улсын зах зээл дэх тодорхой бус нөхцөл байдлын улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс буурсан ч Монгол Улсын Хөгжлийн банк 600 сая ам.долларын өрийн бичгийг олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалснаар багцын хөрөнгө оруулалтын данс ашигтай гарч, улмаар нийт хөрөнгө, санхүүгийн дансны тэнцэл өмнөх оны мөн үеэс 159.9 сая ам.доллараар нэмэгджээ.

Зураг 40: Санхүүгийн данс



Зураг 41: Гадаад валютын цэвэр нөөц



Гадаад хөрөнгө оруулалтын позиц


Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2012 оны 2-р улирлын эцэст 10082.7 сая ам.доллар байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 10.1 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа улсын өрийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Хүснэгт 7: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2012 оны 2-р улирлын байдлаар

		/Сая ам.доллар/	
A. ГАДААД АКТИВ	5,820.9	B. ГАДААД ПАССИВ	
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад рүү)	1,062.5	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадас)	11,082.5
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	1,060.4	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	4,351.8
1.2 Бусад хөрөнгө	2.1	6.2 Бусад хөрөнгө	6,730.7
2. Багцын хөрөнгө оруулалт	24.4	7. Багцын хөрөнгө оруулалт	913.9
2.1 Хөрөнгийн хувьцаа	20.2	7.1 Хөрөнгийн хувьцаа	85.7
2.2 Өрийн бичиг	4.2	7.2 Өрийн бичиг	828.3
3. Санхүүгийн дериватив	0.5	8. Санхүүгийн дериватив	0.5
4. Бусад хөрөнгө оруулалт	1,825.4	9. Бусад хөрөнгө оруулалт	3,906.7
4.1 Худалдааны эзэл	496.3	9.1 Худалдааны эзэл	277.6
4.2 Зээл	21.7	9.2 Зээл	3,394.9
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	264.5
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	1,891.8
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	21.7	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	291.3
4.2.4 Аж ахуйн нэгж	0.0	9.2.4 Аж ахуйн нэгж	947.3
4.3 Бэлэн монго ба харилцах	1,307.5	9.3 Бэлэн монго ба харилцах	110.3
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	124.0
5. Ноөц актив	2,908.2	В. ПОЗИЦ	(10,082.7)
5.1 Монгожсон алт	178.6	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(10,020.0)
5.2 Зээлжих тусгай эрх	68.0	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(889.5)
5.3 ОУВС-д байршиулсан хөрөнгө (цэвэр)	0.2	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	(0.0)
5.4 Бэлэн валют ба харилцах	2,661.4	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(2,081.3)
5.5 Үйнгээ цаас	0.0	14. Ноөц актив	2,908.2
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0		
5.7 Бусад ноөц актив	0.0		

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн 5820.9 сая ам.доллар байна. Үүний 50 хувийг гадаад валютын албан нөөц, 31 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив, 18 хувийг шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Зураг 42: Гадаад актив



Зураг 43: Гадаад пассив



Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 15903.6 сая ам.долларт хүрчээ. Үүний 70 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25 хувийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 6 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 39 хувийг буюу 4351.8 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 61 хувь буюу 6730.7 сая ам.долларыг толгой компаниасаа авсан эзэл эзэлж байна.

Монгол Улсын гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2012 оны 2-р улирлын байдлаар 11.4 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3.3 тэрбум ам.доллараар буюу 1.4 дахин нэмэгдсэн байна. Үүнийг салбарын хувь хэмжээгээр нь авч үзвэл:

Төрийн байгууллага: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 651.0 сая ам.доллараар нэмэгдэж, 2775.7 сая ам.долларт хүрчээ.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг эдийн засгийн харьяат буст өгөх бүх төрийн өглөгийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд жилийн хугацаанд 2667.5 сая ам.доллараар нэмэгдэж 8660.0 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь нийт гадаад өрийн 76 хувийг эзлэж байгаа юм.

Хүснэгт 8: Гадаад өр

Үзүүлэлт			Өөрчлөлт	
	3/30/2011	3/30/2012	Дун	Дахин
Нийт гадаад өр	4,137.2	11,030.5	6,893.3	2.7
I. Засгийн газар	1,767.0	2,533.4	766.4	1.4
II. Төв банк	264.5	268.9	4.4	1.0
III. Банк	483.6	659.0	175.4	1.4
Богино хугацаат	76.9	76.6	-0.2	1.0
Үрт хугацаат	406.8	582.4	175.6	1.4
IV. Бусад сектор	588.4	1,130.4	542.0	1.9
Богино хугацаат	236.0	617.6	381.6	2.6
Үрт хугацаат	352.5	512.9	160.4	1.5
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	893.4	6,438.7	5,545.3	7.2

Зураг 44: Гадаад өрийн үлдэгдэл




3.1.9 Санхүүгийн салбарын тогтвортой байдал


Банкны салбар нь 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар нийт 14 банк, 1371 салбар нэгж, 13162 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 7.3 сая харилцагчид байгаагаас хадгаламж өзэмшигчид 1.9 сая, зээлдэгчид 598.6 мянгад хүрлээ.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2012 оны эхний 8 дугаар сарын эцсийн байдлаар 9.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсч, нийт 8.8 их наяд төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлжээ. Оны эхний 8 сарын байдлаар хөрвөх актив бүхий хөрөнгөд 2.8 их наяд төгрөгийг байршуулснаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 31.7 хувьд хүрлээ.

Зураг 45: Хөрвөх активын динамик



Зураг 46: Эх үүсвэрийн динамик




Банкуудын хөрвөх активын 26.6 хувь болох 734.5 тэрбум төгрөгийг богино хугацаат хөрөнгө оруулалтад, 73.4 хувь болох 2 их наяд төгрөгийг мөнгөн хөрөнгөд байршуулжээ. Хөрвөх активын хэмжээ тайлант оны 6 дугаар сараас эхлэн буурсан нь банкууд Төв банкин дахь нөөцөө бууруулж, зээл олголтыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Эх үүсвэрийн өсөлтөд төслийн зээлийн санхүүжилт болон харилцах, хадгаламжийн өсөлт голлон нөлөөлжээ. Дээрх зургаас харахад хөрвөх актив болон эх үүсвэрийн динамик нь системийн нөлөө бүхий банкуудын¹¹ үзүүлэлтээс хамаарч байгаа нь харагдаж байна.


Зураг 47: Хөрвөх активын өөрчлөлт



Зураг 48: Эх үүсвэрийн өөрчлөлт



Зураг 49: Хөрвөх чадварын үзүүлэлтүүд




¹¹ Системийн нөлөө бүхий банк нь банкны системийн нийт активын 5-аас дээш хувийг эзэлж буй банкыг хэлэх бөгөөд одоогоор нийт 5 банк байна.

Эх үүсвэрийн хэмжээ тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар эх үүсвэрийн сарын өсөлт 0.9 хувь, жилийн өсөлт 26.1 хувь байгаа бол өнгөрсөн нэг жилийн хугацаан дахь сарын дундаж өсөлт нь 1.9 хувь, жилийн дундаж өсөлт нь 36.3 хувь байна. Хөрвөх актив нь 2012 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар өссөн бол өмнөх сараас 5.1 хувиар буурчээ. Харин өнгөрсөн нэг жилийн хугацааны жилийн дундаж өсөлт 13.6 хувь, сарын дундаж өсөлт 0.5 хувь байна.


Зээлийн өсөлт өндөр байсантай холбоотойгоор 2011 оны эхний улирлаас эхлэн Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)-ын үзүүлэлт буурч байсан бөгөөд 2011 оны 11 дүгээр сард ТТГЧ-ын харьцааг 25 хувьд хүргэнсээр ТТГЧ-ын үзүүлэлт 36 хувьд хүрч тогтворжиж байна. Тайлант хугацаанд Төв банкны үнэт цаасны үлдэгдэл оны эхнээс 46.8 хувиар буюу 417.1 тэрбум төгрөгөөр буурсан бол гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 42.1 хувиар буюу 219.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Өнгөрсөн оноос эхэлсэн зээлийн хурдтай өсөлт нь ТТГЧ-ыг бууруулж байсан бол энэ оны эхнээс эхлэн зээлийн өсөлтийн хурд саарч ТТГЧ-ын үзүүлэлт харьцангуй тогтвортой болсон байна.

Зураг 50: Зээлийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)



Банкуудын хөрөнгө оруулалтын үндсэн бүтээгдэхүүн, нийт активын 64 хувийг эзэлж буй зээлийн үлдэгдэл 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 6.5 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 19.3 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 39.1 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өсчээ. Нийт зээлийн багцын 53.9 хувь буюу 3.5 их наяд төгрөгийг хувийн секторт, 41.9 хувь буюу 2.7 их наяд төгрөгийг иргэдэд олгоод байгаа бол 2.4 хувь болох 156 тэрбум төгрөгийг картын зээл хэлбэрээр олгожээ. Оны эхнээс нийт зээлийн үлдэгдлийн 67.9 хувь болох 4.4 их наяд төгрөгийг дотоод валютаар, үлдэх 32.1 хувь болох 2.1 их наяд төгрөгийг гадаад валютаар олгосон байна. Оны эхнээс гадаад валютаар олгосон зээлийн жилийн дундаж өсөлт нь 36.6 хувь байгаа бол төгрөгийн зээлийн жилийн дундаж өсөлт нь 57 хувьд хүрчээ.

**Зураг 51: Зээлийн үлдэгдэл
Эз-ын салбардаар
(хувиар)**




**Зураг 52: Гол салбаруудын зээлийн динамик
(тэрбум төгрөгөөр, улирлаар)**



Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн голлох салбаруудаар ангилахад үндсэн 5 салбарт нийт зээлийн багцын 66 хувь ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй байна. Дээрхи салбаруудад 2011 оноос эхлэн зээлийн эрэлт нэмэгдсэн, зээл олголт өссөн ба жилийн өсөлтийн хувиар мэдээлэл, холбоо (58%), барилга (47.9%), ул хөдлөх хөрөнгө (47.4%), уул уурхай (47.3%), боловсрол (43.6%) зэрэг салбарууд өндөр өсөлттэй байлаа.

2011 оноос эхлэн зээлийн өсөлт огцом нэмэгдсэн хэдий ч уг үзүүлэлт 2012 оны эхнээс эхлэн буурч байна. Оны эхний 8 сарын байдлаар зээлийн жилийн өсөлт 39.1 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийн зээлийн жилийн өсөлттөөс 14.3 нэгжээр буурчээ. Зээлийн өсөлт болон эрсдэлийн сангийн хоорондын хамаарлыг харахад өнгөрсөн хугацаанд зээлийн өсөлт өндөр байхад эрсдэлийн сангийн хувийн жин буурдаг, эсрэг тохиолдолд эрсдэлийн сангийн хувийн жин нэмэгддэг хандлага байна. Олон улсын санхүүгийн зах зээлийн хямралаас үүдэн улс орнуудад эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэхийг олон улсын байгууллага, эдийн засаг санхүүгийн голлох байгууллагуудаас санал болгож байгаа юм.


Зураг 53: Эрсдэлийн сан ба зээлийн хамаарал (тэрбум төгрөгөөр)




Үүнтэй холбоотойгоор Монголбанкнаас зээлд динамик эрсдэлийн санг байгуулах талаар холбогдох судалгааг хийж байна. Эрсдэлийн сангийн хэмжээ нь нийт чанаргүй зээлийн өөрчлөлтийг дагаж хөдөлдөг бөгөөд оны эхний 8 сарын байдлаар эрсдэлийн сангийн хэмжээ нь нийт чанаргүй зээлийн 72.3 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээлийн хэмжээ 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 167.4 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс өөрчлөлтгүй байгаа бол өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар буюу 35.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Нийт зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа үед чанаргүй зээлийн үлдэгдэл буурч байгаа нь чанаргүй зээлийн харьцааг 2.6 хувьд хүргэж оны эхнээс 0.5 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 67.9 хувь болох 113.7 тэрбум төгрөгийг хувийн секторт олгосон зээл, 20.8 хувь болох 34.9 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Зураг 54: Чанаргүй зээл болон эрсдэлийн сан (тэрбум төгрөгөөр)




Зураг 55: Гол салбаруудын чанаргүй зээл (хувиар)



Нийт зээлийн 67.9 хувийг төгрөгөөр олгосон зээл эзэлж байгаа бөгөөд үүний 53.3 хувь чанаргүй ангилалд байна. Эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн чанарыг авч үзвэл уул уурхайн салбар дахь чанаргүй зээлийн хэмжээ 107.3 тэрбум төгрөгт хүрч нийт банкны салбарын чанаргүй зээлийн 35 хувийг дангаар эзэлж байна. Энэ нь тухайн салбар дахь эрсдэлийн хэмжээ өндөр байгааг харуулж байгаа юм.

Банкны салбарын активын бүтцэд эзлэх зээлийн хэмжээ өссөөр байгаа нь банкууд Төв банкны үнэт цаас, Төв банкин дахь харилцах, хадгаламжийн хэмжээгээ бууруулснаас хөрвөх активын хэмжээ буурч, зээлийн өрийн үлдэгдэл нь нийт активын 64 хувьд хүрч өмнөх оноос 10.5 нэгжээр өсчээ.

Зураг 56: Хөрөнгийн бүтэц (хувиар)



Банкны салбарт 2011 оны эцсээс эхлэн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсээр байна. Банкуудын харилцах 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 15.1 хувиар буюу 0.3 их наяд төгрөгөөр, нийт хадгаламж 4.6 их наяд төгрөгт хүрч 24.9 хувиар буюу 0.9 их наяд төгрөгөөр өсчээ. Төрийн байгууллагуудын харилцах 267 тэрбум төгрөгөөр, иргэдийн харилцах 92.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь харилцахын өсөлтөд голлох нөлөөг үзүүлсэн байна. Хугацаатай хадгаламжийн хэмжээ 25.6 хувиар буюу 0.6 их наяд төгрөгөөр өсч, 3.2 их наяд төгрөгт хүрсэн нь хадгаламжийн өсөлтөд голлон нөлөөлсөн бөгөөд энэ нь банкуудын эх үүсвэрийн дундаж хугацааг нэмэгдүүлэх, цаашлаад урт хугацаат хөрөнгө оруулалтыг өсгөх боломжийг бий болгож байна.

Зураг 57: Харилцах, хадгаламжийн динамик (тэрбум төгрөгөөр)



Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ оны эхний 8 сарын байдлаар 592.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 107.2 тэрбум төгрөгөөр буюу 22.1 хувиар өсчээ.


Банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 2012 оны эхний 8 сарын байдлаар 1.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар буюу 365.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь банкуудын ашигт ажиллагаа сайн байгаа болон Төв банкнаас

банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх шийдвэртэй холбоотой юм. Нийт өөрийн хөрөнгийн 80.9 хувь болох 932.4 тэрбум төгрөг нь дотоодын валютаар байршсан бол 19.1 хувь болох 220.4 тэрбум төгрөг нь гадаад валютаар байршжээ.

Банкны ашигт ажиллагаа сайжирсаар байгаа бөгөөд 2012 оны эхний 8 сарын байдлаар цэвэр ашгийн хэмжээ 123.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.1 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Банкуудын ашигт ажиллагаа ийнхүү нэмэгдэхэд хүүгийн орлогын өсөлт өндөр байсан нь нөлөөлжээ. Хүүгийн орлогын хэмжээ 652.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 166.1 тэрбум төгрөгөөр өссөн бол хүүгийн зардал 393.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 103.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нийт эх үүсвэрт эзлэх харилцах, хадгаламжийн хувийн жин 70.1 хувь байгаа нь өмнөх оноос 4 нэгжээр нэмэгджээ. Харин банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь хэмжээ өмнөх оны эцсээс 0.8 нэгжээр өсөв.

Зураг 58: Эх үүсвэрийн бүтэц (хувиар)




Шигтгээ 3: Мэдрэмтгий байдлын шинжилгээ (стресс тест)

Олон улсад Төв банкууд мэдрэмтгий байдлын шинжилгээг микро болон макро түвшинд хийдэг. Уг шинжилгээний үндсэн зорилго системийг эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэх бөгөөд тухайн салбар нь гэнэтийн эрсдэл бий болвол яаж нөлөөлөхийг гаргаж ирдэг. Макро мэдрэмтгий байдлын шинжилгээг эдийн засгийн тухайн нэг үзүүлэлт өөрчлөгдөхөд санхүүгийн салбарын бусад үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөллийг тооцдог бол микро түвшний шинжилгээ нь тухайн нэг санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд санхүүгийн аливаа эрсдэл хэрхэн нөлөөлж болохыг тооцох шинжилгээ юм. Мэдрэмтгий байдлын шинжилгээг дараах 2 эрсдэлийн хувьд тооцлоо.


- Зээлийн эрсдэлийн мэдрэмтгий байдлын шинжилгээ
- Хөрвөх чадварын эрсдэлийн мэдрэмтгий байдлын шинжилгээ

Тухайн эрсдэлийн хувьд банкны салбарт нөлөөлж болох боломжит хувилбаруудыг (сценари) түүхэн хугацаанд үзүүлж байсан нөлөөлөл болон шууд таамаглал гэсэн үндсэн хоёр аргаар сонгон авч хийдэг. Зээлийн болон зах зээлийн эрсдэлийн үнэлгээнд сонгосон сценариуд нь тухайн банк болон нийт салбарын хэмжээний өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагад үзүүлж буй нөлөөг тооцсон бол хөрвөх чадварын эрсдэлийн стресс тестээр тухайн цочролоос нийт салбар болон тухайн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтэд үзүүлж буй нөлөөг тус тус тооцлоо.

Зураг 59: Зээлийн эрсдэлийн стресс тест



Зураг 60: Хөрвөх чадварын эрсдэлийн стресс



Тайлбар: Зээлийн эрсдэлийн хувьд сул, дунд болон хүчтэй сценариудыг сонгоходо одоогийн чанарын ангилалд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдэл нь харгалzan 10, 20 болон 30 хувиар нэг ангиллаар буурах (муу зээлийн ангилалд байгаа зээл ангилал шилжихгүй) тохиолдлуудыг сонголоо. Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь нь гадагшлах тохиолдолд бол банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд орох өөрчлөлтүүдийг харуулав.

Нийт зээлийн үлдэгдлийн 10 хувь нь одоо байгаа ангиллаас нэг шатаар буурахад сул сценарийн хувьд банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.5 нэгж хувиар, дунд сценарийн хувьд 1 нэгж хувиар харин хүчтэй сценарийн хувьд 1.5 нэгж хувиар тус тус буурахаар байна. Шинжилгээнээс харахад өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд нь дээрх сценарийн дараах байдлаар зөвшөөрөгдөх доод хязгаарлалтаас 1.8-aac 2.8 нэгж хувиар өндөр байна.

Нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь гадагшлахад банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 3.4-өөс 11.4 нэгж хувь хүртэл буурахаар байгаа нь харагдаж байна. Сул болон дундаж сценариийн хувьд зохистой харьцааны үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа бол хүчтэй сценариийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа нь зөвшөөрөгдөх түвшнөөс 1.2 нэгжээр бага болохоор байна.

Зохистой харьцааны үзүүлэлтүүд

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 тоот тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт банкны салбарын хэмжээнд 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 15.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1 нэгжээр өсчээ. Харин нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 11.4 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтийг бүрэн хангаж байна. Нийт эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 7.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. 2012 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээг нэг л банк ханганд ажиллаагүй байна.

Зураг 61: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 2012 оны 08 дугаар сарын эцсийн байдлаар 31.7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр буурчээ. Энэ нь Монголбанкны тогтоосон шалгуур үзүүлэлтийг (25%) бүрэн хангаж байна.

Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн хязгаарлалт болон банкны холбогдох этгээдэд олгосон зээлийн хязгаарлалтыг хангаагүй байгаа зарим банкуудад албадлагын арга хэмжээг авч ажиллаж байна. Системийн хэмжээнд зээлийн төвлөрөл өндөр байгаа бөгөөд 50 том зээл, нийт зээлийн харьцаа 2012 оны 8 дугаар сарын


Эцсийн байдлаар 26.4 хувьд хүрсэн бол 50 том зээл, нийт өөрийн хөрөнгийн харьцаа 149.7 хувьд хүрлээ.

Оны эхний 8 сарын байдлаар гадаад валutyн цэвэр нээлттэй позицийн хэмжээ 9.8 тэрбум төгрөгт хүрэв. Банкны салбарын хэмжээнд гадаад валutyн зохистой харьцааны үзүүлэлт нэгж валutyн хувьд ($\pm 15\%$)-1.3 хувь байгаа бол нийт валutyн хувьд ($\pm 40\%$) 2.9 хувь байгаа нь зохистой харьцааны шаардлагыг бүрэн хангаж байна.


Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт (FSI) улс орнуудтай харьцуулсан судалгаа

Тухайн банкны эрсдэл даах чадварыг илэрхийлдэг голлох үзүүлэлтүүдийн нэг нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт бөгөөд энэхүү харьцаа 12 хувь байхаар заасан байдаг. Уг үзүүлэлт нь банкны салбарын хэмжээнд 15.2 хувь байгаа нь бусад орнуудын¹² үзүүлэлтүүдтэй ойролцоо байна.

Зураг 62: Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, %



Зураг 63: НЗӨХ зохистой харьцаа, %



Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлт салбарын хэмжээнд 11.4 хувь байна. Банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 404 тоот тушаалаар хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлж 16 тэрбум төгрөгт хүргэн 2013 оны 5 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх шаардлагыг тавысан.


Зээлийн өндөр өсөлтөөс хамаараад өөрийн хөрөнгийн үзүүлэлт буурч байсан хэдий ч 2012 оноос зээлийн өсөлт тогтвортойн банкуудын ашигт ажиллагаа өсч, зарим

¹² WHD – (Western hemisphere countries), ED (emerging and developing economies) – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд, OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд(organization for economic cooperation and development), G20-их 20 орнууд (group of 20 countries), EUR- европын орнууд (European countries), APD – ази, номхон далайн орнууд(asian and pacific countries)

Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар нь авсан болно.

банкууд хувь нийлүүлсэн хөрөнгө болон хоёрдогч өглөгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн зэрэг нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг өсгөлөө.

Зураг 64: Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа (хувиар)




Банкны тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор Монголбанк, Сангийн яамнаас хамtran 2010 онд “Активыг ангилах, түүнд эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар активыг ангилах чанарын үзүүлэлтгүүд болон бусад холбогдох заалтуудыг илүү чангатгаж өгсөн.

Зээлийн чанарыг хэмжих гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн харьцаа нь бүс нутгийн түвшний үзүүлэлтгүүдтэй харьцуулахад харьцангуй бага хэмжээнд байна. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хэмжээ буурч байгаа нь нийт зээлийн өсөлттэй холбоотой юм.


Банкны салбарын ашигт ажиллагаа 2010 болон 2011 онд сайжирсан нь өөрийн хөрөнгийн өгөөж болон активын өгөөж өсөхөд голлон нөлөөллөө. Бусад бүс нутгуудтай харьцуулахад активын өгөөжийн хэмжээ 0.5-1.7 нэгжээр илүү байгаа нь банкуудын ашигт ажиллагаа өндөр байгааг харуулж байна.

Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт бүс нутгийн түвшингтэй харьцуулахад өндөр байгаа нь харагдаж байна. Доорх зургаас харахад Европын бүс нутагт хамгийн бага буюу 4.6 хувь байна. Зээлийн хүүгийн орлого, үнэт цаасны хүүгийн орлогын өсөлттэй холбоотойгоор банкуудын ашигт ажиллагаа сайжирч байгаа бөгөөд энэ нь өөрийн хөрөнгийн өгөөж, активын өгөөжийг нэмэгдүүлэхэд голлох нөлөөг үзүүлж байна.

Зураг 65: Активын өгөөжийн үзүүлэлт (хувиар)




Зураг 66: Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт (хувиар)




Тайлбар: Активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцоолоходоо жилийн хугацаанд дундажлан тооцооллыг хийсэн болно.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 213 тоот тушаалаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг банкуудад тогтоосон бөгөөд уг харьцаа нь хамгийн багадаа 18 хувь байхаар заасан бол мөн оны 11 дүгээр сард 25 хувьд хүргэх шийдвэр гарсан.

Зураг 67: Хөрөөх актив нийт активын харьцаа



Зураг 68: Хөрөөх актив БХЭҮ харьцаа



Нийт активт эзлэх хөрөөх активын хэмжээ бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад өндөр байгаа бол богино хугацаат эх үүсвэрт эзлэх хэмжээ харьцангуй бага байна. Зээлийн өсөлт өндөр байгаа нь дээрхи харьцааг буурахад нөлөөлжээ.

Шигтгээ 4: Динамик зээлийн эрсдэлийн сан

Дэлхий нийтийг хамарсан 2007 онд эхэлсэн санхүү, эдийн засгийн хямралын үр дагавараас дэлхийн улс орнууд, хянан шалгах эрх бүхий байгууллагуудын зүгээс хямрал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцолсон. Сүүлийн үед зарим улсуудад ихээхэн ашиглагдаж буй Макро-зохистой бодлогыг тухайн улс орны эдийн засгийн онцлогт тохируулан оновчтой хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар ихээхэн анхаарал хандуулж байна. Макро-мөнгөний бодлогыг, Микро-хяналт шалгалтын үйл ажиллагаатай үр ашигтайгаар хослуулан хэрэгжүүлэх, энэхүү хоёр зорилгыг хамтад нь хангах чадамж бүхий бодлогын хэрэгслийг бий болгох хэрэгцээ зайлшгүй тулгарч байгаа билээ. Эдгээр бодлогын хэрэгслүүдийн нэг нь Динамик буюу Мөчлөг сөрсөн эрсдэлийн сан юм.

Динамик эрсдэлийн сангийн тухай ойлголтыг анх Испанийн Төв банкнаас 2000 онд танилцуулж, тухайн үед нүүрлээд байсан хэт их зээлийн өсөлтийг тогтвортжуулах зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн. Тус улсад 1990-ээд оны дунд үеэс банкуудын хооронд хямд, бага хүйтэй зээлийн үйлчилгээгээр өрсөлдөх хандлага ихэссэнээр зээлийн хэмжээ огцом өсч, нийт зээл дэх чанаргүй зээлийн хувийн жин буурч эхэлсэн бөгөөд чанаргүй зээлд харгалзах зээлийн эрсдэлийн сангийн хувийн жин нь бусад OECD-ийн орнуудтай харьцуулахад хамгийн бага (1999 оны байдлаар) үзүүлэлттэйд тооцогдож байсан. Түүнчлэн тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт болон зээлийн эрсдэлийн сангийн хувийн хоорондын корреляцийн коэффициент нь 1991-1999 оныг хамрах хугацаанд дээрх орнуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан. Өөрөөр хэлбэл, тус улсын зээлийн эрсдэлийн сангийн хувь хэмжээ нь эдийн засгийн мөчлөгийг дагасан буюу эдийн засгийн өсөлтийн үед багасч, хямралын үед ихсэх шинжтэй болсоноос гадна, өсөлтийн үед зээлийн эрсдэлийн бодит үнэлгээг бууруулах, эрсдэл өндөртэй төсөлд зээл олгох үзэгдэл ихэсч байсан.

Иймд, банкуудаас олгосон зээлийг тайлан тэнцэлд цэвэр дүнгээр тусгахдаа бодит эрсдэлийн хэмжээг бууруулж эсвэл өсгөж тусгах зөрчлийг арилгах, нуугдмал шинжтэй байсан эрсдэлийн сангийн хэмжээг тайланд тусгуулах үүднээс динамик эрсдэлийн санг хэрэгжүүлж эхэлсэн.

Испанийн Төв банкнаас нэг талаас нуугдмал шинжтэй байгаа зээлийн эрсдэлийг бодитоор тайлан тэнцэлд тусгах, нөгөө талаас зээлийн өсөлтөд хамаарах эрсдэлийн сан байгуулалтын цаг хугацааны хоцрогдлыг арилгах зорилгоор Ерөнхий эрсдэлийн сан (General provision)-гийн оновчтой хэмжээг тооцоолох статистик загварчлалыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Динамик эрсдлийн сан нь тэдэнд зээлийн хэт өндөр өсөлтийг хязгаарлах, хямралын бус цагт түүнээс хамгаалах нөөц санг бүрдүүлэх боломжийг олгоно гэж үзсэн. Нийт эрсдэлийн санг i) Ерөнхий болон ii) Тусгай эрсдэлийн санд ангилсан байдал.

Ерөнхий эрсдэлийн сангийн эдийн засгийн утга санаа нь тухайн зээлийн зориулалт, эдийн засгийн салбар нь нуугдмал эрсдэлийг дагуулж байдал тул уг эрсдэлийг банкуудаас анх олгох зээлийн үнэлгээнд шингээх шаардлагатай гэсэн байр суурийг Испаний Төв банк баримталж эхэлсэн.

Зээлийн зориулалт, эдийн засгийн салбар болон ерөнхий эрсдэлийн түвшингээс хамаарч ерөнхий эрсдэлийн сангийн тооцоог 6 төрлийн зээлийн ангиллын хувьд ялгавартайгаар тогтоодог. Динамик эрсдэлийн санг нэвтрүүлэхэд бүртгэл, аудит, санхүүгийн тайлагнал, татварын хөнгөлөлттэй холбоотойгоор олон улсын стандартууд, хууль, журамтай үл нийцэх байдал үүсдэг. Испанийн загварыг шууд хэрэгжүүлэхэд сайн чанарын зээлийн эрсдлийн өгөгдлийн санг бий болгосон байх хэрэгтэй.

1997 оны хямралын дараа Азийн орнуудад активын эрсдэлийн сан байгуулах хувийг нэмэгдүүлэх, шаардлагыг нарийвчлах, олон улсын стандартад ойртуулах ажил эрчимтэй хийгдсэн.

Зүүн болон зүүн өмнөд Азийн тэргүүлэх эдийн засагтай орнуудад зээлийн эрсдэлийн санг салбар, санхүүгийн байдлаар нь ялгавартай байгуулдаг туршлага түгээмэл байна. Мөн энэ нь өмнөд Азийн орнуудад ч бий. Индонезид барьцаа хөрөнгийн өнөөгийн өртгийг цэвэршүүлсэн зээлийн үлдэгдэл дээр сан байгуулж болдог байна. Филиппинид эрсдэл bagatay хэвийн зээлд 1 хувиар, зээлийн анхны нөхцөлд өөрчлөлт оруулсан буюу бүтцийн өөрчлөлт хийгдсэн хэвийн зээлд 5 хувиар эрсдлийн сан байгуулдаг байна. Индонезийн банкууд барьцаа хөрөнгийн шинж чанарыг харгалзан өөр өөр хувиар эрсдлийн санг байгуулдаг. БНСУ-д картын болон орон сууцны зээлд бизнесийн зээлээс өндөр хувиар сан байгуулахыг банкуудаас шаарддаг байна. Мөн дээрх орнуудад зээлийн зэрэглэл, эрсдлийн үнэлгээнд тулгуурлан тусгай эрсдлийн сан байгуулдаг туршлагатай байна.

Азийн олон оронд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг авч хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхэлсэн байна. Япон улс дотоодын ерөнхий бүртгэлийн стандартыг олон улсын стандарттай нийцүүлэх ажлыг хийж байгаа бол Малайзад 2010 онд 39 дүгээр ОУНББС-ыг авч хэрэгжүүлжээ. Тайландад 2013 он гэхэд бүх банкууд зээлийн эрсдлийн санг байгуулахдаа 39 дүгээр ОУНББС стандартын дагуу хийдэг болохоор төлөвлөж байна.

Цөөнгүй Азийн улсууд олон улсын стандартыг зээлийн эрсдлийн сан байгуулахдаа мөрдөж ашигладаг. Жишээлбэл Хонг-Конг, Сингапур, Филиппин, БНСУ зэрэг улсууд 39 дүгээр ОУНББС-ыг бүрэн авч хэрэгжүүлсэн орнууд юм.

Монгол улсын хувьд зээлийн эрсдлийн санг 2010 онд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу байгуулж байна. Зээлийн болон активын чанарын 5 ангилал байдаг бөгөөд зээлийг хугацааны болон чанарын хүчин зүйлийг харгалзан ангилдаг. Монголбанкнаас активын эрсдлийн сангийн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, мөчлөг сөрсөн зээлийн эрсдлийн санг нэвтрүүлэх боломжийн талаар судалж байна.

3.1.10 Монгол улсын төсөв

Монгол улсын төсвийн нэгдсэн орлого ба тусlamжийн дүн 2012 оны эхний 8 сарын байдлаар 3125.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3582.6 тэрбум төгрөгт хүрч тэнцвэржүүлсэн төсвийн нийт тэнцэл 483.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 9: 2012 оны эхний 7 сарын улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)


	1. НЭГДСЭН ТӨСӨВ		2012 I-VIII		2012/2011, %
	Гүйцэтгэл	Хувийн жин	Гүйцэтгэл	Хувийн жин	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,757.0	100.0	3,125.0	100.0	113.3
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	40.7	1.5	25.5	0.8	62.6
НИЙТ ТЕНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,716.3	98.5	3,099.5	99.2	114.1
А. УРСГАЛ ОРЛОГО	2,705.0	98.1	3,088.5	98.8	114.2
I. ТАТВАРЫН ОРЛОГО	2,342.8	85.0	2,780.2	89.0	118.7
1 Орлогын албан татвар	526.1	19.1	544.5	17.4	103.5
2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	273.8	9.9	418.7	13.4	152.9
3 Өмчийн татвар	9.8	0.4	12.4	0.4	127.0
4 Дотоодын бараа, үйлчилгээний татвар	908.4	32.9	1,035.5	33.1	114.0
5 Гадаад худалдааны орлого	218.0	7.9	223.8	7.2	102.7
6 Бусад татвар	406.8	14.8	545.3	17.5	134.1
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	362.3	13.1	308.3	9.9	85.1
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	9.7	0.4	10.0	0.3	102.6
Б. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1.5	0.1	1.0	0.0	67.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,530.0	100.0	3,582.6	100.0	141.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,962.1	77.6	2,761.0	77.1	140.7
1. Бараа, үйлчилгээний зардал	869.9	34.4	1,197.2	33.4	137.6
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	25.8	1.0	63.3	1.8	245.5
3. Татаас бүшилжүүзг	1,066.5	42.2	1,500.6	41.9	140.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	427.7	16.9	779.9	21.8	182.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	140.2	5.5	41.6	1.2	29.7
ТЕНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	742.9		327.4		
ТЕНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	186.3		(483.1)		

Эх сурвалж: Төсвийн сарын гүйцэтгэл


Нийт орлого ба тусlamжийн дүн 3125.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 13.3 хувь буюу 368.0 тэрбум төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого ба тусlamжийн 98.8 хувийг бүрдүүлсэн урсгал орлого 14.2 хувь буюу 383.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Урсгал орлогын 90.0 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 18.7 хувь буюу 437.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2780.2 тэрбум төгрөгт хүрсэн бол татварын бус орлого 14.9 хувь буюу 54.0 тэрбум төгрөгөөр буурчээ.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 80.0 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татвар 19.2 хувь буюу 133.2 тэрбум төгрөг, тусгай зориулалтын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 2.7 хувь) 27.9 хувь 6.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол онцгой албан татвар (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 17.3 хувь) 6.4 хувь буюу 12.2 тэрбум төгрөгөөр буурсан нь автобензин, дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг тэглэсэнтэй холбоотой юм. Мөн гадаад худалдааны орлогын 99.9 хувийг бүрдүүлдэг импортын барааны албан татвар өнгөрсөн онд жилийн 74.5 хувиар өссөн ч энэ оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувь буюу 5.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 69: Нийт орлого ба туссламж



Зураг 70: Нийт зарлага ба цэвэр зээл



Төсвийн зарлага. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 41.6 хувь буюу 1052.6 тэрбум төгрөгөөр өсч 3582.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант сард урсгал зардал өмнөх оны мөн үеэс 40.7 хувь буюу 798.9 тэрбум төгрөгөөр өсч 2761.0 тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал 82.4 хувь буюу 352.2 тэрбум төгрөгөөр өсч 779.9 тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл 70.3 хувь буюу 98.5 тэрбум төгрөгөөр буурч 41.6 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн тус бүрээр нь үзвэл, бараа үйлчилгээний зардал (урсгал зардлын 43.4 хувь) өмнөх оны мөн үеэс 327.3 тэрбум төгрөг, татаас ба шилжүүлэг (урсгал зардлын 54.3 хувь) 434.1 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр (урсгал зардлын 2.3 хувь) 37.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

3.2 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

2011 оны сүүлч, 2012 оны эхнээс хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт саарснаас 2008/09 оны хямралын үед тогтвортой байсан Хятадын эдийн засгийн өсөлт буурч эхлээд байна. Хөгжингүй орнуудын санхүүгийн хямрал гүнзгийрч, түүхий эдийн томоохон хэрэглэгч Хятадын өсөлт саарч байгаа нь манай улсын экспортын гол түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж, цаашлаад экспортын орлогыг бууруулах эрсдэлтэй байна. Түүнчлэн дэлхийн санхүүгийн хямрал гүнзгийрвэл гадаадын хөрөнгө оруулалт буурч, эрчимтэй хөгжиж буй орнуудын бодит сектор, үйлдвэрлэлийг бууруулах эрсдэлтэй байна.

АНУ, Евро бүс 2013 онд эдийн засгийн хүндрэлээ давж чадах эсэх, Хятад улс гадаад эдийн засгийн сөрөг шокын хариуд оновчтой арга хэмжээ авч түүхий эдийн эрэлтийг сэргээх эсэхээс манай эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв шууд хамаарах юм. Иймээс болзошгүй эрсдэлийг урьдчилан харах, макро эдийн засгийн зөв бодлого явуулахын тулд гадаад эдийн засгийн байдлыг байнга ажиглаж, судалж байх явдал мөнгөний бодлогын шийдвэр гаргахад нэг чухал мэдээлэл болдог.

Дэлхийн эдийн засгийн ойрын ирээдүйн төлөвөөр дагнан хийсэн олон улсын санхүүгийн байгууллагуудын шинжилгээ, тайлангуудын үр дүнг нэгтгэн дор танилцуулж байна.

АНУ

Хувийн хэрэглээ ба үйлдвэрлэлийн салбарын өсөлтөөр тэтгэгдэж 2012 оны эхний улиралд АНУ-ын ДНБ 2 хувь өссөн байна. Өнгөрөгч оны сүүлийн улиралд эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр байсан нь хувийн хэрэглээг 2.7 хувь нэмэгдэхэд голлон нөлөөлсөн бол цаг агаарын тааламжтай байдал нь улирлын чанартай эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлжээ. Гэсэн хэдий ч 2012 оны 2 дугаар улиралд хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлт буурсан нь ДНБ-ий өсөлтийг бууруулж 1.7 хувьд хүргэсэн байна. Тодруулбал, орлогын түвшин хангалттай өсөөгүй, ажилгүйдлийн түвшин өндөр (8.3%), хэрэглэгчдийн баялаг болох үл хөдлөх хөрөнгийн үнэ 2006 оны оргил үеийнхээс 30 хувь доогуур байгаа зэрэг нь хувийн хэрэглээ, жижиглэнгийн худалдаанд сөргөөр нөлөөлсөөр байна. Инфляцийн түвшин 1.4 хувьд хүрч буусан боловч нэрлэсэн цалин 7 дугаар сарын байдлаар дөнгөж 1.3 хувиар нэмэгдсэнээр бодит цалин буурчээ. Түүнчлэн ажилгүйдлийн түвшинг цаашид нэмэгдүүлэхгүйн тулд хамгийн багадаа сар тутам 250 мянган шинэ ажлын байр бий болгох шаардлагатай байгаа хэдий ч сүүлийн 4-н сард дунджаар 87 мянган ажлын байр бий болгосон нь шинээр хөдөлмөрийн заход орж байгаа ажиллагсдыг ч ажлын байраар хангахад хүрэлцэхгүй тоо юм. Бизнес

эрхлэгчид хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн үйлдвэрлэлээ өргөжүүлэх сонирхолгүй байгаа нь Евро бүсийн хямрал, 2012 оны сүүлээр “Бушийн татварын хөнгөлөлт” хөтөлбөр дуусгавар болж, төсвийн зардал 2 их наяд ам.доллараар автоматаар буурах тул нийт зардал ДНБ-ий 4 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр буурснаар гадаад болон дотоод эрэлт буурна гэсэн хүлээлттэй холбоотой юм. 2012 оны 11-р сард ерөнхийлөгчийн сонгууль болох гэж байгаа нь конгресс төсвийн зардлын бууралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч чадахгүй хэмээн ажиглагчид үзэж байгаа юм. Гадаад эрэлт буурч эхэлсэн нь АНУ-ын аж үйлдвэрийн экспортын захиалга буурч 8 дугаар сард экспортын индекс 47¹³, нийт үйлдвэрлэлийн индекс 49.6 болж буурснаас харагдаж байна. Ийнхүү дэлхийн эдийн засгийн төлөв суд, дотоод эдийн засгийн өсөлт 2012 оны сүүлээр илүү буурах төлөвтэй байгаа тул хэрэглэгчид хувийн хэрэглээгээ нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчид үйлдвэрлэлээ өргөжүүлэх сонирхолгүй байгаа юм. Холбооны нөөцийн банкнаас эдийн засгийн өсөлтийг цааш сааруулахгүйн тулд шаардлагатай үед мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээ мэдэгдээд байгаа боловч Грек улс Европын холбооноос гарч, Евро бүсийн хямрал гүнзгийрэх тохиолдолд энэ арга нь үр дүнтэй байх эсэхэд ажиглагчид эргэлзэж байна. Тиймээс 2012 онд АНУ-н эдийн засаг 2.2 хувь өсч, 2.0 хувийн инфляцитай байхаар төлөвтэй байна.

Евро бүс

Евро бүсийн орнуудын өрийн хямрал, тэр дотроо Грек, Испани, Итали, Португаль зэрэг улсуудын санхүүгийн хямрал нь тус бүсийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж 2011 онд 1.5 хувийн өсөлттэй байсан эдийн засаг 2012 оны эхний улиралд огт өсөөгүй бол 2 дугаар улиралд 0.4 хувиар буурсан байна. Одоогоор Грекийн засгийн газрын нийт өрийн харьцаа хамгийн өндөр буюу ДНБ-ний 132 хувьтай тэнцэхээр байна. Грек улс бондын өрийг тэглэж Евро бүсээс гарсан тохиолдолд тус улсын бондыг эзэмшигч банкууд их хэмжээний алдагдал хүлээж, хөрөнгийн урсгал Грекээс гадна өрийн хямралтай байгаа Итали, Испани зэрэг улсуудыг хамарч, тэдгээрийн бонд үнэгүйдэх, Евро бүсийн банкууд мөнгөн хөрөнгийн дутагдалд орж улмаар хямрал банк санхүү, бодит секторт дамжин халдварлах эрсдэлтэй байгаа юм. Иймд Европын Холбооны Комисс, Европын Төв банк болон ОУВС Грекийг Евро бүсээс гаргахгүй байх, өрийн хямралыг давах, банкуудыг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулахгүй байх, зээлийн тасалдаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэд хэдэн арга хэмжээг аваад байна. Тухайлбал, өнгөрөгч оны 12 дугаар сараас эхлэн 2 удаа Евро бүсийн 800 орчим банкуудад нийт 1018.5 тэрбум еврогийн урт хугацаатай бага хүйтэй зээлийг Европын Төв банкнаас олгосон нь Италийн өрийн дарамтыг бууруулж бондын хүүг 5.19 хувьд хүргэх ач холбогдолтой байлаа. Түүнчлэн Европын холбооны комисс, Европын Төв банк, ОУВС-аас Грекийн

¹³ Индекс 50 үед 0 хувийн өсөлттэй байна.

Засгийн газрын хугацаа нь тулсан өрийг барагдуулах, банкны салбарыг мөнгөн хөрөнгөөр хангах зорилгоор 130 тэрбум еврогийн туслалцаа үзүүлж, үүний хариуд тэтгэвэр тэтгэмж, цалингийн зардлыг бууруулах, төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх зэргээр төсвийн зардлыг танах нөхцлийг тавьсан. 2012 оны 2 дугаар улирлын байдлаар Грекийн хөрөнгө оруулалт жилийн 21.3 хувь, хувийн хэрэглээ 7.5 хувь тус тус буураад байгаа ба цаашид хэрэгжүүлэх төсвийн хатуу бодлого нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд Грек цаашид энэ байдлаар удаан тэсвэрлэхгүй, хамгийн эртдээ 2013 оны эхэнд засгийн газрын өрийг тэглэж, Евро бүсээс гарснаар эдийн засаг нь 8.4 хувиар буурна хэмээн Roubini Global Economics-ийн эдийн засагчид үзэж байна. Грекээс гадна Испани, Италийн засгийн газрын өр сүүлийн саруудад ДНБ-ний 120 хувийг давж, бондын хүү тогтмол 7 хувиас дээгүүр байгаа нь Евро бүсэд бас нэгэн эрсдлийг бий болгоод байна. Испанийн банкуудыг хөрөнгийн дутагдлаас гаргах зорилгоор энэ оны 5 дугаар сард 100 тэрбум еврогийн тусламж олгохоор болсон юм. Хэдий ОУВС 100 тэрбум евро хангалттай гэж тооцсон хэдий ч иргэд, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид хангалтгүй, хямрал гарцаагүй болно гэсэн хүлээлттэй байгаа тул Испани хямралд өртөж, 2012 онд эдийн засаг 2.1 хувиар буурна хэмээн Roubini Global Economics таамаглаж байна. Евро бүсийн бусад орнуудын эдийн засгийн өсөлт 2 дугаар улиралд мөн саарч, цаашид буурах төлөвтэй байгаа тул Европын Төв банкнаас мөнгөний төлөвийг сулруулах бодлого хэрэгжүүлж байгаа боловч төсвийн хатуу бодлогын эсрэг хангалттай сул байж чадахгүй байгаа юм. Одоогоор Европын Төв банкнаас хямралыг давахын тулд евро-бонд гаргах, өрийн хямралтай орнуудын Засгийн газруудын өрийг хамтран төлөх санал гаргаад байгаа боловч энэ саналыг Герман улс хатуу эсэргүүцэж байгаа юм. Цаашид бодлогын ямар арга хэмжээ авах, хэрхэх тухай тодорхой шийдэлд хүрч чадаагүй байна. Иймд Грек болон Испанийн байдал илүү хүндрээгүй тохиолдолд хамгийн сайндаа Евро бүсийн эдийн засаг 2012 онд-0.35 хувь, 2013 онд 1 хувь өснө хэмээн Блүүмберг таамаглаж байгаа бол дээрх 2 улс Евро бүсийг орхивол 2012 онд 0.5 хувь, 2013 онд 0.4 хувиар тус тус унах тооцооллыг зарим судалгааны байгууллагаас хийгээд байна.

Хятад

Хятадын эдийн засгийн өсөлт 2012 оны эхний улиралд 8.1 хувь байсан бол 2 дугаар улиралд хүлээгдэж байсан 7.7 хувиас бага зэрэг доогуур буюу 7.6 хувь болж буурсан байна. Өсөлт ийнхүү саарахад дараахи гадаад ба дотоод хүчин зүйлс нөлөөлжээ.

2009 оны хямралаас хойш АНУ-н эдийн засаг маш удаан сэргэж байгаа, Евро бүс хямралд орсон зэрэг нь Хятадын гадаад худалдааны эрэлтийг бууруулахаас гадна дотоод эдийн засагт орох ГШХО-д сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал 2012 оны эхний 7 сарын байдлаар экспорт 7.8 хувь, импорт 5.5 хувь өсч худалдааны илүүдэл

94.1 тэрбум ам долларт хүрээд байна. Цаашид 2012 онд экспорт 8 хувь, импорт 10 хувь тус тус өснө хэмээн Рубинигийн судлаачид таамаглаж байна. Энэ нь 2011 онтой харьцуулахад маш бага өсөлт юм. (*Экспорт 20.4 хувь, импорт 24.9 хувиар өсч худалдааны илүүдэл 156.7 тэрбум ам.доллар байсан*). Мөн Хятадын эдийн засаг 2011 онд 9 хувь, 2010 онд 17 хувиар тус тус өсч байсан энэ оны эхний хагаст 3 хувиар буурчээ. Энэ нь нэг талаас дэлхийн эдийн засгийн өсөлт саарснаас нийт гадаад шууд хөрөнгө оруулалт татарч байгаа, нөгөө талаас Хятадын өсөлт буурч, эрсдэл нэмэгдэж байгаагаас иргэд хадгаламжаа доллар луу шилжүүлэх, эсвэл хилийн чанадад байршуулах болсон тул гадаад валютын дотогшлох урсгал татарсантай холбоотой гэж Рубинигийн судлаачид үзэж байна.

Орон сууцны үнэ ихээр өсч, аливаа сөрөг шокын үед “тэсэрч” эдийн засгийг хямралд оруулах эрсдэлтэй үнийн “хөөсрөл” зах зээлд үүссэн байсан тул энэ оны эхний улиралд Хятадын Засгийн газар орон сууцны үнийг бууруулах, орон сууцны захад шинэчлэл хийхээр ажилласан. Орон сууцны үнэ сүүлийн саруудад тогтмол унаж байгаагаас үл хөдлөх хөрөнгө нь Хятадын иргэдийн дунд хөрөнгөө байршуулах ашигтай бизнес байхаа болж эрэлт нь буурсан тул шинээр эхэлж буй барилгын ажил 2012 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буурчээ. Үүний дунд 2011 онд 30.2 хувь байсан орон сууцны хөрөнгө оруулалтын өсөлт 2012 оны эхний хагаст 13 хувь болж буурчээ. Түүнчлэн мөнгөний бодлогоор хөрөнгийн захыг сайжруулж өмнөх байдалд нь хүргэх боломжгүй тул яваандаа ДНБ-ний 4 хувийг бүрдүүлдэг орон сууцны барилгын сектор зогсонги байдалд орох эрсдэлтэй байна.

Ийнхүү гадаад ба дотоод хүчин зүйлийн улмаас өсөлт саарч буй тул Хятадын Засгийн газраас өсөлтийг дэмжих бодлогын арга хэмжээг авч эхлээд байна. Орон нутгийн засаг захиргааны өр 17.5 триллион юаньд хүрч, төв засгийн газар нь их хэмжээний өрийг өөр дээрээ авах сонирхолгүй байгаа тул хөрөнгө оруулалтыг дахин хиймлээр өсгөх, дэд бүтцийн томоохон төслийг хэрэгжүүлэх боломжгүй болоод байна. 2009 онд өсөлтийг дэмжихийн тулд хөрөнгө оруулалтыг хэт нэмэгдүүлсний улмаас үр ашиггүй төслүүд банкны секторын чанаргүй зээл, орон нутгийн засаг захиргааны өрийг нэмэгдүүлж эдийн засагт хүндрэл авчирсан тул энэ удаа өсөлтийг хөрөнгө оруулалтаар бус, хувийн хэрэглээгээр дэмжих бодлогыг баримталж байна. Энэхүү бодлогын хүрээнд 6, 7 дугаар саруудад зээл, хадгаламжийн хүүг 2 удаа бууруулан 6 хувь, 3 хувьд тус тус хүргэсэн. Түүнчлэн заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг бууруулж зээл олголтыг нэмэгдүүлэхийг хичээж байна. Мөн зарим хэрэглээний бараанд татаас ч олгож байгаа юм. Инфляцийн түвшин доогуур байгаа нь мөнгөний бодлогыг сулруулах орон зайд илүү олгож байна. Тухайлбал, сүүлийн саруудад инфляци тогтмол буурч байгаа бөгөөд 6 дугаар сард 2.2 хувь байсан бол 7 сард 1.8 хувь болж буурсан байна. Мөнгөний бодлогын төлөвийг сулруулсны

дээр татварын дараах орлого ёсч, шатахууны үнэ буурсан тул хувийн хэрэглээ ёсөх боломжтой хэмээн эрх баригчид үзэж байгаа юм. Гэвч иргэдийн дийлэнх хөрөнгөө байршуулсан орон сууцны үнэ тогтмол буурч байгаа тул хувийн хэрэглээ нь гадаад сөрөг шокын нөлөөг давж ёсөлтийг тэтгэх хэмжээнд хүртэл хангалттай ёсөхгүй байх магадлал өндөр байна. 2012 оны хувьд, Хятадын эдийн засгийн ёсөлт Засгийн газрынх нь төлөвлөсөн 7.5 хувьд дөхнө хэмээн судлаачид үзэж байна.

Орос

2011 онд дэлхийн зах зээл дээрх газрын тос, байгалийн хийн үнэ өндөр байж газар тариалангийн арвин ургац хураан авсан нь ОХУ-н эдийн засгийн ёсөлтийг тэтгэж 4.3 хувьд хүргэжээ. 2012 оны эхний улиралд түүхий эдийн үнэ өндөр түвшингээ хадгалж, хувийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 8 хувь, засгийн газрын зардал 40 хувь ёссөн нь эдийн засгийн ёсөлт 4 хувьд хүрэхд голлон нөлөөлжээ. Харин энэ оны 2 дугаар улирлаас эхлэн гадаад эдийн засгийн төлөвийн сөрөг нөлөө ОХУ-д мэдрэгдэж эхэлсний дээр энэ онд газар тариалангийн ургац тааруу байх төлөвтэй тул цаашид ёсөлт саарч 2012 онд 3.6 хувь, 2013 онд 3.5 хувь болно хэмээн судлаачид таамаглаж байна. Евро бүсийн хямрал гүнзгийрч, Хятадын ёсөлт саарч байгаа нь ОХУ-ын эдийн засагт худалдааны ба хөрөнгийн гэсэн 2 сувгаар дамжин нөлөөлж байна. Нэгдүгээрт, Евро бүс ба ОХУ-ын худалдааны хамгийн том түнш Хятадын ёсөлт саарч, эрэлт буурснаар дэлхийн зах зээл дээрх газрын тос, байгалийн хийн үнэ 4 дүгээр сараас эхлэн тогтмол буураад байна. Энэ нь нийт экспортын дийлэнх нь эдгээр түүхий эдүүдээс бүрддэг ОХУ-ын гадаад худалдаанд шууд нөлөөлж байгаа юм. Түүнчлэн оны эхэнд хувийн хэрэглээ өндөр ёссөн нь импортыг нэмэгдүүлж худалдааны илүүдлийг бууруулаад байна. Хоёрдугаарт, хөгжингүй орнуудын ёсөлт саарч, бизнесийн орчны эрсдэл нэмэгдэж байгаагаас хөрөнгө оруулагчид аль болох эрсдэл багатай бүс, салбарт хөрөнгөө шилжүүлж эхэлсэн. Үүний дунд ОХУ-аас хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэж байна. Ийнхүү экспортын орлого буурч, гадаад хөрөнгө оруулалт татарч байгаа нь хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлж дотоод эдийн засагт хийгдэх хөрөнгө оруулалтыг бууруулан рублийн ханшийг сулруулах эрсдэлтэй. Дотоод хөрөнгө оруулалт буурснаар аж үйлдвэрийн салбарын ёсөлт саарч, цалин хөлс буурах тул хувийн хэрэглээ оны эхний ёсөлтөө хадгалж чадахааргүй байна. Харин рублийн ханшийн сулрах дарамтын эсрэг Төв банк одооноос интервенци хийж эхэлсэн боловч цаашид инфляци нэмэгдэх тохиолдолд мөнгөний төлөвийг сулруулах орон зайд олгохооргүй байна. Тодруулбал, газар тариалангийн ургац тааруу, аж үйлдвэр саарах төлөвтэй байгаагаас оны сүүл рүү инфляци нэмэгдэж 5 хувь, 2013 онд 7.4 хувьд хүрнэ хэмээн зарим судалгааны байгууллагууд таамаглаж байна. Иймд мөнгөний төлөв 2012 онд ерөнхийдөө хатуу, төсвийн төлөв ялимгүй сүл байх боловч оны сүүлийн хагаст ёсөлтөд үзүүлэх нөлөө нь бага байхаар байна.

Эрчимтэй хөгжиж буй Ази

Барууны эдийн засаг хямарч, гадаад эрэлт буурах нь экспортоос ихээхэн хамааралтай хөгжиж буй Азийн орнуудад худалдааны сувгаар дамжин богино хугацаанд сөргөөр нөлөөлөх боловч эдгээр улсын эдийн засгийн суурь үндэс нь бат бөх, макро эдийн засгийн бодлого нь зохистой явж буй тул урт хугацаанд тогтвортой өсөхөөр байна. Тухайлбал, улсын нийт өр (засгийн газрын болон хувийн секторын өр)-ийн хэмжээ бага, инфляцийн түвшин доогуур байгаа тул богино хугацааны сөрөг шокын хариуд мөнгө, сангийн тэлэх бодлого хэрэгжүүлэх боломжтой юм. Түүнчлэн Хятадын хөдөлмөрийн хөлс нэмэгдэж байгаагаас цаашид хөдөлмөрийн хөлс доогуур Вьетнам, Камбож зэрэг орнууд руу үйлдвэрлэлээ шилжүүлж магадгүй тул эдгээр улсуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ хэмээн ажиглагчид үзэж байна. 2011 онд 4.5 хувийн өсөлттэй байсан ASEAN-ны орнуудын эдийн засаг дотоод эрэлтээр тэжээгдэн 2012 онд 5.2 хувь, 2013 онд 5.6 хувиар тус тус өсөхөөр байна. Энэ нь уг бүсийг 2012 онд өсөлт нь сааралгүй нэмэгдэх цорын ганц бүс болгож байгаа тул гадны хөрөнгө оруулагчид ASEAN-ны бүсэд анхаарлаа хандуулснаар хөрөнгийн урсгал уг бүсийг чиглэнэ хэмээн судлаачид үзэж байна.

Латин Америк

Евро бүсийн үргэлжилсэн хямрал, АНУ-ын эдийн засгийн сул өсөлт нь Латин Америкийн орнуудын экспортын эрэлтийг бууруулж байгаа нь эдийн засгийн өсөлт нь саарч 2012 онд 3.1 хувьд хүргэхээр байна. Латин Америкийн эдийн засаг Хятад уруу хийдэг түүхий эдийн экспорт, гадны хөрөнгө оруулалтаас их хамаардаг тул түүхий эдийн үнэ унах, хөрөнгө оруулалтын орчин муудах зэргээс өсөлт нь саарах эрсдэл байгаа юм. Гэсэн хэдий ч эдийн засгийн суурь сайтай тул 2013 оноос дотоод эрэлт, Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагаатай орнууд (OECD)-ын эрэлт сэргэснээр уг бүсийн өсөлт сэргэж 2013-2016 онд дунджаар 4.1 хувь байхаар байна. Тодруулбал, OECD-н орнуудын хүү түүхэндээ хамгийн доод түвшинд хүрээд байгаа нь хөрөнгө оруулагчдыг Латин Америкиг чиглэхэд түлхэц болж байна. Үүний зэрэгцээ ДНБ-нд эзлэх гадаад өрийн хэмжээ бага, гадаад албан нөөцийн хэмжээ сүүлийн жилүүдэд өндөр өсч байгаа нь хөрөнгийн огцом гадагшлах урсгалын үед эдийн засагт богино хугацааны валютын хямрал үүсэх эрсдлийг бууруулж байгаа юм. Харин бүс дотроо хамгийн томд тооцогддог Бразилийн эдийн засаг мөчлөгийн уналтад орж 2 хувийн өсөлттэй байх тул уг бүсийн өсөлтийг доош нь татахаар байна. Эдийн засгийн өсөлтөө дэмжихээр Бразилийн Засгийн газар энэ онд мөнгөний төлөвийг сулруулна хэмээн ажиглагчид таамаглаж байгаа бөгөөд энэ нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг сулруулж экспортыг дэмжих ач холбогдолтой байх юм. Дэлхийн зах дээрх түүхий эдийн үнэ буурч байгаа тул мөнгөний бодлогыг сулруулахад инфляцийн дарамтыг нэмэгдүүлэхгүй хэмээн таамаглаж байна.

Дүгнэлт

Евро бүсийн өрийн хямралаас гадна дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр АНУ болон Хятад улсын эдийн засгийн өсөлт саарч эхлээд байна. АНУ, Хятадын Засгийн газраас богино хугацаанд өсөлтийг дэмжих оновчтой арга замыг олж чадахгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн ойрын ирээдүйн төлөвийг сулруулах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хөгжингүй орнуудын өсөлт саарч байгаа нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийг унагаж, экспортлогч орнуудын гадаад худалдааны орлогыг бууруулж байгаа боловч Азийн эрчимтэй хөгжиж буй улсууд болон Латин Америкийн улсуудын (Бразилаас бусад) гадаад ба дотоод өрийн хэмжээ бага, эдийн засгийн үндэс суурь нь сайн байгаа тул ойрын ирээдүйд өсөлт нь саарахааргүй байна. Нөгөө талаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хүүгийн зөрүү, хөдөлмөрийн хөлсний ялгаа зэрэг нь гадны хөрөнгө оруулагчдыг ихээр татаж, тус бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих төлөвтэй.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Бодит ДНБ, салбараар, тэрбум төгрөг	37
Хүснэгт 2: Хүртээмжтэй өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлс	39
Хүснэгт 3: Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: 2012 оны 2 дугаар улирал	52
Хүснэгт 4: Гадаад худалдааны эргэлт (сая ам.доллар)	61
Хүснэгт 5: Экспортын барааны гүйцэтгэл	62
Хүснэгт 6: Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)	64
Хүснэгт 7: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2012 оны 2-р улирлын байдлаар	68
Хүснэгт 8: Гадаад өр	69
Хүснэгт 9: 2012 оны эхний 7 сарын улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)	83

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Эдийн засгийн өсөлт, өсөлтийн задаргаа (эрэлт талаасаа)	38
Зураг 2: Бодит ДНБ-ий бүтэц, 2011 оны эхний хагас жилийн байдлаар	38
Зураг 3: Эдийн засгийн өсөлт	40
Зураг 4: Дотоодын нийт бүтээгдэхүүн ба Үндэсний нийт орлого	40
Зураг 5: Ажилгүйдлийн түвшин	40
Зураг 6: Жини индекс	40
Зураг 7: Ядуурал ба Эдийн засгийн өсөлт	41
Зураг 8: Ядуурлын мэдрэмж	41
Зураг 9: ХҮИ-ийн жилийн өөрчлөлт	42
Зураг 10: ХҮИ-ийн жилийн өөрчлөлт, бүлгээр	42
Зураг 11: Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа, бүлгээр	43
Зураг 12: Түүхий эдийн үнийн индекс (2010=100хувь)	45
Зураг 13: Түүхий эдийн үнийн өсөлт (%)	45
Зураг 14: Жилийн инфляцийн төсөөлөл	46
Зураг 15: Улирлын зохицуулалт хийгдсэн M1, M2 мөнгөний жилийн өсөлт ба хүнсний бус инфляци	50
Зураг 16: Бодит M2 мөнгөний илүүдэл (дутагдал) болон бодит M2 мөнгөний зөрүү	51
Зураг 17: Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа	55
Зураг 18: Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбараар	56
Зураг 19: Зээлийн өсөлтийн задаргаа, ДНБ-ий салбараар	56
Зураг 20: Зээлийн бүтэц, ДНБ-ий салбараар	57
Зураг 21: Зээлийн хүү	57
Зураг 22: Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханшийн хөдөлгөөн	58
Зураг 23: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн өөрчлөлт	58
Зураг 24: Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш	59
Зураг 25: Бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлтийн бүтэц	59
Зураг 26: Гадаад валютын цэвэр урсгал	59
Зураг 27: Гадаад валютын орох урсгалын бүтэц (2012 оны эхний 8 сар)	59
Зураг 28: Экспорт, импортын өсөлтийн хурд (3 сарын дунджаар)	61
Зураг 29: Валютын төлбөртэй худалдаа	61
Зураг 30: Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт	61
Зураг 31: Экспортын өөрчлөлт дэх үнийн болон тоо хэмжээний нөлөөлөл	62
Зураг 32: Лондонгийн металлын бирж дээрх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ	63
Зураг 33: Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ, сараар	63
Зураг 34: Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ	65
Зураг 35: Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/	65

Зураг 36: Төлбөрийн тэнцэл	65
Зураг 37: Урсгал тэнцэл	65
Зураг 38: Барааны гадаад худалдаа.	66
Зураг 39: Үйлчилгээний гадаад худалдаа.	66
Зураг 40: Санхүүгийн данс	67
Зураг 41: Гадаад валютын цэвэр нөөц	67
Зураг 42: Гадаад актив	68
Зураг 43: Гадаад пассив	68
Зураг 44: Гадаад өрийн үлдэгдэл	69
Зураг 45: Хөрвөх активын динамик	70
Зураг 46: Эх үүсвэрийн динамик	70
Зураг 47: Хөрвөх активын өөрчлөлт	70
Зураг 48: Эх үүсвэрийн өөрчлөлт	70
Зураг 49: Хөрвөх чадварын үзүүлэлтүүд	70
Зураг 50: Зээлийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)	71
Зураг 51: Зээлийн үлдэгдэл ЭЗ-ын салбараар (хувиар)	72
Зураг 52: Гол салбаруудын зээлийн динамик (тэрбум төгрөгөөр, улирлаар)	72
Зураг 53: Эрсдэлийн сан ба зээлийн хамаарал (тэрбум төгрөгөөр)	72
Зураг 54: Чанаргүй зээл болон эрсдэлийн сан (тэрбум төгрөгөөр)	73
Зураг 55: Гол салбаруудын чанаргүй зээл (хувиар).	73
Зураг 56: Хөрөнгийн бүтэц (хувиар)	74
Зураг 57: Харилцах, хадгаламжийн динамик (тэрбум төгрөгөөр)	74
Зураг 58: Эх үүсвэрийн бүтэц (хувиар)	75
Зураг 59: Зээлийн эрсдэлийн стресс тест	76
Зураг 60: Хөрвөх чадварын эрсдэлийн стресс	76
Зураг 61: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	77
Зураг 62: Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	78
Зураг 63: НЗӨХ зохистой харьцаа	78
Зураг 64: Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа (хувиар)	79
Зураг 65: Активын өгөөжийн үзүүлэлт (хувиар)	80
Зураг 66: Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт(хувиар)	80
Зураг 67: Хөрвөх актив нийт активын харьцаа	80
Зураг 68: Хөрвөх актив БХЭҮ харьцаа	80
Зураг 69: Нийт орлого ба тусламж	84
Зураг 70: Нийт зарлага ба цэвэр зээл	84

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1: Эдийн засгийн өсөлтийн боломжийг иргэдэд хүргээмжтэй болгох нь	38
Шигтгээ 2: Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ	51
Шигтгээ 3: Мэдрэмтгий байдлын шинжилгээ (стресс тест).	76
Шигтгээ 4: Динамик зээлийн эрсдэлийн сан	81

